




ДАСАН ЗОХИЦОХ
ИНТЕГРАЦИЛАЛЫН ДАМЖАА

Чех Улсад тавтай морилно уу



ЧЕХ УЛСАД ТАВТАЙ МОРИЛНО УУ

Чех Улсад шинээр ирж буй гадаадын
иргэдэд зориулсан мэдээлэл



MINISTERSTVO VNITRA
ČESKÉ REPUBLIKY



Чех Улсад шинээр ирж буй гадаадын
иргэдэд зориулсан товхимол

ЧЕХ УЛСАД ТАВТАЙ МОРИЛНО УУ



MINISTERSTVO VNITRA
ČESKÉ REPUBLIKY



Гадаадын иргэдийг Чех Улсад дасан зохицоход нь дөхөм болох зорилготой энэхүү төслийг БНЧУ-ын Дотоод хэргийн яамнаас санхүүжилж байгаа болно. Төслийг “Слово 21” нийгэмлэг хэрэгжүүлж байна.

Энэхүү товхимлыг гуравдагч орны буюу Европын Холбооны гишүүн бус орнуудын иргэдэд зориулсан дасан зохицох интеграцчилалын дамжаанд дагалдах материал болгон ашиглана.

Гадаадын иргэд Чех Улсад оршин суух тухай 326/1999 тоот хуульд ямар нөхцөлд гадаадын иргэд дасан зохицох интеграцчилалын дамжаанд заавал хамрагдах үүрэгтэйг тодорхой заасан байдаг.

Чех Улсад амьдарч, ажиллаж буй гадаадын иргэдэд тус улсад оршин суухтай холбоотой эрх, үүргийн талаар мэдээлэл өгөхөөс гадна чех оронтой танилцах, баримжаа олж авахад нь туслахын зэрэгцээ учирч болзошгүй нийгмийн сөрөг үзэгдлийн талаар урьдчилан анхааруулахад энэхүү дамжааны гол зорилго оршино. Дамжаанд оролцогчдод зөвхөн ерөнхий мэдээлэл өгнө. Гадаадын иргэдэд учирч буй хүндрэл бэрхшээл нь олон тохиолдолд нэлээд ярвигтай байдаг тул багш хувийн асуудлаар зөвлөгөө өгдөггүй, өгөх ч боломжгүй юм. Энэхүү товхимолд тулгарсан асуудлаар үнэ төлбөргүй зөвлөгөө, үйлчилгээ авахаар ямар байгууллагад хандаж болох тухай мэдээлэл багтсан болно.

Танд зөвлөгөө, туслалцаа хэрэгтэй болох тохиолдолд Чех Улсын аймаг бүрт үйл ажиллагаагаа явуулдаг төрийн бус байгууллагууд (ТББ) эсвэл интеграцчилалын төвүүдэд (Гадаадын иргэдийн интеграцчилалыг дэмжих төв) нэрэлхэлгүй хандахыг зөвлөж байна. Эдгээр байгууллагуудын ажилтнууд нь уг товхимолд багтсан сэдэв бүрээр нийгмийн болон хууль зүйн зөвлөгөө үнэ төлбөргүй өгөхөөс гадна чех хэлний дамжаа, Чех Улсад амьдрахад хэрэг болох бүхий асуудлаар нийгэм, соёлын дамжаа зохион байгуулж, албан газартай харилцах, албан газарт биеэрээ очих, эмчид үзүүлэх, сургуультай харилцах үед хамт явах, орчуулах зэрэг үйлчилгээ үзүүлдэг. Танд зөвлөгөө, туслалцаа хэрэгтэй болох тохиолдолд хүссэн төрийн бус байгууллагадаа утсаар хандах боломж нээлттэй.

Гадаадын иргэдийн интеграцчилалын төвүүд нь танд тулгарсан асуудлаа шийдэхийн тулд ямар албан газарт хандах тал дээр зөвлөгөө өгөх, чех хэлний дамжаа санал болгох, зөвлөгөө, орчуулга зэрэг олон төрлийн бусад үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлдэг. Интеграцчилалын төвүүд бүгд интернетэд холбогдсон байдаг тул интернет хэрхэн ашиглах талаар ажилтнууд танд зөвлөж, тусална.

Интеграцчилалын төв, зарим ТББ-ын холбоо барих утас, хаяг зэрэг мэдээллийг энэхүү товхимлын **Холбоо барих** хэсгээс үзнэ үү.

© “Слово 21” нийгэмлэг, 2023

Бүх эрх хуулиар хамгаалагдсан. “Слово 21” нийгэмлэгийн бичгээр үйлдсэн зөвшөөрөлгүйгээр уг товхимлыг бүрнээр нь болон хэсэгчлэн цахим, хэвлэмэл ямарваа нэгэн хэлбэрээр олшруулах, хувиран тараахыг хориглоно.

Засан шинэчилж долоо дахь удаа хэвлэв.

ISBN 978-80-88301-36-3

ГАРЧИГ

Өмнөх үг.....	5
Таны хүрэлцэн ирсэн улсын тухай.....	6
Чех Улс дахь гадаадын иргэдийн шилжин суурьшилт, интеграцчилалын түүхээс.....	13
Чех Улсад оршин суух тухай.....	16
Боловсрол, сургууль, гадаадад эзэмшсэн боловсролыг хүлээн зөвшөөрөх.....	31
Хөдөлмөр эрхлэлт.....	42
Бизнес эрхлэлт.....	56
Эрүүл мэндийн үйлчилгээ, эрүүл мэндийн даатгал.....	67
Нийгмийн хангамж, нийгмийн хангамжийн тогтолцоо.....	75
Байр.....	79
Гэр бүл, эрх тэгш байдал, хүүхдүүд.....	85
Зөвлөмж.....	93
Чехүүдийн өдөр тутмын амьдралаас.....	97
Бусад чухал мэдээлэл.....	103
Холбоо барих.....	108

ӨМНӨХ ҮГ

Эрхэм анд найз нөхдөө,

Та бүхэн Чех Улсад тавтай морилно уу.

Сайн мэдэхгүй шинэ улс оронд амьдралаа дахин эхнээс нь товхиуулна гэдэг амаргүй даваа болохыг бид сайн ойлгож байна. Тийм болохоор Чех Улсад ирээд удаагүй байгаа та бүхэнд зориулан юун түрүүнд манай орны талаар анхан шатны мэдээлэл өгөх, учирч болзошгүй бэрхшээл хүндрэлийг даван туулахад тань туслахыг хүсч байгаа билээ. Та бүхний хүлээх эрх үүргийг танилцуулахаас гадна өдөр тутмын амьдралын асуудлаа хэрхэн шийдэх, учирч болзошгүй эрсдэлийн талаар анхааруулж түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх мэдээллийг өгөх дөрвөн цагийн угтах дамжааг та бүхэнд зориулан бэлтгэсэн юм.

Сургалтын явцад гарах кино нь Чех Улсын газар нутаг, байгал орчин, уур амьсгал, зан заншил, хүмүүсийн хоорондын харьцааны талаар өгүүлэх бөгөөд харин товхимол нь уг дамжааны сургалтын дагалдах материал болж байгаа юм. Товхимолд дамжааны үеэр танилцуулсан мэдээллийн тойм орсноос гадна ямар нэгэн асуудал үүссэн үед хандаж болох байгууллага, нэн ялангуяа төрийн бус байгууллагууд, интеграцчилалын төвүүдийн хаягийн жагсаалт багтсан болно. Тэндэхийн ажилтнууд танд туслах, зөвлөгөө өгөхөөс гадна шаардлагатай үед албан газраар өөрийн биеэр дагуулж явах зэрэг үнэ төлбөргүй тусалцаа үзүүлэхэд бэлэн байдаг. Тийм болохоор ямар нэгэн асуудал, бэрхшээл тулгарах ахул энэ хүмүүст цаг алдалгүй хандахыг зөвлөө. Та бүхэн ийм таатай боломжийг алдалгүй ашиглаарай.

Та бүхэн өөрсдийн ажиллаж амьдрах орноор манай Чех Улсыг сонгож авсан явдалд бид сэтгэл хангалуун байна. Ингээд та бүхнийг Чех Улсад өөрийн нутаг мэт идээшин дасаж, манай нийгмийн амьдралд идэвхтэй оролцоно гэдэгт итгэж байна.

Та бүхний цаашдын амьдралд сайн сайхныг хүсэн ерөөе.

Чех Улсад тавтай морилно уу.

Чех Улс дахь гадаадын иргэдийн
интеграцчилалын зохицуулагч
БНЧУ-ын Дотоод хэргийн яамны
Орогнол, шилжин суурьшилтын газрын хамт олон



ТАНЫ ХҮРЭЛЦЭН ИРСЭН УЛСЫН ТУХАЙ

Прага хотын Тыны сум, Одон орны цаг




ЧЕХ УЛС

Чех Улс нь Герман, Польш, Словак, Австри улстай хиллэдэг Төв Европод оршдог улс.

Чехословак Улс задарснаар 1993 оны 1 сарын 1-ний өдөр Бүгд Найрамдах Чех Улс үүсэн байгуулагдсан. Чех Улс нь 1999 оны 3 сарын 12-ны өдөр НАТО-д, 2004 оны 5 сарын 1-ний өдөр Европын Холбоонд гишүүнээр элсэж, 2007 оны 12 сарын 21-ний өдөр Шенгений орон болсон.

Чех Улс 10 гаруй сая хүн амтай. Нийслэл Прага хотод 1 200 000 орчим хүн амьдардаг. Бусад том хотуудын тоонд Брно, Острава, Пльзень, Либерец, Оломоуц, Усти над Лабем, Храдец Кралове, Ческе Будейовице, Пардубице зэрэг хотууд орно. Чех Улсын албан ёсны хэл нь чех хэл юм.

Чех Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд 6 000 гаруй суурин газар бүхий өөрөө удирдах 14 аймагт хуваагдана. Хот, тосгон, суурин газрын захиргаа нь иргэдийн байр, орон сууцны асуудлыг шийдэх, эрүүл мэндийг сахин хамгаалж, хөгжүүлэх, нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх зэргээр иргэдийн хэрэгцээг хангадаг. Аймгийн засаг захиргаа нь орон нутгийн удирдлагын тогтолцооны нэг хэсэг юм. Иргэд аймаг, хот, тосгон, дүүргийн захиргаанд хандаж захиргааны асуудлаа шийддүлдэг. Аймаг, хот, тосгон, дүүрэг өөрөө удирдах эрхтэй тул иргэд (аймаг, хот, тосгон, дүүргийн) Төлөөлөгчдийн хурлыг сонгоно.



Чех Улс нь улс төрийн нам, хөдөлгөөний чөлөөт өрсөлдөөн дээр үндэслэсэн улс төрийн систем бүхий ардчилсан, эрх зүйт улс мөн. Хувь хүний нэр төр, үнэ цэнэ, хүн бүрийн төрөхөөсөө эрх чөлөөтэй, хуулийн өмнө адил тэгш, ялгаварлан гадуурхагдахгүй байх эрхийг хангасан Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон Үндсэн хууль нь Чех Улсын хамгийн дээд хууль мөн. Чех Улсын амьдарч буй иргэн бүр эрх нь зөрчигдсөн тохиолдолд шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй. Зөвхөн Чех Улсын иргэн сонгох, сонгогдох эрх эдлэнэ.

Чех Улсын **ерөнхийлөгч** нь төрийн тэргүүн мөн бөгөөд засгийн газрын гишүүдийг томилох, батлагдсан хуульд гарын үсэг зурах, олон улсын гэрээний тухай хэлэлцээ явуулах, соёрхон батлах, сонгууль зарлах, өршөөл үзүүлэх эрхийг эдэлнэ. Чех Улсад хууль өргөн барих, тогтоох эрхийг **Төлөөлөгчдийн** буюу доод **танхим, Сенат** буюу дээд танхимаас бүрдсэн **БНЧУ-ын Парламент** эдлэнэ.

Засгийн газар нь төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн. Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ улс орныг удирдах, хууль тогтоомж батлах өндөр хариуцлага хүлээхээс гадна төрийн байгууллагуудын үйл ажиллагааг удирдах, хууль тогтоомж биелүүлэх, тэдгээрийн хүрээнд тогтоол, тушаал гаргах зэрэг үйл ажиллагаа явуулдаг. Засгийн газар үйл ажиллагаагаа Төлөөлөгчдийн танхимд тайлагнах бөгөөд итгэл алдсан засгийн газрыг Төлөөлөгчдийн танхим огцруулах эрхтэй. Шүүх эрх мэдлийг хараат бус шүүх хэрэгжүүлнэ. Аливаа хэргийг БНЧУ-ын эрх зүйн дэг журам дээр үндэслэсэн хууль тогтоомжийн дагуу зохицуулж, шийдвэрлэнэ.

Чех Улсын иргэд ерөнхийлөгч, Парламентын Төлөөлөгчдийн танхим, Сенатын гишүүд, аймаг, хот, тосгон, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдийг шууд сонгуулиар сонгодог. Ардчилсан сонгуулийн үндсэн зарчим нь сонгуулийн насны иргэд нийтээрээ, чөлөөтэй саналаа нууцаар өгөх, сонгогчдын санал эрх тэгш байдлыг хангах үүрэгтэй. Насанд хүрсэн буюу 18 нас хүрсэн Чех Улсын иргэн бүр сонгуульд саналаа өгөх эрхтэй.

Чех Улсад янз бүрийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг төрийн бус байгууллага, нийгэмлэг, холбоо зэргээс бүрдсэн иргэний нийгэм харьцангуй өндөр түвшинд байна. Эдгээр ТББ, нийгэмлэг, холбоо, хувь хүний үйл ажиллагаа нь төрийн болон хувийн хэвшил, тэдний ашиг сонирхлыг хооронд нь тэнцвэржүүлэн, нөхөж байдаг хүчин зүйл юм. Ашгийн бус, төрийн бус байгууллагууд гадаадын иргэдэд зөвлөгөө өгөх, янз бүрийн үйлчилгээ үзүүлэх салбарт үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд тус товхимлын зохих хэсгээс энэ тухай мэдээллийг олж авах боломжтой.

Хүний эрх хамгаалагч (омбудсман)

Омбудсман нь төрийн болон бусад албан байгууллагын хууль зөрчсөн, хууль эрх зүйт ардчилсан орны зарчимд нийцээгүй үйлдлээс иргэдийг хамгаалж ажиллана. Омбудсман нь хүний эрхийн үндсэн зарчмыг эрхэмлэн дээдлэх, хүн бүрд эрх тэгш хандах, ялгаварлан гадуурхахаас сэргийлэн хамгаалах асуудалд өөрийн хувь нэмрээ оруулж ажилладаг.

Гадаадын иргэдийн эрх зөрчигдсөн эсвэл төрийн байгууллагын зүгээс хүлээсэн үүргээ эс биелүүлсэн тохиолдолд туслалцаа үзүүлнэ.

Албан ёсны нэр	Бүгд Найрамдах Чех Улс, Чех эсвэл ЧУ хэмээн товчилдог
Үүсгэн байгуулагдсан огноо	1993 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр
Нийслэл	Прага хот
Нутаг дэвсгэр, засаг захиргааны хуваарь	14 аймаг
Улс төрийн засаглал	Парламентын ардчиллын засаглалтай, Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн юм
Насанд хүрсэнд тооцох	18 нас хүрсэн өдрөөс (Иргэний хуулиар зохицуулагдсан)
Эрүүгийн хариуцлага хүлээлгэх нас	15 нас хүрсэн өдрөөс (Эрүүгийн хуулиар зохицуулагдсан)
Нутаг дэвсгэрийн хэмжээ	78 865 км ²
Утасны олон улсын код	+420
Уур амьсгал	Зөөлөн дулаан уур амьсгалтай, жилийн дөрвөн улирал ээлждэг. Өвөлдөө 0 хэмээс -5 хэм хүйтэрдэг, цас орох нь багавтар, их хүйтэрсэн үед -20 хэм хүрдэг. Зундаа +25 хэм, их халуун болоход +30 гаруй хэм хүрдэг.
Чухал утасны дугаар (дуудлага 24 цагийн турш үнэ төлбөргүй өгөх боломжтой)	112 Европын нэгдсэн шуурхай дугаар 150 Гал унтраах анги 155 Түргэн тусламж (эмнэлгийн) 156 Хотын цагдаа 158 ЧУ-ын цагдаа 116 111 Хүүхдийн тусламжийн утас

ЧЕХ УЛСЫН ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДЭГ

Чех Улс төрийн том сүлд, төрийн бага сүлд, ерөнхийлөгчийн далбаа, төрийн далбаа, үндэсний өнгө, төрийн тамга, төрийн дуулал гэсэн нийт 7 төрийн бэлгэ тэмдэгтэй байна. Дор дурдсан төрийн бэлгэ тэмдгийг хамгийн өргөнөөр ашигладаг. Үүнд:



Төрийн том сүлд

Төрийн том сүлд нь бамбай хэлбэртэй бөгөөд дотроо дөрвөн хэсэгт хуваагддаг. Хэсэг тус бүрээр Чех, Морав, Силезийг, дөрөвдэх нь улс орныг бүхэлд нь илэрхийлдэг. Төрийн том сүлд нь тус улсын түүхт газар нутаг дээр нэгдмэл улс буй болсныг илэрхийлдэг бөгөөд төрийн байгууллага, албан газар, бусад байр байшинд байрлуулах, улс орноо төлөөлөхөд хэрэглэдэг.

Төрийн далбаа

Чех Улсын төрийн далбаа нь Чех Улсыг эх орондоо болон гадаад улсуудад төлөөлөх төрийн албан ёсны бэлгэ тэмдэг юм. Төрийн далбаа нь дээд талдаа цагаан, доод талдаа улаан хэвтээ хоёр судлын дунд цэнхэр гурвалжин хошуутай байна. Төрийн далбаанд орсон өнгийг Чех Улсын үндэсний өнгө гэж үздэг.



Ерөнхийлөгчийн далбаа

Ерөнхийлөгчийн далбаа дөрвөлжин хэлбэртэй. 1918 онд анх Чехословак Улс үүсч бий болох үед төрт улсын бэлгэдлийн нэг болж үүссэн түүхтэй. Далбаагаар ерөнхийлөгчийг ямагт төр захиргааны байгууллагаас давуу байхыг бэлгэддэг. Ерөнхийлөгчийн ажиллаж амьдардаг Прагийн ордны орой дээр ерөнхийлөгчийг байгаа үед мөн хэвлэлийн бага хурлын үеэр далбааг мандуулахаас гадна ерөнхийлөгчийн албаны машинд байрлуулдаг дүрэмтэй.

Төрийн дуулал

“Фидловачка” хэмээх чех жүжгийн “Нутаг минь хаа байдаг вэ” дууны эхний бадгийг бага зэрэг өөрчилж 1992 оноос эхлэн Чех Улсын төрийн дуулал болгожээ. Төрийн дууллын шүлгийг Йосеф Кайетан Тыл, хөгжмийг Франтишек Шкroup зохиосон бөгөөд уг дуу ахархан хугацаанд ардын дуу болтлоо алдаршсан юм. Төрийн дууллыг улсын баяр, олон улсын тэмцээний эхэнд, олон улсын болон ёслолын чанартай соёлын арга хэмжээ зэрэг үед дуулж, хөгжимдөнө.



Төрийн дууллын үг

*Kde domov můj,
kde domov můj?
Voda hučí po lučinách,
bory šumí po skalínách,
v sadě skví se jara květ,
zemský ráj to na pohled!
A to je ta krásná země,
země česká, domov můj,
země česká, domov můj!*

Нутаг минь хаа байна вэ,
Нутаг минь хаа байна вэ?
Нуга тохойгоор гол горхи хүрхрэн урсаж,
Нарсан ой уул, хад дамжин шуугина.
Айлын гадаа хаврын цэцэг дэлгэрч,
Харахаас л диваажин юм даа.
Энэ бол миний сайхан орон,
Миний нутаг – чех орон,
Миний нутаг – чех орон.

Тусгаар тогтносон Чех Улсын анхны ерөнхийлөгч Вацлав Хавел байжээ.

МЭДЭЭЛЭЛ, ТУСЛАЛЦАА

Төрийн засаг захиргаа

www.statnisprava.cz

Төрийн байгууллагуудын нэгдсэн портал сайт

www.portal.gov.cz



ЧЕХ УЛС ДАХЬ ГАДААДЫН ИРГЭДИЙН ШИЛЖИН СУУРЬШИЛТ, ИНТЕГРАЦЧИЛАЛЫН ТҮҮХЭЭС

Чески Крумлов, Влтава мөрний намрын өнгө

Бүгд Найрамдах Чех Улс 1993 онд үүсгэн байгуулагдснаасаа хойш шилжин суурьшилтын хувьд гадаадын иргэдийн сонирхлыг ихээр татах болжээ. Чех Улсад хөдөлмөр эрхлэх, бизнесийн үйл ажиллагаа явуулах, сургуульд сурахын зэрэгцээ нутагт нь болж буй дайн самуунаас дайжсан гадаадын иргэдийн тоо жилээс жилд өссөөр иржээ.

2022 оны шувтаргаар Чех Улсад бүртгэгдсэн нийт 1 116 000 гадаадын иргэдийн 334 мянга гаруй нь байнга оршин суух зөвшөөрөлтэй байна (эх сурвалж: Дотоод хэргийн яамны Гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн цагдаагийн албаны захиргаа).

Иргэний харьяаллын хувьд Чех Улсыг зорьж ирж буй эсвэл амьдарч буй гадаадын иргэдийн дунд Украин, Словак, Вьетнам, Орос, Польш, Герман зэрэг улсын иргэд зонхилж байна (эх сурвалж: Чехийн статистикийн хороо).

Нийгмийн дийлэнх хэсэг нь, үндэстний цөөнхи болон бусад хувь хүмүүстэй зөрчил маргаангүй, эв найртай амьдрах гол хүчин зүйлийн нэг нь гадаадын иргэдийн нийгэмд интеграцчилагдах асуудал юм. Засгийн газраас Гадаадын иргэдийн интеграцчилалын бодлогыг баталж, Дотоод хэргийн яам зохицуулан явуулдаг. Бусад яамдууд өөр өөрсдийн эрх мэдлийн хүрээнд гадаадын иргэдийн интеграцчилалтай холбоотой үүрэг даалгавар биелүүлдэг.

Гадаадын иргэд чех хэл сурах, эдийн засгийн хувьд биеэ даах, нийгэмд чиг баримжаагаа олох, нийгмийн дийлэнхтэй ойлголцох нь тэдний интеграцчилагдах үйл явцад хамгийн тэргүүн эгнээнд байх ёстой хэмээн Чех Улсын Засгийн газар үздэг.

Интеграцчилалын бодлого ихэвчлэн Чех Улсад удаан хугацаагаар болон байнга оршин суугаа гуравдагч орны иргэдэд хамаарах хэдий ч зарим нэг арга хэмжээ нь Чех Улсын талаарх анхан шатны мэдээлэл өгөх зорилгоор тус улсад шинээр ирж буй гуравдагч орны иргэдэд зориулагдсан болно.

Интеграцчилалын бодлогын хүрээнд хэрэгжүүлж байгаа арга хэмжээний нэг нь шинээр ирж буй гуравдагч орны иргэдэд, ялангуяа Чех Улсад оршин суух эхэн үед нь тус орны нийгэм, ахуй амьдралд шаардлагатай үндсэн мэдээлэл өгөх зорилгоор явуулж буй дасан зохицох, интеграцчилалын дамжаа юм. **2021.01.01-ний** өдрөөс эхлэн сургуульд сурах, хамгаалалтад байгаа, компани дотроо нэг ажлаас нөгөө ажилд шилжих, хөрөнгө оруулах зорилгоор оршин суух зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд Гадаадын иргэд Чех Улсад оршин суух тухай хуулийн 66 эсвэл 67-р зүйлийн дагуу удаан хугацааны эсвэл байнга оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэд энэхүү дамжаанд заавал хамрагдах үүрэг хүлээж байгаа бөгөөд ингэхдээ дамжаанд суух үүргээ оршин суух зөвшөөрөл олгосон өдрөөс 1 жилийн дотор биелүүлнэ. 15-аас доош, 61-ээс дээш насны эсвэл уг дамжааг урьд нь дүүргэсэн иргэд суух шаардлагагүй.

Жич: Та дасан зохицох, интеграцчилалын дамжаанд хамрагдах эсэхдээ эргэлзэж байгаа бол Прагийн интеграцчилалын төвийн асуултанд хариулж үзээрэй.

ГАДААДЫН ИРГЭДИЙН НИЙГЭМД ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР

Гадаадын иргэд нь тэднийг хүлээн авсан нийгмээ өөрсдийн мэдлэг мэргэжил, ур чадвар, уламжлалаараа баяжуулж байдаг юм. Улам бүр даяаршиж байгаа өнөө үед шилжин суурьшилт нь нэгэнт хэвийн үзэгдэл болоод зогсохгүй хэрэгцээ болж байгаа нь нийгмээ солонгоруулж байна. Шилжин суурьшихаар ирж буй гадаадын иргэд төдийгүй тэднийг хүлээн авч буй нийгэм нь эдгээр хүмүүсийн мэдлэг, ур чадвар, мэргэжлийг хэн хэнийхээ сайн сайхны төлөө хангалттай ашиглах тал дээр анхаарч ажиллавал зохино.

Чех Улсад 1989 оноос хойш иргэний нийгэм, иргэдийн нийгмийн оролцоо сэргэсээр байна. Мөн гадаадын иргэд ч өөрсдийн амьдарч буй бүс нутаг, хот, тосгоны нийгэмлэг, бүлгээс зохиож буй сайн дурын болон сонирхлын үйл ажиллагаа, төрийн бус байгууллага (ТББ), сан, интеграцчилалын төвүүдийн үйл ажиллагаанд оролцох боломжтой.





ЧЕХ УЛСАД ОРШИН СУУХ ТУХАЙ

Телч хотын цэцэрлэгт хүрээлэн

БАЙГУУЛЛАГУУД

Богино хугацааны виз олгох:

БНЧУ-ын Гадаад хэргийн яам: гадаад улсад суугаа БНЧУ-ын төлөөлөгчийн газар

Оршин суухтай холбоотой бүх асуудал, оршин суух зөвшөөрлийн сунгалт, өөрчлөлтийн тухай мэдэгдэх, хүсэлтийн хамт бүрдүүлэх материал:

БНЧУ-ын Дотоод хэргийн яамны Орогнол, шилжин суурьшилтын газар (“ОАМП”) -ын Гадаадын иргэдийн оршин суух асуудал эрхэлсэн хэлтэс

Оршин суух зөвшөөрлийн хяналт шалгалт, урилга баталгаажуулалт, тус улсад хүрч ирсэн гадаадын иргэдийн бүртгэл:

Гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн цагдаагийн алба

Энэ бүлэгт орсон мэдээлэл зөвхөн гуравдагч орны иргэдэд зориулагдсан болно. ЕХ-ы орны иргэд, тэдний гэр бүлийн гишүүд, олон улсын хамгаалал хүсэгч болон олон улсын хамгаалал авсан гадаадын иргэдэд зарим асуудлаар өөр дүрэм үйлчилдэг тул доорх мэдээлэл хамаарахгүй.

Цэнхэр болон ажилтны карт эзэмшигч гуравдагч орны иргэдийн оршин суух зөвшөөрөл, ажил эрхлэлт, гэр бүл нэгтгэх зэрэг асуудал нь тусгайлан зохицуулагддаг тул энэ тухай мэдээллийг Дотоод хэргийн яамны www.mvcr.cz/cizinci нэгдсэн портал сайтаас үзнэ үү.

ГОЛ БОЛОХ БАЙГУУЛЛАГУУД

БНЧУ-ын Дотоод хэргийн яамны Орогнол, шилжин суурьшилтын газар (“ОАМП”/ОАМР)-ын Гадаадын иргэдийн оршин суух асуудлыг эрхэлсэн хэлтэс.

Энэ хэлтэст гадаадын иргэний тус улсад оршин суух хугацааг сунгуулах, өөрчлөлтөө мэдэгдэх зэрэг оршин суухтай холбоотой асуудлыг шийдүүлэхээр хандана. Дэлгэрэнгүй мэдээллийг доорх бүлгүүдээс, товхимлын Холбоо барих хэсгээс үзнэ үү.

Гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн цагдаагийн алба. Энэ алба нь гадаадын иргэдийн оршин суух эрхийг хянан шалгах, урилга баталгаажуулах зэргээс гадна гадаадын иргэн тус улсын хил нэвтэрсний дараа байр олгогч этгээдээс бүртгэл хийлгүүлээгүй тохиолдолд уг албанд өөрөө хандаж бүртгүүлнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг доорх бүлгүүдээс, товхимлын Холбоо барих хэсгээс үзнэ үү.

Дотоод хэргийн яамны Орогнол, шилжин суурьшилтын газрын ("ОАМП"/ОАМР) Гадаадын иргэдийн оршин суух асуудал эрхэлсэн хэлтэс, Гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн цагдаагийн албаны хоорондын ялгааг ойлгох нь чухал! Энэ бол эрх мэдэл, үүргээрээ эрс ялгаатай хоёр өөр байгууллага! Ямар нэг асуудлаар зохих байгууллагад хандаж байхыг анхаарна уу.

ҮНДСЭН НЭР ТОМЬЁНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Гуравдагч орны иргэн гэж Европын Холбооны гишүүн орнууд, Исланд, Лихтенштейн, Норвег, Швейцараас бусад улсуудын иргэнийг хэлнэ.

Европын Холбооны гишүүн орон гэж Австри, Бельги, Болгар, Герман, Грек, Дани, Ирланд, Испани, Итали, Кипр, Латви, Литва, Люксембург, Мальт, Нидерланд, Польш, Португал, Румын, Словак, Словени, Унгар, Финланд, Франц, Хорват, Чех, Швед, Эстони улсыг хэлнэ.

Удаан хугацааны виз гэж 90 хоногоос дээш хугацааны виз (цаашид "удаан хугацааны виз")-ийг хэлнэ. Уг визийг 1 жилээс дээшгүй, бизнес эрхлэлт, гэр бүл нэгтгэх, урилга, соёлын болон спорт, биеийн тамирын арга хэмжээ, сургалтын зарим нэг хэлбэр зэрэг оршин суух зорилгоор, бүрдүүлэх шаардлагатай материалын хүчинтэй байх хугацаатай тааруулан оршин суух тодорхой хугацаагаар олгодог. Анх удаа Чех Улс руу явж буй хүмүүсийн мэдүүлдэг хамгийн түгээмэл виз юм.

БНЧУ-д удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл. Чех Улсад удаан хугацааны визтэй иргэн цаашдаа ирсэн зорилгоо өөрчлөлгүй 1 жилээс илүү хугацаагаар оршин суух тохиолдолд тус улсын Дотоод хэргийн яамны Орогнол, шилжин суурьшилтын газарт (ОШСГ буюу чехээр "ОАМП") БНЧУ-д удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл хүссэн хүсэлт гаргаж тус улсад оршин суух хугацаагаа сунгуулах боломжтой). БНЧУ-д удаан хугацааны оршин суух зөвшөөрөл олгуулах хүсэлтээ



тусгайлан заасан зарим нөхцөлд (сургуульд сурах, эрдэм шинжилгээний ажил хийх, гэр бүл нэгтгэх, цэнхэр болон ажилтны карт авах, хөрөнгө оруулалт хийх гэх мэт) **Чех Улсын дипломат төлөөлөгчийн газарт** гаргаж болно. Удаан хугацааны оршин суух зөвшөөрлийг EX-ны гишүүн өөр орны иргэн ажилтныг компани дотроо шилжүүлэх зорилгоор 3 жил, гэр бүл нэгтгэх зорилгоор 5 жилийн хугацаагаар тус тус олгодог бол бусад тохиолдолд 2 жилээс дээшгүй хугацаагаар олгодог. Уг зөвшөөрлийг ямагт тодорхой зорилгоор олгох бөгөөд удаа дараалан сунгуулах боломжтой.

Чех Улсад оршин суух зорилго. Оршин суух зорилго гэдэг нь гадаадын иргэн Чех Улсад оршин суух эрх зүйн үндсэн нэр томъёо бөгөөд өөрөөр хэлбэл Чех Улсад оршин суух эрх авах үндэслэл болсон үндсэн шалтгаан гэж энгийнээр тайлбарлаж болно. **Хөдөлмөр, бизнес эрхлэх, суралцах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, гэр бүл нэгтгэх зэрэг нь** тус улсад оршин суух зорилго болдог.

Удаан хугацааны виз мэдүүлэх эсвэл оршин суух зөвшөөрлийн хүсэлт гаргахдаа Чех Улсад ямар хэргээр оршин суух гэж байгаагаа нотлох баримтыг бусад материалын хамт бүрдүүлнэ. Чех Улсад амьдарч байх хугацаандаа анх мэдүүлсэн зорилгоор оршин суух үүрэгтэй байгаа ба энэ үүргээ биелүүлээгүй тохиолдолд тус улсад оршин суух эрхийг хүчингүй болгоход хүрч болзошгүй. Мэдүүлсэн зорилгоороо оршин сууна гэдэг нь тус улсад амьдарч байгаа бүхий л хугацааныхаа туршид анхны зорилгоороо оршин сууж байгаагаа хөдөлмөрийн гэрээ, гэрлэлтийн гэрчилгээ, сургуулийн тодорхойлолт гэх мэт зохих бичиг баримтаар нотлоно гэсэн үг юм.

Таны нөхцөл байдал олон төрлийн зөвшөөрлөөс сонгох боломжтой байж болох ч оршин суух эрх олгох үндэслэл болсон оршин суух зорилго хэзээд ганц л байна. Тодорхой нөхцөлд оршин суух зорилгоогоо өөрчлөх боломжтой. Тус улсад оршин суух зорилгын кодыг оршин суух үнэмлэхэд заасан байдаг тул утга учрыг нь Дотоод хэргийн яамны цахим хуудаснаас үзэж болно.

Таны нөхцөл байдал өөрчлөгдөж өнөөдрийг хүртэл Чех Улсад оршин сууж байсан зорилгоогоо өөрчилж өөр зорилгоор оршин суух хүсэлтэй байх тохиолдолд та шинээр удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл олгох хүсэлт гаргах үүрэгтэй. Гэхдээ энд зарим нэг хуулийн хязгаарал байдаг. Үүнд,

- Чех Улсад удаан хугацааны визээр оршин сууж байгаа гадаадын иргэн визэд зааснаас өөр зорилгоор удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл хүсэх эрхгүй. Харин өөр зорилгоор удаан хугацааны виз авсан гадаадын иргэд гэр бүл нэгтгэх зорилгоор удаан хугацааны оршин суух зөвшөөрөл хүсэх эрхтэй. Түүнчлэн эрдэм шинжилгээний ажил хийх, сургуульд сурах зорилгоор удаан хугацааны виз авсан гадаадын иргэн ажил хайх, бизнес эхлүүлэх зорилгоор удаан хугацааны оршин

суух зөвшөөрөл хүсэх эрхтэй. Удаан хугацааны визтэй гадаадын иргэн Чех Улсаас гаралгүй ажилтны карт хүссэн өргөдөл гаргах эрхтэй.

- Чех Улсад хувиараа бизнес эрхлэх зорилгоор оршин суух хүсэлтэй тохиолдолд та удаан хугацааны оршин суух зөвшөөрөлтэй байхаас гадна тус улсад 5-аас илүү жил амьдарсны дараа оршин суух зөвшөөрлийн зорилгоо өөрчлөх өргөдөл гаргах боломжтой.
- Хэрэв та гэр бүл нэгтгэх зорилгоор оршин суух зөвшөөрөл авсан бол тус улсад 3 жил амьдарсан эсвэл 18 нас хүрсэн нөхцөлд Дотоод хэргийн яаманд өөр зорилгоор оршин суух зөвшөөрөл олгох хүсэлт гаргаж болно.
- Та гэр бүл нэгтгэх зорилгоор оршин суух зөвшөөрөл авсан боловч зөвшөөрөл эзэмшигчтэй гэрлэлтээ цуцлуулсан тохиолдолд ч шинээр удаан хугацааны оршин суух зөвшөөрлийн хүсэлт гаргах эрхтэй. Шинээр хүсэлт гаргах болзолд та гэрлээд хамгийн багадаа 5 жил хамт амьдарсан, гэрлэлтээ цуцлуулсан өдрийн байдлаар Чех Улсад 2 жил амьдарсан байх шаардлагатай. Хүсэлтээ гэрлэлт цуцлагдснаас нэг жилийн дотор гаргана.

Удаан хугацааны виз, удаан хугацааны оршин суух зөвшөөрөлтэй этгээд ажилтны эсхүл цэнхэр карт гаргуулах, гэр бүл нэгтгэх, эрдэм шинжилгээний ажил хийх, хөрөнгө оруулах зорилгоор удаан хугацааны оршин суух зөвшөөрөл хүсэх тохиолдолд хүсэлтээ шууд Чех Улсын нутаг дэвсгэр дээр гаргах боломжтой. Харин тус улсад улирлын чанартай ажил хийх зорилгоор олгосон удаан хугацааны виз, хүлээлгийн виз, хөдөлмөрийн онцгой визтэй хүнд хамаарахгүй.

Удаан хугацааны виз, удаан хугацааны оршин суух зөвшөөрөл нь хоорондоо эрс ялгаатай. Энэ ялгаанаас улбаалан хоорондоо харилцан адилгүй эрх, үүрэг үүсдэг тул албан газар, интеграцчилалын төвүүдтэй харилцах үедээ нэр томъёог оновчтой зөв хэрэглэх нь чухал.



ЧЕХ УЛСАД ОРШИН СУУХ, ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРЛӨӨ СУНГУУЛАХ БҮДҮҮВЧ



Удаан хугацааны визтэй гадаадын иргэн Чех Улсад оршин суух хугацаагаа сунгуулах (визийн хугацааг сунгуулах)

Тус улсад удаан хугацааны визээр оршин суух хугацаа болон удаан хугацааны визийн хугацааг сунгуулах хүсэлтийг Дотоод хэргийн яамны Орогнол, шилжин суурьшилтын газрын ("ОШСГ" буюу чехээр "ОАМП"/OAMP хэмээх товчилсон нэртэй олонтоо тааралдана) зохих салбарт гаргана.

Таны Чех Улсад орж ирсэн, цаашдаа байхаар төлөвлөж байгаа хугацаа нийлээд 1 жилээс илүүгүй байх тохиолдолд оршин суух хугацаагаа (визийн хугацааг) сунгуулах хүсэлт гаргаж болно. Үүнд, хуульд заасан материалыг бүрэн бүрдүүлэх ба оршин суух зорилго хэвээр байх шаардлагатай.

Тус улсад оршин суух хугацаа, удаан хугацааны визийн хугацааг сунгуулах хүсэлт гаргахдаа үйлчилгээний хураамж төлнө. Төлбөрийн хэмжээг Дотоод хэргийн яамны цахим хуудсанд мэдээлдэг. Зургаагаас доош насны хүүхэд, сургуульд сурах зорилгоор виз авсан хүмүүс үйлчилгээний хураамжаас чөлөөлөгдөнө. Үйлчилгээний хураамжийг Чех шуудангийн зарим салбарт худалддаг улсын тэмдэгт худалдан авч төлнө.

Үйлчилгээний хураамж төлөөгүй, хүсэлт бүрдүүлэх материал дутуу байх нь хүсэлтийг хүлээн авахаас татгалзах үндэслэл болно. Ингэж хүлээн авахаас татгалзсан хүсэлтийг шийдвэрлэх ажиллагааг үүсгэлгүйгээр хүсэлт гаргасан этгээдэд буцааж өгнө.

Чех Улсад удаан хугацааны оршин суух зөвшөөрөл авах

Чех Улсад удаан хугацааны визээр оршин сууж байгаа гадаадын иргэн оршин суух хугацаагаа 1 жилээс илүү хугацаагаар сунгуулах тохиолдолд хуульд заасан хугацааны дотор удаан хугацааны оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргах эрхтэй. Хүсэлт

гаргах өдөр Бямба, Ням гараг эсвэл баярын өдрүүдтэй давхцвал эдгээр өдрүүдийн дараах ажлын эхний өдөр хүсэлтээ гаргана. Хүсэлт дээр заасан хугацааны сүүлийн өдөр гэхэд БНЧУ-ын Дотоод хэргийн яамны Орогнол, шилжин суурьшилтын холбогдох салбар, хэлтэст ирсэн байх шаардлагатай. Үүнд, оршин суух зорилго хэвээр байхаас гадна хуульд заасан материалыг бүрэн бүрдүүлнэ.

Удаан хугацааны оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргахдаа тэмдэгтийн хураамж төлнө.

Чех Улсад удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэн удаан хугацааны оршин суух зөвшөөрлийнхөө хугацааг сунгуулах

Удаан хугацааны оршин суух зөвшөөрлийн үндсэн дээр Чех Улсад амьдарч байгаа гадаадын иргэн нь оршин суух зөвшөөрлийнхөө хугацааг сунгуулахаар болсон тохиолдолд удаан хугацааны оршин суух зөвшөөрлийнхөө хугацааг хуульд заасан хугацааны дотор сунгуулах хүсэлт гаргах эрхтэй. Энэ өдөр Бямба, Ням гараг эсвэл баярын өдрүүдтэй давхцвал эдгээр өдрүүдийн дараах ажлын эхний өдөр хүсэлтээ гаргана. Энэ тохиолдолд ч мөн адил хуульд заасан материалыг бүрэн бүрдүүлэх шаардлагатай.

Хүсэлтээ заасан хугацаанд амжиж гаргаагүй бол хүндэтгэн үзэх шалтгаанаас бусдаар таны Чех Улсад оршин суух зөвшөөрлийг дуусгавар болгохыг анхаарна уу.

Удаан хугацааны оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргахдаа тэмдэгтийн хураамж төлнө.

Байнга оршин суух зөвшөөрөл

Байнга оршин суух зөвшөөрөл авах хүсэлтийг Чех Улсад тасралтгүй 5 жил амьдарсан гадаадын иргэн Дотоод хэргийн яаманд гаргана. Гадаадын иргэд Чех Улсад оршин суух тухай хуульд ямар төрлийн оршин суух зөвшөөрлийн хугацааг тус улсад амьдарсан 5 жилийн хугацаанд тооцох, ямарыг нь тооцохгүйг заасан байдаг (Чех Улсад сургуульд суралцсан хугацааг оруулахдаа зөвхөн хагасыг нь тооцдог болохыг анхаарна уу). Байнга оршин суух зөвшөөрөл авах болзлын нэг болох чех хэлний шалгалтыг 15-аас доош болон 60-аас дээш насны, сэтгэцийн өвчтэй иргэдээс бусад нь өгнө. Европын Холбооны хэлний нэгдсэн стандартын дагуу наанадаж А2 түвшний шалгалтад тэнцэх шаардлагатай. Бичгийн болон аман хэсгээс бүрддэг шалгалтад тэнцсэн гадаадын иргэнд гэрчилгээ олгоно.

Байнга оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргахдаа тэмдэгтийн хураамж төлнө.

БИЕЙН ДАВЦАХГҮЙ ӨГӨГДӨЛ

Биеийн давхцахгүй өгөгдөл гэж цээж зураг, хурууны хээг хэлнэ. Уг өгөгдлийг Дотоод хэргийн яамны холбогдох хэлтэс, салбаруудад тусгай зориулалтын тоног төхөөрөмжийн тусламжтайгаар авдаг бөгөөд мөнхүү газраас биеийн давхцахгүй өгөгдөл бүхий оршин суух цахим үнэмлэх олгодог. Иймээс оршин суух үнэмлэхээ (эхээр нь) биедээ авч явна, хуулбар хангалтгүй. Шалгуулах тохиолдолд зөвхөн эх үнэмлэхээ үзүүлнэ.

Биеийн давхцахгүй өгөгдлийг Чех Улсад удаан эсвэл байнга оршин суух зөвшөөрөлтэй гуравдагч орны иргэдээс авдаг. Харин тус улсад удаан хугацааны визээр суудаг гуравдагч орны иргэдээс авдаггүй.

Энэ дүрмийг Европын Холбооны хууль тогтоомжийн дагуу нэвтрүүлэн мөрдөж байгаа болно.

Гадаадын иргэний гаргасан оршин суух зөвшөөрөл авах хүсэлтийг нааштай шийдвэрлэсэн тохиолдолд Чех Улсын “ОШСГ” (буюу чехээр “ОАМП”/OAMP)-д цээж зураг, хурууны хээг авахуулж, дижитал аргаар боловсруулах зорилгоор гарын үсэг зуруулна.

Гадаадын иргэн биеийн давхцахгүй өгөгдлөө авахуулснаас хойш 60 хоногийн дотор Дотоод хэргийн яамны харьяалагдах хэлтэст очиж, үнэмлэх авах тухай мэдэгдэл авна. Үнэмлэх олгохдоо алдаа гарсан эсэхийг шалгах үүднээс биеийн давхцахгүй өгөгдлийг дахин авч тулгадаг.

Цээж зураг, хурууны хээ анх авахуулснаас 60 хоногийн дотор үнэмлэхээ очиж аваагүй тохиолдолд өгөгдөл автоматаар устгагдаж, оршин суух зөвшөөрөл дуусгавар болохыг **анхаарна уу**.

Үнэмлэхэд бичигдсэн мэдээлэл (жишээ нь, овог, гэр бүлийн байдал – гэрлэсэн гэх мэт) өөрчлөгдсөн тохиолдолд энэ тухайгаа Дотоод хэргийн яаманд өөрчлөлт гарсан өдрөөс ажлын 3 хоногийн дотор мэдэгдэх үүрэгтэй.

Чех Улсад удаан хугацааны виз эсвэл оршин суух зөвшөөрлийн үндсэн дээр суудаг гадаадын иргэний гэрийн хаяг өөрчлөгдсөн ба уг өөрчлөлт нь 30-аас илүү хоног үргэлжлэх тохиолдолд энэ тухайгаа өөрчлөлт гарсан өдрөөс 30 хоногийн дотор мэдэгдэх үүрэгтэй. Байнга оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэний гэрийн хаяг

өөрчлөгдсөн ба өөрчлөлт 180 хоногоос илүү хугацаанд үргэлжлэх тохиолдолд энэ тухайгаа өөрчлөлт гарсан өдрөөс эхлэн 30 хоногийн дотор мэдэгдэнэ.

Өөрчлөлтийг “**Өөрчлөлтийг бүртгүүлэх маягт**” хэмээн зориулалтын маягтыг ашиглан биечлэн эсвэл шуудангаар явуулж бүртгүүлнэ. Танд төрийн байгууллагуудтай харилцах зориулалтын цахим шуудан байгаагаас бусад тохиолдолд өөрчлөлтийг и-мэйлээр мэдэгдэх боломжгүй.

Цахим үнэмлэх дахин олгоход үйлчилгээний өндөр хураамжтай тул үнэмлэхээ гээж, үрэгдүүлэхээс болгоомжлогтун. Хугацаа нь дуусч хүчингүй болсон үнэмлэхээ БНЧУ-ын Дотоод хэргийн яамны зохих салбар, хэлтэст хураалгана.

ШЕНГЕНИЙ ОРНУУД

Чех Улс нь 2007 онд Шенгений орон болсон.

Шенгений орнууд гэдэг нь зорчигчдийн харилцан хилийн шалгалтгүй, чөлөөтэй нэвтрүүлдэг улс орнуудыг хамарсан бүс нутаг юм. Хилийн шалгалтын оронд хамтын нягт ажиллагаа, Шенгены бүсийн гадна хилээ хамгаалах нэгдсэн дүрэм, цагдаагийн болон хууль хяналтын байгууллагуудын хамтын ажиллагаа, хувийн мэдээллийн хамгаалал, богино хугацааны (Шенгений) виз олгох, Шенгений мэдээллийн системийн хэмжээнд мэдээлэл харилцан солилцох арга хэмжээг нэвтрүүлэн хэрэгжүүлдэг юм. Шенгений орнууд харилцан мэдээлэл солилцдог бөгөөд гадаадын иргэн



Шенгений аль нэг улсад хууль зөрчсөн тохиолдолд бусад орнууд өөрсдийн орны хилээр нэвтрэхийг хориглох хүртэл арга хэмжээ авдаг.

Шенгений бүс нутаг

Шенгений бүс нутагт Австри, Бельги, Герман, Грек, Дани, Исланд, Испани, Итали, Латви, Литва, Лихтенштайн, Люксембург, Мальта, Нидерланд, Норвег, Польш, Португал, Словак, Словени, Унгар, Чех Улс, Швед, Швейцар, Финланд, Франц, Эстони, 2023 оноос эхлэн Хорват Улс нэмэгдсэн болно. Болгар, Ирланд, Кипр, Румын нь ЕХ-ы гишүүн орнууд мөн ч Шенгений бүс нутагт багтдаггүй.

Шенгений бүс нутгаар зорчих эрх

Гуравдагч орны иргэн хүчин төгөлдөр гадаад паспорт, удаан хугацааны виз, удаан хугацааны эсвэл байнга оршин суух зөвшөөрөлтэй бол Шенгений орнуудаар 6 сарын (180 хоногийн) дотор нийт 90 хоногийн хугацаагаар зорчих эрхтэй. Энэ хугацаа нь Чех Улсын хилээр гарч Шенгений бүс нутгийн өөр улсын нутаг дэвсгэрт нэвтрэн орсон өдрөөс тоологдож эхлэх бөгөөд 6 сар буюу 180 хоногийн хугацаанд 90 хоног өнгөрмөгц Чех Улсад буцаж орж ирэх, эсвэл Шенгений бүс нутгаас бүрмөсөн гарах шаардлагатай. Шенгений бүс нутгаар сүүлийн 180 хоногийн дотор зорчсон нийт хугацаа 90 хоногоос хэтэрч болохгүй гэсэн дүрэм үйлчилдэг гэсэн үг юм.

Шенгений бүс нутгаар зорчиж, оршин сууж болох дээд талын хугацааг албан ёсны бус тооны машинаар тооцож болно:

<https://ec.europa.eu/assets/home/visa-calculator/calculator.htm?lang=en>

(тооны машин ашиглах заавар: www.ec.europa.eu/dgs/home-affairs/what-we-do/policies/borders-and-visas/border-crossing/docs/short_stay_schengen_calculator_user_manual_en.pdf).

Оршин суух хугацааг шалгахын тулд Planning функцийг сонгоно.

Шенгений бүс нутагт хамаарахгүй ЕХ-ы орнуудад зорчих талаарх мэдээллийг тухайн орны дипломат төлөөлөгчийн газраас лавлана уу. Тухайн улсын хилээр нэвтрэх, түүнчлэн нисэх онгоцны буудлын дамжин өнгөрөх хэсэгт орохын тулд виз шаардагддаг байж магадгүй.

Чех Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газрын жагсаалтыг Гадаад харилцааны яамны www.mzv.cz цахим хуудаснаас үзэх боломжтой.

Шенгений мэдээллийн систем – СИС (SIS)

Шенгений мэдээллийн систем (SIS) нь эрүүгийн хариуцлагад татах ажиллагааны хүрээнд эрэн сурвалжлагдсан, Шенгений бүс нутгийн хилээр нэвтрэх, оршин суух эрхгүй, сураггүй болсон хүмүүс болон хулгайд алдсан, гээгдүүлсэн бичиг баримтын талаар мэдээлэл солилцоход зориулагдсан болно.

Аль нэг улсын нутаг дэвсгэрт хууль зөрчсөн тухай мэдээллийг SIS-д оруулсны улмаас Шенгений бусад орнуудын хилээр нэвтрэх, оршин суухыг хориглоход хүрч болзошгүй.

Шенгений бүс нутгийн орнуудад ажил эрхлэх, орлого олох зорилгоор үйл ажиллагаа явуулах

Чех Улсад ажил эрхлэх, орлого олох зорилгоор үйл ажиллагаа явуулахад авсан эрх нь зөвхөн Чех Улсад л үйлчилнэ. Шенгений бүс нутгийн бусад орнуудад үйлчилдэг дүрмийг тухайн улс орноос лавлах шаардлагатай.

Зохих зөвшөөрөлгүй ажиллаж, орлого олох зорилгоор үйл ажиллагаа явуулсан бол тухайн орны хуулийг зөрчсөнд тооцно гэдгийг анхаарна уу.

ЧЕХ УЛСАД БОГИНО ХУГАЦААГААР ЗОРЧИХ

Европын Холбооны гишүүн бус орноос хүн урих гэж байгаа тохиолдолд уг этгээд нь БНЧУ-ын дипломат төлөөлөгчийн газарт Чех Улсад 90 хүртэл хоногийн хугацаагаар зочлох эрх олгодог **богино хугацааны буюу Шенгений виз мэдүүлэх** боломжтой. Мэдүүлгийг элчин сайдын яам хянан шийдвэрлэх ба богино хугацааны визээр зорчсон иргэний тус улсад оршин суух хугацааг сунгуулах асуудлыг Гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн цагдаагийн газар шийддэг.



Чех Улсад хүн урих өөр нэг зам нь “Урилга” явуулах. Уригч этгээд урилгын маягт бөглөж, Гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн цагдаагийн газраар баталгаажуулна. Баталгаажуулсан урилга нь уригдаж буй этгээдийн БНЧУ-ын дипломат төлөөлөгчийн

газарт богино хугацааны виз мэдүүлэхдээ Чех Улсад зорчих зорилгын үндэслэл нотолгоо болно.

Богино хугацааны виз олгох журмын тухай дэлгэрэнгүй мэдээллийг Дотоод хэргийн яамны www.mzv.cz цахим хуудасны “Чех Улсын хилээр нэвтрэх, оршин суух” хэсгээс үзнэ үү.

ГЭР БҮЛИЙН ГИШҮҮД

Гадаадын иргэний гэр бүлийн гишүүдийн Чех Улсад оршин суух нөхцөл болзол

Танай гэр бүлийн гишүүд Чех Улсад 90-ээс дээш хоногоор оршин суух хүсэлтэй тохиолдолд нөхцөл байдлаас шалтгаалан удаан хугацааны виз эсвэл удаан хугацааны оршин суух зөвшөөрөл мэдүүлэх эрхтэй. Оршин суух эрхийн төрлөөс хамааран бүрдүүлэх материал, хүсэлтийг хянан шийдэх хугацаа, Чех Улсад эдлэх эрх, үүрэг өөр өөр байдаг.

Удаан хугацааны визийг 1 жилээс дээшгүй хугацаагаар олгодог ба дараа нь удаан хугацааны оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргах боломжтой. Танай гэр бүлийн гишүүдийн оршин суух зөвшөөрлийн хугацаа таны авсан оршин суух зөвшөөрлийн төрлөөс (удаан хугацааны эсвэл байнга оршин суух зөвшөөрөл) хамаарах бөгөөд зөвшөөрлийг 2 жилээс дээшгүй хугацаагаар олгодог.

Гэр бүлийн шалтгаанаар удаан хугацааны оршин суух зөвшөөрөл авсан гадаадын иргэн хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл, ажилтны болон цэнхэр карт авах шаардлагагүйгээр тус улсын хөдөлмөрийн зах зээлд чөлөөтэй нэвтрэнэ. Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тухай мэдээллийг Чех Улсын Хөдөлмөрийн товчооноос, ажилтны эсвэл цэнхэр картын тухай мэдээллийг БНЧУ-ын Дотоод хэргийн яамнаас тус тус авна.

Танай гэр бүлийн гишүүд Чех Улсад 90-ээс дээш хоногийн хугацаагаар оршин суухын тулд БНЧУ-ын дипломат төлөөлөгчийн газарт дараах төрлийн виз мэдүүлж, зөвшөөрөл авах хүсэлтээ гаргана. Үүнд,

“Гэр бүлийн” шалтгаанаар олгодог удаан хугацааны виз

“Гэр бүлийн” шалтгаанаар олгох визийн хариуг БНЧУ-ын дипломат төлөөлөгчийн газраас мэдэгдэж, гадаад паспортын хуудсанд визийн наалт нааж өгнө. Удаан хугацааны виз авсан гадаадын иргэн Чех Улсын хилээр орж ирснээсээ 3 хоногийн дотор Гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн цагдаагийн газарт бүртгүүлэх үүрэгтэй.

Чех Улсад гэр бүлийн гишүүд нэг дор амьдрах зорилгоор олгодог удаан хугацааны зөвшөөрөл

Энэ төрлийн зөвшөөрлийг таны эхнэр, 18-аас доош насны хүүхэд, өөрийгөө тэжээх чадваргүй насанд хүрсэн хүүхэд, эрүүл мэндийн шалтгаанаар өөрийгөө асрах боломжгүй 65-аас дээш насны ганц бие гадаадын иргэн гэх мэт тантай нэг дор Чех Улсад удаан хугацаагаар амьдрах хүсэлтэй гэр бүлийн гишүүд гаргана.

Хэрэв та удаан хугацааны эсвэл байнга оршин суух зөвшөөрөлтэй, тус улсад 15 сараас доошгүй хугацаанд амьдарсан бол танай гэр бүлийн гишүүд гэр бүлийн шалтгаанаар удаан хугацааны оршин суух зөвшөөрөл авах боломжтой. Хорин нас хүрсэн эхнэр, нөхөр хоёр аль нэгэндээ нь гэр бүлийн шалтгаанаар оршин суух зөвшөөрөл хүсэх эрхтэй. Энэ дүрэм ажилтны карттай гадаадын иргэдийн гэр бүлийн гишүүдэд хамаарахгүй. Ажилтны карттай гадаадын иргэн тус улсад 6 сараас дээш хугацаанд амьдарч байгаа тохиолдолд гэр бүлийн гишүүд нь гэр бүлийн шалтгаанаар удаан хугацааны оршин суух зөвшөөрөл авах эрхтэй.

Гадаадын иргэний гэр бүлийн гишүүд виз авах шаардлагагүй бол удаан хугацааны оршин суух зөвшөөрөл авах хүсэлтийн хариу нааштай гарсан даруйд Чех Улсад зорчиж болно. Чех Улсын нутаг дэвсгэрт орж ирсний дараа Дотоод хэргийн яамны зохих хэлтэст бүртгүүлж, оршин суух үнэмлэх авахад шаардагдах биеийн давхцахгүй өгөгдөл авахуулна. Үнэмлэх бэлэн болмогц мөн хэлтсээс очиж авна.

Гадаадын иргэний гэр бүлийн гишүүд виз авах шаардлагатай тохиолдолд БНЧУ-ын дипломат төлөөлөгчийн газраас “оршин суух зөвшөөрлөө биечлэн хүлээн авах зорилгоор 90-ээс дээш хоногийн виз” (D/VR төрлийн виз) олгоно. Ийм тохиолдолд ч танай гэр бүлийн гишүүд Чех Улсад ирснээс ажлын 3 хоногийн дотор Дотоод хэргийн яамны зохих хэлтэст бүртгүүлэх үүрэгтэй. Заасан хугацааг хэтрүүлэх нь хүсэлтийг хянан шийдвэрлэх ажиллагааг зогсоох буюу оршин суух зөвшөөрөл олгохоос татгалзах үндэслэл болно.

Танай гэр бүлийн тус улсад хамтдаа нэг дор амьдарахад хүрэлцэх орлоготой эсэхээ хүсэлт гаргахаасаа өмнө сайтар бодож тооцоолох нь зүйтэй. Учир нь оршин суух зөвшөөрлийн хүсэлтийг боловсруулах явцад та өөрийнхөө орлогын хэмжээг хуульд зааснаар үнэн зөв нотлох шаардлагатай болно.

Удаан хугацааны виз мэдүүлэх, удаан хугацааны оршин суух зөвшөөрөл авах хүсэлтийн хариу гарах хугацааг Гадаадын иргэд Чех Улсад оршин суух тухай хуульд заасан байх бөгөөд бусад мэдээллийг БНЧУ-ын Дотоод хэргийн яамны (www.mvcr.cz/cizinci) цахим хуудаснаас үзэх боломжтой.

ХУРААНГУЙЛВАЛ

Чех Улсад орж ирсэн гадаадын иргэн 3 хоногийн дотор харьяаллын дагуух Гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн цагдаагийн газарт, удаан хугацааны эсвэл байнга оршин суух зөвшөөрлөө биечлэн авах зорилгоор D/VR төрлийн визээр Чех Улсад орж ирсэн гадаадын иргэн мөн 3 хоногийн дотор Дотоод хэргийн яамны зохих хэлтэст бүртгүүлэх үүрэгтэй. Зочид буудал, оюутны байранд байрлавал буусан газар нь бүртгүүлдэг тул өөрийн биеэр очиж бүртгүүлэх шаардлагагүй. Түүнчлэн 15 нас хүрээгүй хүүхдүүд бүртгүүлдэггүй. АНХААР! Гадаадын иргэн удаан хугацааны эсвэл байнга оршин суух зөвшөөрлөө биечлэн хүлээж авах зорилгоор D/VR төрлийн визээр Чех Улсад орж ирсэн тохиолдолд улсын хилээр нэвтэрсэн өдрөөсөө хойш ажлын 3 хоногийн дотор Дотоод хэргийн яамны холбогдох хэлтэст биечлэн очоогүй тохиолдолд хүсэлт хянан шийдвэрлэх ажиллагааг зогсооно.

Гадаадын иргэн удаан хугацааны виз эсвэл оршин суух зөвшөөрөл авах үндэслэл болсон зорилгоо тус улсад амьдрах бүхий л хугацааны туршид даган мөрдөж, өөрчлөхгүй байх үүрэгтэй.

Гадаадын иргэн Чех Улсад амьдрах хугацаандаа овог, гэр бүлийн байдал, паспорт эсвэл оршин суух зөвшөөрөлийн мэдээлэлд өөрчлөлт орсон тухайгаа ажлын 3 хоногийн дотор мэдэгдэх үүрэгтэй.

Мөн түүнчлэн Чех Улсад оршин суугаа хаяг (гэрийн хаяг) өөрчлөгдсөн тухайгаа 30 хоногийн дотор мэдэгдэх үүрэгтэй.

Ямар нэгэн өөрчлөлтийг нотлох баримт бүрдүүлсний үндсэн дээр мэдэгдэнэ. Өөрчлөлт гарсан тухайгаа цаг тухайд нь мэдэгдээгүй тохиолдолд мөнгөн торгууль ногдуулна.

Хуульд заасан хугацааг ягштал баримтлах нь чухал. Учир нь Чех Улсад албан газартай харилцах үед тогтоосон цаг, хугацааг хатуу мөрдөх дүрэм үйлчилдэг.

Гадаадын иргэн оршин суух зөвшөөрлийн үнэмлэх олгуулах зорилгоор биеийн давхцахгүй өгөгдөл авахуулах үүрэгтэй.

Гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн цагдаагийн газраас гадаадын иргэдийн дунд бичиг баримтын шалгалт явуулах үед хүчин төгөлдөр гадаад паспорт, оршин суух зөвшөөрлийн үнэмлэх, эрүүл мэндийн даатгалын баримт, түүнчлэн гэрээт даатгалтай байвал даатгалын төлбөрийн баримтаа шалгуулах үүрэгтэй.

МЭДЭЭЛЭЛ, ТУСЛАЛЦАА

Богино хугацааны виз олгох:

БНЧУ-ын Гадаад харилцааны яам: БНЧУ-ын дипломат төлөөлөгчдийн газар
www.mzv.cz

Оршин суух зөвшөөрөлтэй холбогдох аливаа асуудал, оршин суух зөвшөөрөл сунгуулах, өөрчлөлт гарсан тухай мэдэгдэх, хүсэлт гаргахдаа хамт бүрдүүлэх бичиг баримт:

БНЧУ-ын Дотоод хэргийн яамны Орогнол, шилжин суурьшилтын газрын хэлтэс, салбарууд (ОАМП/ОАМР), гадаадын иргэдийн оршин суух асуудал эрхэлсэн хэлтсүүд www.mvcr.cz/cizinci – эндээс Дотоод хэргийн яамны бүс нутаг дахь хэлтэс, салбарын хаяг, холбоо барих тухай мэдээллийг олж авч болно.

Лавлагаа авах: Дотоод хэргийн яамны лавлах утас: **(+420) 974 820 680**

Оршин суух зөвшөөрлийн хяналт, урилга баталгаажуулалт, тус улсад ирсэн гадаадын иргэдийн бүртгэл

Гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн цагдаагийн газар

www.policie.cz/clanek/informace-pro-poby-t-cizincu.aspx

Үнэ төлбөргүй мэдээлэл, зөвлөгөө өгөх үйлчилгээ:

Интеграцчилалын төвүүд – www.integracnicentra.cz

Төрийн бус ашгийн бус байгууллагууд (ТББ) – www.cizinci.cz – хаяг, холбоо барих мэдээллийн жагсаалт

Холбоо барих зарим байгууллагуудын харилцах утас, хаягийг товхимлын

Холбоо барих хэсгээс үзнэ үү.



БОЛОВСРОЛ, СУРГУУЛЬ,
ГАДААДАД ЭЗЭМШСЭН
БОЛОВСРОЛЫГ ХҮЛЭЭН
ЗӨВШӨӨРӨХ

Прага хотод орших бага сургуулийн барилгын гадна фасад

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУД

Боловсрол, сургууль, сургуулийн жагсаалт, гадаадад эзэмшсэн боловсролыг хүлээн зөвшөөрөх, мэдээлэл, хууль эрх зүйн асуудал

Боловсрол, залуучууд, биеийн тамирын яам

Боловсролын салбарт үйлчилдэг хууль тогтоомжийн мөрдөлтийг хянах, хяналтын үйл ажиллагаа явуулах

Чехийн боловсролын хяналтын газар

Аймаг дахь байгууллагууд (аймгийн захиргааны дэргэдэх боловсролын хэлтэс)

Хот, тосгон, суурин газрын байгууллагууд (хот, тосгон, суурин газрын захиргааны боловсролын хэлтэс)

ЧЕХ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦОО

Боловсрол, залуучууд, биеийн тамирын яам нь Чех Улсын боловсролын салбарыг боловсролын тогтолцооны түвшин тус бүрт боловсрол эзэмших үе шатчилсан үйл явцыг тогтоосон Боловсролын тухай хууль, Их, дээд сургуулийн тухай хуулийн хүрээнд удирддаг.

Чех Улсын боловсролын тогтолцоо дараах түвшнээс бүрддэг: бага, дунд, техник мэргэжлийн дунд (мэргэжлийн үнэмлэхтэй), бүрэн дунд, гүнзгий мэргэших, дээд боловсрол

Чех Улсад дараах төрлийн сургуульд байдаг. Үүнд,

- цэцэрлэг;
- бага сургууль;
- дунд сургууль: лицей, мэргэжлийн дунд сургууль, техник мэргэжлийн сургууль;
- хөгжим бүжгийн дунд сургууль (коллеж);
- гүнзгий мэргэших сургууль;
- урлагийн сургууль (урлагийн олон төрлийн чиглэлээр төрөлжсөн сургалт явуулдаг, БЗБТЯ-ны харьяа сургууль боловч боловсролын тогтолцоонд ордоггүй);
- хэлний хичээлээр улсын шалгалт авах эрх бүхий хэлний сургууль;
- их, дээд сургууль.

Аль байгууллагад харьяалагдаж байгаагаасаа хамааран суруулиуд улсын, нийтийн, хувийн, шашны гэж хуваагддаг. Улсын эсвэл нийтийн сургуулиас бусад сургуулийн сургалт төлбөртэй.

Цэцэрлэг, бага, дунд сургуулийн хичээлийн шинэ жил 9 дүгээр сард эхэлж, дараа жилийн 6 дугаар сард дуусдаг. Зуны амралт 7, 8 сард нийтдээ хоёр сар үргэлжилдэг. Их, дээд сургуулийн хичээлийн шинэ жилийн эхлэх, дуусах өдрийг тухайн их, дээд сургуулийн захирал (ректор) тогтоох бөгөөд ихэвчлэн 10 дугаар сарын 1-ний өдрөөс дараа жилийн 9 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл үргэлжилдэг.

СУРГУУЛИЙН ӨМНӨХ НАСНЫ БОЛОВСРОЛ

Цэцэрлэгт (чех ярианы хэлээр “школка” гэж нэрлэх нь олонтгоо) 3-аас 6 хүртэлх насны хүүхдүүдэд сургуулийн өмнөх насны боловсрол эзэмшүүлдэг. Бага сургуульд орохын өмнөх нэг жилээс бусад хугацаанд нь хүүхэд цэцэрлэгт сайн дураараа явна. Тухайн хуанлийн жилийн 8 сарын сүүл гэхэд 5 нас хүрсэн хүүхэд заавал цэцэрлэгт орсон байна.


Цэцэрлэг улсын, аймгийн, хот, тосгон, суурин газрын эсвэл хувийн байдаг тул төлбөртэй, төлбөргүй гэсэн хоёр янз байдаг. Хүүхдийн хоолны мөнгийг цэцэрлэгийн төрлөөс үл хамааран төлнө (хүүхдийн цэцэрлэгт явсан өдрийн хоолны төлбөр).

Хүүхдээ цэцэрлэгт оруулахын тулд бүртгүүлнэ. Сүүлийн жилүүдэд цэцэрлэгийн эрэлт хэрэгцээ маш их болсон тул хүүхдээ бүртгүүлэх асуудлыг цагийг нь тулгалгүй эрт эхлэх нь зөв. Цэцэрлэгийн бүртгэл ихэвчлэн хавар явагддаг бөгөөд бүртгэл явагдах тодорхой өдөр, газрыг тухайн цэцэрлэгийн захирал тогтооно. Энэ тухайгаа цэцэрлэгийн болон хот, дүүрэг, тосгоны захиргааны цахим хуудсанд урьдчилан мэдээлдэг.

БАГА СУРГУУЛЬ – ЗААВАЛ ЭЗЭМШИХ БОЛОВСРОЛ

Заавал эзэмших боловсрол нь цэцэрлэгийн 1 жил дээр бага сургуулийн 9 жилийг нэмэхээр нийлээд 10 жил болно. Эрүүл мэндийн, оюун ухааны хөгжил бүрэн хөгжөөгүй үндэслэлээр хүүхдээ сургуульд орохыг нь хойшуулах зөвшөөрөл аваагүй л бол 6 нас хүрсэн хүүхэд сургуулийн нэгдүгээр ангид элсэн орно. Заавал эзэмших боловсрол нь Чех Улсын иргэд, чех хэл мэддэг үгүйгээс үл хамааран тус улсад 90-ээс дээш хоногоор оршин суух зөвшөөрөл авсан гадаадын иргэдэд ч хамаатай.

Эцэг эх нь 6-15 хүртэлх болон 17-аас дээшгүй насны хүүхдээ бага сургуулийн боловсрол заавал эзэмшүүлэх үүднээс сургуульд сургах үүрэг хүлээдэг. Хүүхдээ сургуульд явуулаагүй эцэг эх эсвэл хууль ёсны төлөөлөгчийг хууль зөрчсөнд тооцож хариуцлага хүлээлгэнэ.



Чех Улсад оршин суудаг гадаадын иргэн суурь боловсрол эзэмших эрхтэй. Бага сургуульд элсэх үед Чех Улсад оршин суух үндэслэлтэй эсэхийг нотлох албагүй.

Хуулиар хүн бүрийн улсын, нийтийн, бага, дунд сургуульд үнэ төлбөргүй боловсрол эзэмших эрхийг хангадаг. Хувийн сургуулийн сургалт төлбөртэй.

Сургуулийн зүгээс санал болгодог өдрийн хоол, чөлөөт цагаа өнгөрүүлэх дугуйлан, секц, өдөр өнжүүлэх зэрэг нь төлбөртэй.

Бага сургуулийн бүртгэл жил бүрийн 4 дүгээр сарын 1-30-ны хооронд явагддаг бөгөөд зарласан хугацаанд багтаж хүүхдээ бүртгүүлэх нь чухал. Чех Улсад ирсэн даруйдаа хүүхдээ оруулах сургуулийн талаар аль болох тодорхой мэдээлэл олж авахыг хичээ. Бага сургуулиуд мэдээллийн самбарт эсвэл цахим хуудсанд бүртгэлийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг урьдчилан тавьдаг.

Зарим сургуулиас гадаадын хүүхдүүдэд зориулж чех хэлний дамжаа хичээллүүлдэг. Зарим ТББ, интеграцчилалын төв, хэлний сургуулиудаас зохион байгуулдаг чех хэлний дамжаанд хамрагдах боломжтой. Боловсролын чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг ТББ багш нартай харьцах, хүүхдүүдийн тань боловсролын асуудлыг шийдэхэд танд туслалцаа үзүүлнэ.

Чех Улсад суурь боловсрол эзэмшснийг бага сургуулийн 9-р ангийг амжилттай төгссөн гэрчилгээ нотлоно (дүрмийн бусад онцгой тохиолдлын талаарх мэдээллийг холбогдох ТББ эсвэл интеграцчилалын төвүүдээс авах боломжтой).

ДУНД БОЛОВСРОЛ

Бага сургуулиа дүүргэх эсвэл заавал эзэмших суурь боловсрол эзэмшсний дараа дунд сургууль (лицей, мэргэжлийн дунд сургууль, техник мэргэжлийн сургууль) эсвэл хөгжим бүжгийн дунд сургуульд элсэн суралцах боломжтой бөгөөд эдгээр нь заавал эзэмших боловсролд хамаарахгүй.

Дунд сургуулиуд нь суралцагсдын олж авах дараагийн шатны боловсрол, мэргэжил, ажлын талбарт гарахад ихээхэн үүрэг гүйцэтгэдэг. Төгсөгчид нь сургуулийн төрөл, сурч буй мэргэжлээсээ хамааран дунд (өдрийн сургалттай 1-2 жилийн хөтөлбөр), мэргэжлийн үнэмлэх олгодог дунд (өдрийн сургалттай 2-3 жилийн хөтөлбөр) эсвэл улсын шалгалтаар төгссөн бүрэн дунд (өдрийн сургалттай 4 жилийн хөтөлбөр) боловсрол эзэмшдэг.

Их, дээд болон гүнзгий мэргэших сургуульд заавал дунд сургууль төгсөх улсын шалгалт (чех хэлээр “матурита”) өгч, аттестат авсны үндсэн дээр элсэн орно. Одоогийн байдлаар бүх төгсөгчид нэгдсэн төгсөх шалгалт өгдөг. Энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг **www.novamaturita.cz** цахим хуудаснаас үзнэ үү.

Сургуулийн төрлөөс хамааран төгсөлтийн гэрчилгээ (бүрэн бус дунд боловсрол), мэргэжлийн үнэмлэх (мэргэжлийн дунд боловсрол) эсвэл бүрэн дунд боловсролын гэрчилгээ (бүрэн дунд боловсрол) авснаар дунд боловсрол эзэмшсэнд тооцно.



ГҮНЗГИЙН МЭРГЭШИХ СУРГУУЛЬ

Энэ төрлийн боловсрол нь дунд боловсролыг цааш нь гүнзгийрүүлж, ерөнхий боловсролоор зогсохгүй мэргэшлийн боловсрол эзэмшүүлж, мэргэжлийн гүнзгийрүүлсэн практик бэлтгэлийг хангаж өгдөг. Өдрийн сургалт нь мэргэжлийн дадлага оролцуулаад 3 жил байдаг бол эрүүл мэндийн салбарын мэргэшлийн сургалт 3,5 жил байдаг.

Нийтийн гүнзгий мэргэших сургуулиудын сургалтын төлбөр 5000 хүртэл чех крон байдаг бол хувийн сургуулийн төлбөрийг гэрээнд заадаг.

Гүнзгий мэргэших сургуулийг төгсөх шалгалт өгч төгсөнө. Төгсөгчдөд “дипломтой мэргэжилтэн” цол олгох бөгөөд энэ цолыг нэрний ард “DiS.” хэмээн товчилж бичдэг.

ИХ, ДЭЭД СУРУУЛЬ

Их, дээд сургуулиуд нь нийтийн, хувийн, улсын (цэргийн, цагдаагийн) гэсэн гурван төрөл байдаг. Ерөнхий боловсролын эсвэл мэргэжлийн бүрэн дунд сургууль (дунд сургууль төгсөх шалгалт өгч, бүрэн дунд боловсролын гэрчилгээ авсан байх) төгсөн, элсэлтийн шалгалтад тэнцсэн тохиолдолд их, дээд сургуульд элсэн суралцана.

Гадаадын иргэн их, дээд сургуульд чех хэл дээр сурах тохиолдолд Чех Улсын иргэдтэй ижил нөхцөлтэй суралцана. Нийтийн болон улсын сургуульд чех хэлээр үнэ төлбөргүй суралцана.

Ихэнх их, дээд сургуулийн элсэлтийн шалгалтад чех хэлний B1 буюу харьцангуй өндөр түвшний мэдлэг шаарддаг. Зарим сургуулиуд чех хэлний мэдлэг тогтоох өөрийн шалгалтыг өөрсдийн тогтоосон журмаар авдаг.

Их, дээд сургуульд чех хэлнээс өөр хэл дээр сурах хүсэлтэй гадаадын иргэд төлбөр төлнө.

Чех Улсын их, дээд сургуулиудад бакалаврын сургалт 3 жил байдаг. Бакалаврын сургалтаа төгсгөөд магистрын сургалтад үргэлжлүүлэн сурах тохиолдолд 2 жил гэдэг ч зарим тохиолдолд 5 эсвэл 5-аас илүү жил байх нь бий.

Их, дээд сургуулийн бакалаврын сургалтыг “бакалавр” зэрэгтэй төгсөж нэрнийхээ өмнө “Bc.”, магистрын сургалтыг “магистр” зэрэгтэй төгсөж нэрнийхээ өмнө “Mgr.” цолыг товчилж бичнэ. Өөр бусад мэргэжлийн сургуулийг “инженер” цолтой төгсөж нэрнийхээ өмнө “Ing.” хэмээн товчилж бичнэ.

ГАДААДЫН ИРГЭН ЧЕХ УЛСАД СУРАЛЦАХ ЗОРИЛГООР ОРШИН СУУХ ТУХАЙ

2019.07.31-ний өдрөөс эхлэн Гадаадын иргэн Чех Улсад оршин суух тухай хуулийн дагуу “сурах” хэмээх томьёоллын босгыг өндөрсгөсөн. “Сурах” гэж их, дээд сургуулийн магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрт хамрагдахыг хэлнэ. Мөн түүнчлэн солилцооны шугамаар дунд, хөгжим бүжгийн дунд болон гүнзгий мэргэших дунд сургуульд дунд боловсрол эзэмших эсвэл гүнзгий мэргэших сургалтад хамрагдахыг хэлнэ. Харин энэ шатны боловсролыг солилцооны шугамаас өөр замаар эзэмшиж байгаа тохиолдолд Гадаадын иргэн Чех Улсад оршин суух тухай хуулийн дагуу “сурах”-ад тооцохгүй. Цаашилбал “сургалт” гэж тэтгэлгээр сурах, мэргэжил дээшлүүлэх, Европын сайн дурын албанд оролцохыг хэлнэ.

Сурах зорилгоор удаан хугацааны виз эсвэл оршин суух зөвшөөрөл авсан гадаадын иргэн тус улсад байх хугацааныхаа туршид **оюутан статустай байх** аваас виз, оршин суух зөвшөөрлийнх нь зорилго бодит байдалтай нийцсэн байх ёстой. Энэ нь сургуульд суралцах зорилгоор олгогдсон виз, оршин суух зөвшөөрлийн хүчинтэй байх нийт хугацаандаа оюутан статустай болох нь үнэн гэсэн сургуулийн тодорхойлолтоор нотлогдоно. **Сургуулийн тодорхойлолт** нь оюутны амралт, шалгалт, төгсөлтийн улсын шалгалт зэрэг сургууль төгсөх хүртэлх хугацааг бүхэлд нь зохих ёсоор багтаасан тодорхойлолтыг хэлнэ.

Гадаадын иргэн сургуульд суралцахын зэрэгцээ ажил хийх, бизнес эрхлэх боломжтой хэдий ч оршин суух гол зорилго буюу өөрөөр хэлбэл сургуульд сурах зорилгоо биелүүлэх үүрэгтэй. Оюутан ямар нөхцөлд ажил хийж болох тухай дэлгэрэнгүй мэдээллийг Хөдөлмөр эрхлэлт бүлгээс үзнэ үү.

Гадаадын иргэн Чех Улсад суралцаж байх хугацаандаа зуныхаа амралтаар гадаад улс руу аялах боломжтой хэдий ч оршин суух асуудалтай нь холбоотой ямар нэгэн ажиллагаа явагдаж байгаа бол тус улсаас түр хугацаагаар гарах болсноо Дотоод хэргийн яамны холбогдох салбар, хэлтэст мэдэгдэж, албан шугамаар ирэх хариу захидлаа хэрхэх асуудлаа зохицуулах шаардлагатай.

Сургуулиа **солих тохиолдолд** эхний сургуулиас зохих ёсоор гарсны дараа шинэ сургуульд шилжих дарааллаар асуудлаа зохицуулна. Таныг сургуулиасаа гарсан тухай мэдээллийг эхний сургууль Дотоод хэргийн яаманд мэдэгддэг тул та зөвхөн өөр сургуульд шилжин суралцах болсон тухайгаа тус яаманд

мэдэгдэх үүрэгтэй. Ямарваа нэг өөрчлөлт гарах бүрд Дотоод хэргийн яамны салбар, хэлтэст 3 хоногийн дотор мэдэгдэхээ мартуузай!

Сургуулиас хасагдах тохиолдолд хуульд зааснаар сургууль энэ талаар Дотоод хэргийн яаманд мэдэгдэх үүрэгтэй тул үүний үндсэн дээр таны виз эсвэл удаан хугацааны зөвшөөрөл хүчингүй болно.

ГАДААДАД ЭЗЭМШСЭН БОЛОВСРОЛ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ

Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой зарим нэг асуудлаар гадаадын иргэнээс диплом, мэргэжлийн ур чадвар, чадамжийн гэрчилгээ шаарддаг. Хэрэв гадаадын иргэн Чех Улсад үргэлжлүүлэн суралцах тохиолдолд гадаадын сургуулиас олгосон бүрэн дунд боловсролын гэрчилгээ (аттестат), диплом зэрэг боловсрол эзэмшсэн тухай баримт бичгээ хүлээн зөвшөөрүүлэх нь чухал. Ийм төрлийн баримт бичгүүдийг Чех Улсад олгодог баримт бичгүүдтэй ижил түвшинд болгохын тулд албан ёсоор хүлээн зөвшөөрүүлж, хүлээн зөвшөөрснийг гэрчилсэн баталгаа авах шаардлагатай.

Боловсрол эзэмшсэн тухай баримт бичгийг дүйцүүлэн хүлээн зөвшөөрөх гэдэг нь гадаад улсад эзэмшсэн бага, дунд, бүрэн дунд, гүнзгий мэргэших болон дээд боловсролыг Чех Улсад эзэмшдэг боловсролын түвшинтэй ижил болохыг албан ёсоор баталгаажуулахыг хэлнэ.

Бага, дунд, гүнзгий мэргэших сургуулийн аттестат, гэрчилгээг харьяа аймгийн захиргааны боловсролын хэлтэс дүйцүүлэн баталгаажуулдаг. Боловсрол эзэмшсэн тухай гэрчилгээг баталгаажуулахад гадаад гэрчилгээний эх хувь эсвэл баталгаат хуулбар, тухайн сургуулийн сургалтын агуулга, хөтөлбөрийн тухай баримт зэргийг бүрдүүлнэ. Гэрчилгээ тодорхой биш тохиолдолд тухайн сургууль нь тухайн улсад бүртгэлтэй, хүлээн зөвшөөрөгдсөн тухай баримтыг нэмж бүрдүүлэх шаардлагатай болдог. Харьяа аймгийн захиргаан дээр маягт бөглөж хүсэлт гаргана. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, Гаагийн хэлэлцээр зэрэг олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол баримт бичгийг баталгаажуулж, чех хэлний албан ёсны орчуулгыг хавсаргана. Гадаадад эзэмшсэн боловсролын агуулга, хөтөлбөр нь чех сургуулиудийн сургалтын агуулга, хөтөлбөртэй нийцсэн нөхцөлд л баталгаажуулна. Огт нийцээгүй тохиолдолд хүсэлтийг шийдэхгүй. Хоёр орны боловсролын агуулга, хөтөлбөр ялимгүй зөрүүтэй эсвэл оюутан баримт бичгээ бүрэн бүрдүүлээгүй бол боловсрол нийцлийн шалгалт өгнө. Боловсрол нийцлийн шалгалтанд тэнцсэн оюутанд протокол өгөх ба оюутан уг протоколыг аймгийн захиргаанд өгч боловсрол нийцлийн баталгаа авна.

Бага, дунд, гүнзгий мэргэших боловсрол эзэмшсэн тухай баримт бичгийг дүйцүүлэн хүлээн зөвшөөрүүлэх хүсэлт гаргахад аймгийн захиргаанд төлбөр төлнө.

Гадаад улсад эзэмшсэн дээд боловсролын баримт бичгийг дүйцүүлэн хүлээн зөвшөөрүүлэх хүсэлтийг агуулгын хувьд ижил төстэй магадлан итгэмжлэгдсэн **нийтийн их, дээд сургуульд** гаргах эсвэл Чех Улстай боловсролын гэрчилгээ харилцан хүлээн зөвшөөрөх олон улсын гэрээ байгуулсан гадаадын их, дээд сургуулийн дипломтой тохиолдолд БНЧУ-ын Боловсрол, залуучууд, биеийн тамирын яаманд хандана.

Гадаадад эзэмшсэн дээд боловсролын баримт бичгийг дүйцүүлэн хүлээн зөвшөөрүүлэх хүсэлт нь төлбөртэй. Төлбөрийг хүсэлт гаргаж буй их, дээд сургуульд төлнө.

Баримт бичгээ баталгаажуулах явцдаа **апостиль, консулын баталгаажуулалт** гэсэн нэр томъёотой тааралдаж магад. Апостиль, консулын баталгаажуулалтын гол зорилго нь баримт бичгийг тухайн улсын хуулийн этгээд, захиргааны байгууллагаас олгосон эсвэл тэдний өмнө үзэглэсэн болохыг гэрчилнэ гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл баримт бичгийн утга агуулга бус, албан газрын тамга тэмдэг, гарын үсгийн үнэн зөвийг гэрчилнэ. Баталгаажуулалт нь хуурамч баримт бичиг үйлдэхээс урьдчилан сэргийлэх үүднээс үнэн зөв болохыг гэрчлэх гол зорилготой.

Баримт бичиг баталгаажуулах тухай дэлгэрэнгүй мэдээллийг Гадаад харилцааны яамны цахим хуудаснаас үзнэ үү.

Боловсрол эзэмшсэн тухай баримт бичгийг хүлээн зөвшөөрөх тухай дэлгэрэнгүй мэдээллийг Боловсрол, залуучууд, биеийн тамирын яамны цахим хуудаснаас үзнэ үү.

СУРГУУЛЬД ХҮҮХДИЙН ДУНД ГАРДАГ ДАРАМТЛАЛ

Хэдийгээр дарамтлал, дээрэлхэлт бол зөвхөн сургуульд биш, зөвхөн сургуулийн хүүхдийг хамарсан асуудал биш боловч өнөө үед сургуульд гардаг хамгийн ноцтой сөрөг үзэгдлийн нэгт тооцдог. Сургуулийн орчинд хүүхдүүд нэг нэгнийгээ дээрэлхэх дарамтлах нь газар авч ноцтой асуудалд хүрээд байгаа бөгөөд ингэж дээрэлхэх дарамтлах нь нийгмийн бусад салбарт ч дэлгэрээд байгаа юм. Олон хүн ажилладаг албан газруудад дээрэлхэлт дарамтлал үүсэх эрсдэлтэй байдаг.

Бусдын биед аюул, гэмтэл учруулах, айлган сүрдүүлэх, доромжлох, биед нь халдахад чиглэсэн үйлдлийг дарамт, дээрэлхэлт гэнэ. Үүнд бусдыг зодох, эд зүйлсийг нь эвдэж гэмтээх зэрэг бие махбодын хэлбэрээр зогсохгүй бусдыг айлган сүрдүүлж эд юмыг нь булаах, хэл амаар доромжлох, нэр төрийг нь гутаан гүтгэх, дээрэлхэх зэрэг сэтгэл

санааны хэлбэр ч багтдаг. Хүүхдүүдийн дунд ийм үзэгдэл ихэвчлэн сургууль дээр, сургуульдаа очих болон гэртээ харих замд, гэрийн ойр орчинд гардаг. Дээрлэхэл дарамтлал хэдийчинээ удаан үргэжилнэ, хохирогчийн бие махбод, сэтгэл санаанд учруулах үр дагавар нь төдийчинээ ноцтой байдаг.

Дарамтлал олон төрлийн хэлбэртэй байхаас гадна дарамтлагчийн хэрэглэдэг арга ч янз бүр байдаг. Дарамтлагч нь ихэнхдээ дарамтлуулж байгаа хүнээс биеэр том, хүч тэнхээ илүү эсвэл эрх мэдлийн хувьд давамгайл байдаг. Дарамтлалын хор уршгийг хохирогч, дарамтлагчийн аль аль нь насан туршдаа амсах хэдий ч хамгийн ноцтойгоор хохирогчид нөлөөлдөг.

Хэрэв таны хүүхэд дарамтлалд өртсөн байж магад тохиолдолд энэ асуудлыг яаралтай шийдвэр нь зөв. Хүүхдээсээ халдлагын талаар асууж аль болох тодорхой мэдээлэл олж аваад сургуулийн захирал эсвэл ангийн багштай нь холбоо барьж биечлэн уулзахыг шаард. Энэхүү товхимлын сүүлийн хэсэгт байгаа интеграцчилалын төвүүд, төрийн бус байгууллагуудын хаяг, утсаар холбоо барьж тэдэнд хандсанаар, танд сургуулийн удирдлага, багш нартай харьцахад туслалцаа үзүүлэх болно.

ГАДААДЫН ИРГЭДИЙН ЧЕХ ХЭЛНИЙ ШАЛГАЛТ, ЧЕХ ХЭЛНИЙ ДАМЖАА

Чех Улсад байнга оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргахтай зэрэгцүүлэн чех хэлний А2 түвшний шалгалт, Чех Улсын харьяат болох тохиолдолд В1 түвшний шалгалт өгдөг. Чех хэлний шалгалтад бэлдэхэд ТББ, интеграцчилалын төвүүд эсвэл хэлний сургуулиуд танд туслалцаа үзүүлэхээс гадна уг шалгалтад бэлтгэх зориулалтын сурах бичиг, гарын авлага зэргийг ашиглаж, мөн шалгалтад туршилтын журмаар орох боломжтой.



Дэлгэрэнгүй мэдээллийг www.cestina-pro-cizince.cz цахим хуудаснаас үзнэ үү.

Чех хэлний дамжаанд суралцах нь таныг Чех Улсад зохицоход тодорхой хэмжээгээр өөрийн гэсэн хувь нэмрээ оруулдаг. Хэлний сургуулиудаас явуулж буй төлбөртэй дамжаанаас гадна хөтөлбөрт нь чех хэлний хичээл багтдаг зарим их, дээд сургуулиудын элсэлтийн эсвэл бэлтгэл ангийн сургалтад хамрагдах боломжтой. Мөн төрийн бус байгууллагууд, интеграцчилалын төвүүдээс чех хэлний дамжааны талаарх мэдээллийг лавлах боломжтой. Ийм дамжаа үнэ төлбөргүй эсвэл бага хэмжээний төлбөртэй байдаг.

МЭДЭЭЛЭЛ, ТУСЛАЛЦАА

Сургууль, боловсрол, сургуулийн жагсаалт, гадаадад эзэмшсэн боловсролыг хүлээн зөвшөөрөх, мэдээлэл, хууль эрх зүй:

Боловсрол, залуучууд, биеийн тамирын яам

www.msmt.cz

Гадаадад эзэмшсэн боловсролыг дүйцүүлэн хүлээн зөвшөөрөх:

- Аймгийн захиргааны боловсролын хэлтэс
- Нийтийн их, дээд сургуулиуд

Боловсрол, залуучууд, биеийн тамирын яам (БЗБТЯ)

Их, дээд боловсролын газар эсвэл боловсролын тогтолцооны газар

Karmelitská 7, 118 12 Praha 1

www.msmt.cz/mezinarodni-vztahy/uznavani-vzdelani

Нийгмийн асуудлаар зөвлөх үйлчилгээ, туслалцаа үзүүлдэг төрийн бус ашгийн бус байгууллага, интеграцчилалын төвүүд

“МЕТА” төрийн бус ашгийн бус байгууллага

Чех хэлний дамжаа явуулах, боловсролын асуудлаар зөвлөгөө өгөх, багш нартай харьцах, хүүхэд сургуульд бүртгүүлэх, боловсролын бичиг баримт хүлээн зөвшөөрөх зэрэг асуудлаар туслалцаа үзүүлдэг

www.meta-ops.cz

Гадаадын иргэдэд зориулсан чех хэлний сургалт:

www.cestina-pro-cizince.cz



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Уран барималч Давид Черныгийн бүтээл Франц
Кафкагийн хөдөлдөг хөшөө, Прага хот

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУД

БНЧУ дахь хөдөлмөр эрхлэлт, мэдээлэл, хөдөлмөр зуучлалын төвүүд (гадаадын иргэдэд хамаарах) ажлын байр

Хөдөлмөр, нийгмийн хэргийн яам

Ажилтны карт олгох

БНЧУ-ын Дотоод хэргийн яамны Орогнол, шилжин сууршилтын бодлогын газар (чехээр “ОАМП” гэж нэрлэнэ), Гадаадын иргэдийн оршин суух асуудал эрхэлсэн хэлтэс

Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, хөдөлмөр эрхлэхтэй холбогдох албан бичиг гаргах

Чех Улсын Хөдөлмөрийн товчоо

Ажлын нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах асуудлаар гарсан гомдлын үндсэн дээр хяналт явуулах

Хөдөлмөр хяналтын газар

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛД НЭВТРЭХ

Чех Улсын хөдөлмөрийн зах зээлд саадгүй нэвтрэхийн тулд хүчин төгөлдөр оршин суух зөвшөөрөлтэй байна. Үүнээс гадна хөдөлмөрийн зах зээлд чөлөөтэй нэвтрэх боломжтой эсэх, хөдөлмөр эрхлэхэд ямар нэг зөвшөөрөл хэрэгтэй эсэхийг судалж мэдэх нь нэн чухал.



Хөдөлмөрийн зах зээлд чөлөөтэй нэвтрэх болох эсэх нь оршин суух зөвшөөрлийн төрөл, хөдөлмөрийн төрөл, өөр бусад нөхцөл байдлаас шалтгаална.

Хөдөлмөрийн зах зээлд дараах хүмүүс чөлөөтэй нэвтрэнэ. Үүнд,

- ЕХ-ы гишүүн орны иргэд, тэдний гэр бүлийн гишүүд,
- байнга оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэд,
- орогнол эсвэл нэмэлт хамгаалал гэх мэт олон улсын хамгаалалд хамрагсад,
- байнга, удаан хугацааны оршин суух зөвшөөрөл эсвэл орогнох эрх авсан гадаадын иргэнтэй гэр бүл нэгтгэх зорилгоор авсан хүчин төгөлдөр бүхий удаан хугацааны оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэд,
- мэргэжлээрээ тасралтгүй суралцаж байгаа гадаадын иргэд (өдрийн сургалттай дунд, хөгжим бүжгийн дунд сургууль, гүнзгий мэргэших болон улсын шалгалт авах эрх бүхий хэлний сургууль, өдрийн сургалттай их, дээд сургуулийн оюутнууд),
- Чех Улсын боловсролын тухай хуулийн дагуу дунд, хөгжим бүжгийн дунд сургууль, гүнзгий мэргэших сургууль дүүргэж боловсрол эзэмшсэн, их, дээд сургуулийн тухай хуулийн дагуу дээд боловсрол эзэмшсэн гадаадын иргэд

Дээр дурдсан гадаадын иргэд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл, ажилтны эсвэл цэнхэр карт авалгүй хөдөлмөр эрхлэх боломжтой. Ажил олгогч БНЧУ-ын Хөдөлмөрийн товчооны аймгийн салбарт гадаадын иргэнийг ажилд авсан тухайгаа оройтлоо гэхэд ажилд орсон эхний өдөр мэдэгдэхээс өөрөөр ямар нэгэн үүрэг хүлээхгүй.

Та Чех Улсын хөдөлмөрийн зах зээлд чөлөөтэй нэвтрэх эрхтэй эсэх мэдээллийг оршин суух цахим үнэмлэхээс тодруулах боломжтой. Таны үнэмлэхэд “Хөдөлмөрийн зах зээлд чөлөөтэй нэвтрэх эрхтэй эсэх: ТИЙМ” гэж заасан тохиолдолд өөр нэмэлт зөвшөөрөл шаардлагагүй гэсэн үг. Харин таны үнэмлэхэд “Ажилтны карт” гэж заасан тохиолдолд та Чех Улсад хөдөлмөр эрхлэх зорилгоор оршин суух зөвшөөрөл авсан тул хөдөлмөрийн зах зээлд чөлөөтэй нэвтрэх эрхтэй эсэхийг заадаггүй.

Хэрэв ажил олгогч хөдөлмөрийн зах зээлд чөлөөтэй нэвтрэх боломжгүй гадаадын иргэнийг ажиллуулах (цахим үнэмлэхэд “ҮГҮЙ” гэж заасан) тохиолдолд хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ байгуулахаас гадна гадаадын иргэн нь хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл, ажилтны эсвэл цэнхэр карт авсан байх шаардлагатай.

АЖИЛТНЫ БОЛОН ЦЭНХЭР КАРТ

Ажилтны карт гэдэг нь хөдөлмөр эрхлэх зорилгоор удаан хугацааны оршин суух зөвшөөрлийн тусгай төрөл юм. Дээд тал нь 2 жилийн хугацаатай оршин суух зөвшөөрөл, хөдөлмөр эрхлэх эрх хосолсон уг картыг тодорхой ажлын байр (албан тушаал)-д зориулан бий болгосон (өөрөөр хэлбэл 1-д 2).

Дараах нөхцөл хангагдсан үед гадаадын иргэний ажилтны карт авах боломж нээгдэнэ. Үүнд,

- ажил олгогч нь ажилтны карт эзэмшигч гадаадын иргэн ажиллаж болох орон тоо суларсан тухай ажлын зар өгсөн,
- сул орон тоонд ЧУ-ын эсвэл ЕХ-ы гишүүн орны иргэн эсхүл хөдөлмөрийн зах зээлд чөлөөтэй нэвтэрч болох гадаадын иргэн ороогүй,
- гадаадын иргэн тухайн албан тушаалыг хашихад шаардагдах мэргэжлийн шаардлагыг хангасан гэдгээ нотлох өөрөөр хэлбэл уг ажлыг гүйцэтгэх мэргэжлийн ур чадвар эзэмшсэн байна,
- сарын нийт цалин цалингийн доод хэмжээний үндсэн тарифаас доошгүй байна,
- долоо хоногийн ажлын цаг нь хөдөлмөрийн гэрээ эсвэл ажил гүйцэтгэх гэрээнд зааснаар хамгийн багадаа 15 цаг байхаар тодорхойлсон гэх мэт.

Цэнхэр карт нь мэргэжлийн өндөр түвшний ур чадвар шаардсан албан тушаалд ажиллах гадаадын иргэдэд зориулсан оршин суух зөвшөөрлийн нэгэн төрөл юм. Гадаадын иргэн нь Чех Улсын нийт жилийн цалингийн дундаж хэмжээнээс 1,5 дахин өндөр цалин авах, 1 жилээс доошгүй хугацаагаар байгуулсан хөдөлмөрийн гэрээг бүрдүүлнэ.

Ажилтны карт эзэмшигч этгээд ажил, албан тушаалаа солих, өөр алба нэмж хаших тохиолдолд энэ тухайгаа Дотоод хэргийн яамны Орогнол, шилжин суурьшилтын бодлогын газарт дээрх өөрчлөлт гарахаас 30-аас доошгүй хоногийн өмнө зориулалтын маягт бөглөж мэдэгдэх үүрэгтэй. Ийм өөрчлөлт хийх болзлыг хангаж байгаа эсэх хариуг гадаадын иргэнд болон түүний ажил олгогч болох гэж буй этгээдийн аль алинд явуулна. Гадаадын иргэн БНЧУ-ын ДХЯ-аас нааштай хариу авахаас өмнө шинэ албан тушаалд очих, ажлаа солих боломжгүй.

Хэрэв гадаадын иргэн анхны удаа авсан ажлын картын үндсэн дээр Чех Улсад оршин сууж байгаа ба картаа Орогнол, шилжин суурьшилтын бодлогын газраас биечлэн аваад 6 сар болоогүй тохиолдолд ажил, албан тушаалаа солих, өөр алба нэмж хаших боломжгүй.

Ажил олгогч цалингаа өгдөггүй, ажил олгогч татан буулгагдах, эсвэл шилжин нүүх, байгууллагын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орсны улмаас ажилтан орон тооны цомхотголд орох, ажилтан эрүүл мэндийн шалтгаанаар ажлаа үргэлжлүүлэн хийх боломжгүй болох зэрэг тодорхой шалтгаанаар хөдөлмөрийн гэрээг цуцалсан тохиолдолд зургаан сарын дүрэм үйлчлэхгүй. Ийм тохиолдолд гадаадын иргэн өөрчлөлт гарсан тухайгаа мэдэгдэх үедээ хөдөлмөрийн гэрээ дээрх шалтгаанаар дуусгавар болж байгаа болохыг өөрөө нотлох үүрэгтэй.

Ажлын карт гаргуулсан ажил олгогч нь Хөдөлмөр, нийгмийн хэргийн яамны албан ёсны жагсаалтад орсон хөдөлмөр зуучлалын төв байсан тохиолдолд шинэ ажил олгогч нь дахин хөдөлмөр зуучлалын төв болох аваас ажил, албан тушаалаа солих, өөр алба нэмж хаших боломжгүй гэсэн дүрэмтэй.

Хэрэв гадаадын иргэн ажил, албан тушаалаа өөрчлөхгүй зөвхөн ажилтны картын хугацаагаа сунгуулах тохиолдолд БНЧУ-ын Дотоод хэргийн яаманд картын хүчинтэй хугацаа дуусахаас дээд тал нь 120, доод тал нь картын хүчинтэй байх сүүлийн өдөр хугацааг нь сунгуулах хүсэлт гаргана. Ийм тохиолдолд БНЧУ-ын Хөдөлмөрийн товчоо хөдөлмөрийн зах зээл дэх нөхцөл байдлыг харгалзан тухайн гадаадын иргэнийг цаашид ажиллуулах эсэх дүгнэлт гаргана.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ, АЖИЛТНЫ КАРТАД ХАМААРАХ ОНЦГОЙ ТОХИОЛДЛУУД

Гадаадын иргэн хөдөлмөр эрхлэх зорилгоор удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөлтэй байхын зэрэгцээ

- а) хөдөлмөрийн зах зээлд чөлөөтэй нэвтрэх эрхтэй эсвэл
- б) хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авсан тохиолдолд ажилтны карт нь зөвхөн удаан хугацааны оршин суух зөвшөөрөл болно (түүнийг “ажилтны дан эрхэт карт” гэж нэрлэдэг).

Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг БНЧУ-ын Хөдөлмөрийн товчооноос олгодог бөгөөд уг зөвшөөрөл нь хөдөлмөрийн зах зээлд чөлөөтэй нэвтрэх эрхгүй гадаадын иргэнд хөдөлмөр эрхлэх эрх эдлүүлдэг юм. Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг дараах тохиолдолд олгодог. Үүнд,

- гадаад дахь ажил олгогч этгээд нь гадаадын иргэнийг Чех Улсад ажил гүйцэтгүүлэхээр томилсон,
- гадаадын иргэн нь компани, хоршооны гишүүн, хамтрагч, эсвэл удирдлагад багтдаг бөгөөд уг хуулийн этгээдээс явуулж буй үйл ажиллагаатай холбоотой үүрэг даалгавар биелүүлж ажилладаг (ерөнхийдөө “бизнес эрхлэх” зорилгоор удаан хугацааны оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэдэд хамаарна),
- гадаадын иргэн нь хөдөлмөрийн харилцааны хүрээнд мэргэжил дээшлүүлэгч байх гэх мэт.

Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг хөдөлмөрийн зах зээл дэх байдлыг харгалзан удаа дараалан хоёр жилийн хугацаатай сунгах боломжтой. Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлөө сунгуулах хүсэлтээ зөвшөөрлийн хугацаа дуусахаас дээд тал нь 3 сар, доод тал нь

30 хоногийн өмнө Хөдөлмөрийн товчоонд гаргана. Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг ажлын төрөл, байр, ажил олгогч нь өөрчлөгдөөгүй нөхцөлд сунгана.

Удаан хугацааны оршин суух зөвшөөрлийг орлодог ажилтны тусгай карт эзэмшигч гадаадын иргэн нь ажил олгогч, ажлын байраа өөрчлөх болсон тухайгаа Дотоод хэргийн яамны Орогнол, шилжин сууршилтын газарт ажлын 3 хоногийн дотор мэдэгдэх үүрэгтэй.

АЖИЛТНЫ КАРТ ХҮЧИНГҮЙ БОЛОХ

Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй ажилтны карт эзэмшигч нь ажлаа алдсан тохиолдолд хөдөлмөрийн харилцаа дуусгавар болсон шалтгаанаас үл хамааран **60 хоногийн хамгааллын хугацаанд шинэ ажил олох боломжтой.**

60 хоногийн хамгааллын хугацаанд багтаж шинэ ажил олж, өөрчлөлт гарсан тухай амжиж мэдэгдээгүй бол хуульд заасны дагуу хамгааллын хугацаа дуусмагц ажилтны карт шууд хүчингүй болно. Ийм тохиолдолд та өөрийнхөө зардлаар нутаг буцахаас өөр арга замгүй болж болзошгүй.

ГАДААДЫН ИРГЭДИЙГ АЖИЛЛУУЛДАГ АЖИЛ ОЛГОГЧ

Ажил олгогч нь ажлын болон цэнхэр карт эзэмшигч, компани дотроо шилжүүлсэн ажилтны карт эзэмшигч, удаан хугацааны хүчин төгөлдөр визтэй эсвэл зөвшөөрөлтэй, Хөдөлмөрийн товчооноос хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авсан эсвэл зах зээлд чөлөөтэй нэвтрэх эрх бүхий гадаадын иргэнийг зөвхөн хөдөлмөрийн гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ (чех хэлээр “dohoda o pracovni činnosti – DPČ” гэх), ажил гүйцэтгэх гэрээ (чех хэлээр “dohoda o provedeni práce – DPP” гэх) гэх мэт бичгээр байгуулсан ажлын гэрээний үндсэн дээр ажиллуулах боломжтой.

ХУУЛЬ БУСААР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ

Хөдөлмөр хяналт, гаалийн болон гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн цагдаагийн газраас хийдэг гадаадын иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг хянах шалгалтын явцад хөдөлмөр эрхлэх болон оршин суух зөвшөөрөл хүчинтэй эсэхийг хянадаг. Гадаадын иргэн хууль бусаар ажиллаж байгаа нь илэрсэн тохиолдолд ажил олгогч болон гадаадын иргэнд өндөр торгууль ногдуулах ба гадаадын иргэний тус улсад оршин суух зөвшөөрлийг нь үл сунгахаас гадна оршин суух эрхийг нь цуцалж, захиргааны журмаар тус улсаас гаргах үндэслэл болох магадлалтай.

Чех Улсад зохих зөвшөөрөлгүй, хөдөлмөрийн, хөлсөөр ажиллах эсвэл ажил гүйцэтгэх гэрээ байлгуулалгүйгээр хууль бусаар ажиллаж байгаа нөхцөлд ажил олгогчоос цалин хөлсөө тохиролцсон хэмжээнд эсвэл огт авч чадахгүй болох гэх мэтээр таны эрх зөрчигдөх нь олонтоо. Хууль бусаар хөдөлмөр эрхлэх нь олон аюултай эрдсэл дагуулсан маш эмзэг асуудал бөгөөд гадаадын иргэн хууль бусаар хөдөлмөр эрхэлж байсан нь илэрсэн тохиолдолд Чех Улсаас албадан гаргах хүртэл арга хэмжээ авна.

АЖЛЫН БАЙРНЫ САНАЛ

Чех Улс өөрийн хөдөлмөрийн зах зээлээ хамгаалах бодлого явуулдаг. Хөдөлмөрийн зах зээлд Чех Улсын иргэд, ЕХ-ны гишүүн орны иргэд, тэдний гэр бүлийн гишүүд давуу эрх эдэлдэг. ЕХ-оос бусад буюу гуравдагч орны иргэд тус улсын хөдөлмөрийн зах зээлд чөлөөтэй нэвтрэх эрхгүй тул гагцхүү БНЧУ-ын Хөдөлмөрийн товчоонд бүртгэгдсэн ажлын орон тоон дээр ажиллах боломжтой.

Хөдөлмөрийн товчоо ажлын саналыг аймгийн салбар, хэлтсээр дамжуулан зуучилдаг. Гадаадын иргэдэд зориулсан ажлын саналыг Хөдөлмөр, нийгмийн хэргийн яамны цахим хуудасны “Гадаадын иргэдийн хөдөлмөр эрхлэлт” хэсгээс үзэх боломжтой.

Цэнхэр карт

Ажилтны карт

Хөдөлмөрийн товчооноос гадна **хөдөлмөр зуучлалын хувийн компаниуд** ажил зуучилдаг. Хувийн компаниар ажил зуучлуулсан тохиолдолд холбогдох төлбөрийг ажилтан бус, ажил олгогч төлөх дүрэмтэй. Ийм дүрэмтэй хэдий ч зарим компаниуд үүнийг орчуулга, баримт бичгийн баталгаажуулалт, зөвлөгөө гэх мэтчилэн янз бүрээр нэрлэж төлбөрийг ажилтнаас гаргуулахыг хичээсээр байна. Иймд та өөрийнхөө хөөцөлдөж чадах, чадахгүй зүйлээ сайтар эрэгцүүлсний дараа хөдөлмөр зуучлалын компанид хандах нь зүйтэй болов уу. Хөдөлмөр зуучлах эрх бүхий компанийн албан ёсны жагсаалтыг Хөдөлмөр, нийгмийн хэргийн яамны цахим хуудаснаас үзнэ үү. Хөдөлмөр зуучлалын компани нь ажилтны эсвэл цэнхэр карттай, хөдөлмөр эрхлэх зөвшөөрөлтэй гадаадын иргэдийг түр хугацаанд ажил гүйцэтгүүлэхээр өөр ажил олгогч руу явуулах гэх мэтээр хөдөлмөр зуучлах эрхтэй.

ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА, ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭ

Хөдөлмөрийн харилцаа гэж ажилтан, ажил олгогчийн хоорондын эрх зүйн харилцааг хэлдэг. **Хөдөлмөрийн гэрээнд гарын үсэг зурснаар** хөдөлмөрийн харилцааны **эхлэл тавигдаж** ажилд орсон эхний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Хөдөлмөрийн гэрээг хуульд заасан нөхцлийн дагуу эсвэл ажил олгогч, ажилтны хооронд бичгээр үйлдсэн тохиролцооны үндсэн дээр дуусгавар болгодог.

Хөдөлмөрийн гэрээний гарын үсэг зурсан нэг хувийг та ажил олгогчоос шаардаж өөртөө авах нь зүйтэй. Зөвхөн бүрэн ойлгосон гэрээнд гарын үсэг зурахыг анхаарна уу. Хөдөлмөрийн гэрээ нь **ажлын төрөл, ажлын байрны хаяг, ажилд орох өдөр** гэх мэт чухал мэдээлэл агуулахаас гадна гэрээний талууд шаардлагатай гэж үзсэн бусад нөхцлүүдийг ч багтаах ёстой. Жишээлбэл: ажилтан, ажил олгогчийн нэр, ажлын цаг, уг гэрээг хугацаатай эсвэл хугацаагүй байгуулсан эсэх, цалингийн хэмжээ, цалин олгох өдөр, илүү цагийн олговор, амралт, туршилтын хугацаа, томилолт гэх мэт.

Хөдөлмөрийн гэрээг ямагт бичгээр байгуулах шаардлагатай. Хөдөлмөрийн гэрээг цуцлах тухай мэдэгдэл, ажлаас гарах өргөдөл, хөдөлмөрийн гэрээг дуусгавар болох тухай ажил олгогч, ажилтан нарын тохиролцоог ч бичгээр байгуулна.



ТОДОРХОЙ/ТОДОРХОЙ БУС ХУГАЦААГААР БАЙГУУЛСАН ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭ

Хөдөлмөрийн гэрээг тодорхой бус (гэрээнд хөдөлмөрийн харилцаа дуусах огноо заагаагүй) эсвэл тодорхой хугацаагаар (гэрээнд хөдөлмөрийн харилцаа дуусах огноо заасан) байгуулдаг.

Туршилтын хугацаа ихэвчлэн 3 сар байдаг (удирдах ажилтны хувьд 6 сар) хэдий ч хөдөлмөрийн гэрээнд үүнийг заавал заах албагүй. Ажилтан болон ажил олгогч талуудын хэн хэн нь туршилтын хугацааны дотор тодорхой шалтгаан заахгүй хөдөлмөрийн гэрээг цуцлах эрхтэй. Хөдөлмөрийн харилцаа дуусгавар болсон тохиолдолд шинэ ажил олох, Дотоод хэргийн яамны харьяа салбар, хэлтэст ажил олгогчоо өөрчлөх тухай мэдэгдэхэд 60 хоногийн хугацаа байдгийг дахин сануулъя. Энэ үүргээ зөрчсөн тохиолдолд ажилтны карт хүчингүй болж, улмаар гадаадын иргэн Чех Улсад оршин суух эрхээ хасуулах эрсдэлтэй болохыг анхаарна уу.

Бүрэн цагийн ажилтан хуанлийн жилд 160 цагаас доошгүй ээлжийн амралт эдлэх, зарим тохиолдолд (ялангуяа ажил олгогчийн зүгээс) ажлаас халагдсны нөхөн олговор авах эрхтэй.

Хөдөлмөрийн гэрээний хугацааг сунгах, өөр бусад нэмэлт, өөрчлөлт оруулахдаа **нэмэлт гэрээ** байгуулах бөгөөд нэмэлт, өөрчлөлтийг ажилтан, ажил олгогч хоёр тал харилцан хүлээн зөвшөөрсөн байна. Нэмэлт гэрээг зөвхөн **бичгээр** байгуулна.

Хоёр тал зөвшилцсний үндсэн дээр, ажлаас гарах өргөдөл өгсөн (хөдөлмөрийн гэрээ цуцлах, ажлаас гарах тухай 2-оос доошгүй сарын өмнө мэдэгдэнэ), **туршилтын хугацаанд хөдөлмөрийн гэрээг цуцалсан** (ажилтан, ажил олгогч аль ч тал нь шалтгаан заахгүйгээр), **гэрээний хугацаа дууссан, гэрээг нэн даруй цуцлах үндэслэлээр** (зөвхөн хуульд заасан тохиолдолд), **оршин суух зөвшөөрлийн хугацаа дууссан эсвэл уг зөвшөөрөл хүчингүй болсон** тохиолдолд хөдөлмөрийн харилцаа дуусна.

Хөдөлмөрийн гэрээг богиносгосон ажлын цагаар ажиллахаар байгуулж болно. Хүн бүр үндсэн ажлынхаа гадуур хоёр ба түүнээс дээш ажил олгогчдод давхар ажил эрхлэх боломжтой бөгөөд гадаадын иргэнийн хувьд эрхэлж буй хөдөлмөр тус бүртээ хөдөлмөрийн зөвшөөрөл авсан байх шаардлагатай (ажилтны карт эзэмшигч, хөдөлмөрийн зах зээлд чөлөөтэй нэвтэрдэг гадаадын иргэдэд хамаарахгүй).

ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААНААС ГАДУУР БАЙГУУЛСАН ГЭРЭЭНҮҮД

Хөдөлмөрийн харилцаанаас гадуурх гэрээг богино хугацаатай байгуулдаг бөгөөд жишээлбэл тухайн ажилтныг нэг өдрөөр эсвэл долоо хоногоор, эсвэл тодорхой ажил гүйцэтгүүлэхээр томилох эсвэл өөр ажилд шилжүүлэх зэргээр уян хатан нөхцөлөөр ашигладаг. Ийм нөхцөлд ажиллах ерөнхий зарчим нь хөдөлмөрийн харилцаатай ижил эсвэл төстэй байх боловч ажлын цаг, амралт, өвчний чөлөө, эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл зэрэг зарим зүйлээр эрх үүрэг нь тусгайлан зохицуулагддаг. Ийм төрлийн гэрээг ч бичгээр үйлдэх бөгөөд гарын үсэг бүхий гэрээний нэг хувийг ажил олгогчоос заавал авна гэдгийг анхаарна уу.

Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар хөдөлмөрийн харилцаанаас гадуурх гэрээ нь хоёр янз байдаг. Үүнд,

Ажил гүйцэтгэх гэрээ (чех хэлээр “Dohoda o provedení práce – DPP” гэх) – энэ гэрээний дагуу ажил олгогч нь нэг хүнийг жилд 300 цаг ажиллуулах хязгаарлалтай байдаг тул ийм гэрээ нь ажил олгогч нэг этгээдтэй удаан хугацаагаар ажиллах бус харин нэг сарын дотор хэд хэдэн ажил олгогчтой зэрэгцэн цагийн ажил хийдэг хүмүүст илүү тохирдог. Сарын орлого нь 10 000 чех кронаас давсан тохиолдолд ажил олгогч эрүүл мэндийн даатгал, нийгмийн хангамжийн шимтгэл төлөх үүрэгтэй. Ажил гүйцэтгэх гэрээ цуцлахад хөдөлмөрийн гэрээнээс ялгаатай нь 15 хоногийн өмнө мэдэгдэхэд хангалттай.

Үйл ажиллагаа явуулах гэрээ (чех хэлээр “Dohoda o pracovní činnosti – DPČ” гэх) – богиносгосон ажлын цагаар буюу долоо хоногт дээд тал нь 20 цаг ажиллах хязгаарлалтай. Гэрээт цалин 3 500 чех кронаас дээш давбал ажил олгогч хөдөлмөрийн гэрээний нэгэн адил эрүүл мэндийн даатгал, нийгмийн хангамжийн шимтгэлийг төлөх үүрэгтэй. Уг гэрээг бичгээр хугацаатай эсвэл хугацаагүй байгуулна. Ажилтан ээлжийн амралт авах, ажлаас халагдсан тохиолдолд нөхөн олговор авах эрх эдлэхгүй. Ажил гүйцэтгэх гэрээг цуцлахад хөдөлмөрийн гэрээнээс ялгаатай нь 15 хоногийн өмнө мэдэгдэхэд хангалттай.

ЦАЛИН ХӨЛС

Хуульд заасны дагуу долоо хоногт 40 цаг ажилласан тохиолдолд **хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг** авах эрхтэй. Засгийн газрын тогтоолоор тогтоодог хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг Хөдөлмөр, нийгмийн хэргийн яамны цахим хуудаснаас шалгах боломжтой. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь 2023 оны байдлаар сарын 17 300 чех крон буюу нэг цагийн 103,80 чех крон болно.

Хөдөлмөрийн, ажил гүйцэтгэх, үйл ажиллагаа явуулах гэрээ байгуулах явцад нийт болон цэвэр цалин (гарт олгох цалин) гэсэн нэр томьёо тааралдана. **Нийт цалин** гэдэг нь шимтгэл, суутгал суутгахаас өмнөх цалингийн хэмжээг хэлнэ. **Цэвэр цалин** (гарт олгох цалин) гэдэг нь нийт цалингаас орлогын албан татварын 15 хувийн урьдчилгаа, эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг суутгаад үлдсэн мөнгөн дүнг ажилтны банкны дансанд шилжүүлснээр ажилтны орлого болно. Ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд цэвэр цалин бус, нийт цалингийн хэмжээг заадаг. Ажлын байрны заруудад ч нийт цалинг заах нь нийтлэг үзэгдэл.

Нийт болон цэвэр цалин, хуульд заасан журмын дагуу авч буй шимтгэл, суутгалын талаарх мэдээллийг цалингийн цэсэнд ойлгогдохоор тусгадаг.

ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОН НИЙГМИЙН ДААТГАЛ

Ажил олгогч нь ажилтныг эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд хамруулж, ажилтны цалингаас суутгал шимтгэлийг төлнө.

Эрүүл мэндийн даатгалын шимтгэл нийт цалингийн 13,5 хувь болдог ба үүнээс 4,5 хувийг ажилтан, 9 хувийг ажил олгогч төлдөг.

Нийгмийн даатгалын шимтгэл нийт цалингийн 31,5 хувь болдог ба үүнээс 6,5 хувийг ажилтан, 24,8 хувийг ажил олгогч төлдөг.

Ажил олгогч нь таны эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг тогтмол төлөх үүрэгтэй. Эрүүл мэндийн даатгалын үнэмлэхээ ямагт биедээ авч явах шаардлагатай.

ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАРАА ТҮР ХУГАЦААГААР АЛДАХ (ӨВЧНИЙ ЧӨЛӨӨ)

Өвчин, гэмтлийн улмаас хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдсан үед өвчний чөлөө авч гэртээ эмчлүүлэх бөгөөд ийм тохиолдолд эмчид үзүүлж өвчилсөн тухай болон өвчин үргэлжлэх хугацааг заасан өвчний хуудсаа авна. Өвчтэй байх хугацаандаа цалин авахгүй, өвчний даатгалаас олговор авна. Эмч шаардлагатай бичгийг цахим хэлбэрээр шууд таны ажил олгогч, Чехийн нийгмийн хангамжийн асуудал эрхэлсэн газарт (Česká správa sociálního zabezpečení – ČSSZ/ЧССЗ) илгээх бөгөөд та ажил олгогчид өвчтэй болсон тухайгаа зөвхөн утас, мессеж эсвэл и-мэйлээр мэдэгдэх үүрэгтэй.

Жирэмсний болон амаржсаны чөлөө (залгуулаад эцэг, эхийн чөлөө) авсан эхэд ажил олгогч нь төрөхийн өмнө 6 - 8 долоо хоногийн чөлөө өгөх үүрэгтэй. Жирэмсний болон амаржсаны чөлөө нийтдээ нэг хүүхэд төрүүлсэн бол 28, хоёр ба түүнээс дээш ихэр хүүхэд төрүүлсэн бол 37 долоо хоног болно. Ийм нөхцөлд мөн цалин авахгүй, өвчний даатгалын мөнгө авдаг. Даатгалын мөнгө авахын тулд тухайн эмэгтэй жирэмсний болон амаржсаны чөлөө авахаасаа өмнө, сүүлийн 2 жилийн хугацаанд доод тал нь 270 хоног өвчний даатгалд хамрагдсан байх ёстой бөгөөд даатгалаас мөнгө авч эхлэх өдрийн байдлаар ч мөнхүү даатгал нь хүчинтэй байх дүрэм үйлчилдэг.

Хуульд зааснаар эцэг, эх нь өвчтэй хүүхдээ асрах чөлөө авч, гэртээ үлдэх эрхтэй. Ийм тохиолдолд эцэг, эх нь өвчтэй хүүхдээ асрах халамж авах ба тэгэхийн тулд хүүхдийн эмчийн бөглөсөн зориулалтын маягтыг ажил олгогчдоо өгнө.

ОЮУТАН БА АЖИЛ ЭРХЛЭЛТ

Чех Улсын дунд, хөгжмийн дунд сургууль, гүнзгий мэргэших сургууль, их, дээд сургуулийн магадлан итгэмжлэгдсэн өдрийн сургалтын хөтөлбөрт хамрагддаг оюутнууд удаан хугацааны оршин суух зөвшөөрөл, визийн зорилгоос хамааралгүй хөдөлмөр эрхлэх боломжтой. Учир нь эдгээр оюутнууд хөдөлмөрийн зах зээлд чөлөөтэй нэвтрэх эрхтэй байдаг тул ажилтны карт, хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авах шаардлагагүй.

Чех Улсын сургуулийн тухай хуулийн дагуу дунд, хөгжим бүжгийн дунд, гүнзгий мэргэших сургуульд мэргэжил эзэмшсэн эсвэл Их, дээд сургуулийн тухай хуулийн дагуу дээд боловсрол эзэмшсэн оюутнууд хөдөлмөрийн зах зээлд чөлөөтэй орох боломжтой тул ажилтны карт эсвэл хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авах шаардлагагүй. Харин сургуулиа төгссөний дараа Чех Улсад цаашид оршин суух хүсэлтэй тохиолдолд өөр зорилгоор оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргана.

Хөдөлмөрийн зах зээлд чөлөөтэй нэвтрэх эрхтэй оюутнууд дээр дурдсан гэрээнүүдийн дагуу хэд хэдэн ажил олгогчтой зэрэгцсэн хөдөлмөр эрхэлж орлого олох боломжтой. Жишээ нь, нэгээс илүү ажил гүйцэтгэх гэрээ байгуулах гэх мэт.

Хэрэв оюутан татварыг нь урьдчилсан шимтгэл хэлбэрээр төлдөг хэд хэдэн зэрэгцсэн ажил хийж байгаа (15 хувийн “шимтгэл татвар” гэж нэрлэдэг) эвсэл татвар ноогдуулах бусад орлого нь жилд 30 мянган чех кроноос давж байгаа тохиолдолд бусад татвар төлөгчдийн нэгэн адил татварын тайлан гаргах үүрэгтэй. Сургуулиас өгсөн тодорхойлолтын үндсэн дээр 26 хүртэлх насны оюутнуудад ажил олгогчоос татварын хөнгөлөлт үзүүлнэ.

АЮУЛ ЭРСДЭЛ, АЖИЛТНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ

Чех Улсад ажилтан, ажил олгогчийн эрх, үүрэг, **хөдөлмөр эрхлэх нөхцлүүд** **Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулагддаг.**

Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой аливаа тохиролцоог ямагт **бичгээр** үйлдэгтүн. **Гэрээний заалтуудыг бүрэн гүйцэд ойлгосон тохиолдолд л гарын үсэг зурна. Ажил олгогчтой байгуулсан, гарын үсэг бүхий баримт бичгээ** нэг бүрчлэн нямбай **хадгалагтун.**

Хөдөлмөр зуучлалын төв, компани итгэл хүлээж чадах эсэхийг сайтар лавлан шалгах хэрэгтэй. Магадлан итгэмжлэгдсэн хөдөлмөр зуучлалын төв, компанийн жагсаалтыг Хөдөлмөр, нийгмийн хэргийн яамны цахим хуудаснаас үзнэ үү.

Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу илүү цагаар, амралт, баярын өдрүүдэд ажилласан тохиолдолд илүү цагийн эсвэл нэмэлт хөлс авна. Эрүүл ахуйн шаардлага хангаагүй, эрүүл мэндэд хортой, хөдөлмөрийн тэвчишгүй нөхцөлд ажилладаг бол харьяа хөдөлмөр хяналтын газар, интеграцчилалын төв болон бусад төрийн бус байгууллагад хандагтун. Гарын үсэг зурсан баримт нотолгооноос гадна та энэ бүхнийг гэрчилж чадна гэвэл ажил олгогчийн эсрэг хөдөлмөр хяналтын газарт гомдол, шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

Хэрэв ажил олгогч танд албан ёсоор цалингийн зөвхөн нэг хэсгийг өгч байгаа бол энэ нь оршин суух зөвшөөрөл гаргуулахад шаардагдах хэмжээний орлоготой болохоо нотлож чадахгүйгээс гадна таны өндөр насны тэтгэвэр хамгийн бага хэмжээгээр тогтоогдоход нөлөөлнө гэдгийг анхаарна уу!

Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөлд зааснаас өөр албан тушаал эсвэл өөр ажил олгогчтой ажилласан бол хууль зөрчсөнд тооцно. Чехийн хуулийн этгээд, хувь хүнтэй байгуулсан гэрээний дагуу үүрэг даалгавар гүйцэтгүүлэхээр гадаадын ажил олгогчоос Чех Улсад томилогдсон гадаад ажилтан хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авах шаардлагатай.

Таныг Чех Улсад ирсний дараа ажил олгогч тохиролцсоноос **өөр**, тэвчишгүй **хөдөлмөр хийлгүүлсэн** бол энэ нь залилан мэхлэх эсвэл хөдөлмөрийн мөлжлөг, ноцтой тохиолдолд бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн байж болох юм. Ийм нөхцөлд та нэн даруй энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ эсвэл БНЧУ-ын Цагдаагийн газарт хандаж өөрийгөө хамгаалуулах нь зүйтэй. Та гэрчийн мэдүүлэг өгснөөр гэмт хэрэгтэнд хариуцлага тооцож, таны нэгэн адил хөдөлмөрийн мөлжлөгт өртөж болзошгүй байдлаас бусад гадаад иргэдийг урьдчилан сэргийлэх боломжтой юм.

МЭДЭЭЛЭЛ, ТУСЛАЛЦАА

БНЧУ дахь хөдөлмөр эрхлэлт, мэдээлэл, хөдөлмөр зуучлалын компани (гадаадын иргэдэд хамаарах) ажлын байрны санал:

Хөдөлмөр, нийгмийн хэргийн яам

<https://www.mpsv.cz/web/cz/hledani-volnych-mist-1>

<https://www.mpsv.cz/web/cz/hledani-volnych-mist>

<https://www.mpsv.cz/web/cz/hledani-volnych-mist-2>

Хөдөлмөр зуучлалын төвүүдийн жагсаалт

Ажилтны болон цэнхэр карт:

Дотоод хэргийн яамны портал сайт

www.imigracniportal.cz

www.mvcr.cz/clanek/zamestnanecka-karta.aspx

Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох:

Хөдөлмөрийн товчоо

www.uradprace.cz

Ажлын нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналт:

Хөдөлмөр хяналтын ерөнхий газар (аймгийн салбарууд)

www.suip.cz/kontakty

Үнэ төлбөргүй мэдээлэл, зөвлөгөө:

Интеграцчилалын төвүүд

Төрийн бус ашгийн бус байгууллагууд


Чех Улсын Ла Страда (La Strada Česká republika) – мөлжлөг, хүн худалдаалах

(албадан ажиллуулах, бэлгийн мөлжлөгт өртсөн) гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлдэг

Прага дахь Архиепископийн Харита (Arcidiecézní Charita Praha) – “Магдала”

төсөл – хүн худалдаалах (албадан ажиллуулах, бэлгийн мөлжлөгт өртсөн) гэмт хэргийн хохирогчдод зөвлөх үйлчилгээ, туслалцаа үзүүлдэг

Холбоо барих бүх мэдээллийг энэ товхимлын Холбоо барих хэсгээс үзнэ үү.



БИЗНЕС ЭРХЛЭЛТ

Прага хотын Бүжиглэдэг байшин

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУД

БНЧУ дахь бизнес эрхлэлт, мэдээлэл, хууль эрх зүй:

Үйлдвэр, худалдааны яам

Бизнес эрхлэх зөвшөөрөл олгох:

(Хотын захиргааны дэргэдэх) Бизнес эрхлэх асуудал эрхэлсэн газар

БИЗНЕС ЭРХЛЭЛТ ГЭЖ ЮУГ ХЭЛЭХ ВЭ?

Бизнес эрхлэлт гэдэг нь ашиг олох зорилгоор эрсдэлээ үүрэн өөрийн нэр дээр бие даасан тогтмол үйл ажиллагаа явуулахыг хэлнэ. **Иргэн хувиараа** эсвэл **компани (хуулийн этгээд)** байгуулан бичил болон жижиг бизнес эрхлэх боломжтой..

Тогтмол үйл ажиллагаа явуулна гэдэг нь таны явуулж буй бизнесийн үйл ажиллагаа давтагдан явагдана гэсэн утгатай. Тодруулбал, өөрийнхөө цэцэрлэгт ургуулсан илүүдэл алимаа ганц удаа зарсан тохиолдлыг бизнест тооцохгүй. Харин үндсэн ажлынхаа хажуугаар эсвэл жилийн зөвхөн тодорхой улиралд цөөхөн хэдий ч удаа дараалан алим худалдвал хувиараа эрхлэх бизнест тооцно.

Эрсдэлээ тооцон өөрийн нэр дээр бизнес эрхэлнэ гэдэг нь өөрийнхөө эсвэл компанийнхаа нэрийн өмнөөс бизнесийн үйл ажиллагаа явуулахыг хэлэх бөгөөд эрсдэл болон эцсийн үр дүнг та өөрөө бүрэн хариуцна. Ямар чиглэлээр үйл ажиллагаа явуулах, ирсэн захиалгыг хэрэгжүүлэх эсэх гээд бүх зүйлийг та өөрөө бие даан даргын зааваргүй шийдэх тул энэ нь хөдөлмөр эрхлэлтээс тэс өөр юм. Бичил болон жижиг бизнес эрхлэгчид нь өөрийнхөө эд хөрөнгөөр баталгаа гарган бизнесийн эрсдэлээ үүрнэ.

Ашгийн төлөө гэдэг нь ашиг олох зорилгоор бичил болон жижиг бизнес эрхэлж байгаа тул захиалагч, үйлчлүүлэгч нартаа нэхэмжлэх гаргана. Иймд, та нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, орлогын татвараа өөрөө төлөх үүрэгтэй. Бичил болон жижиг бизнес эрхлэх нь ажил олгогч ажилтанд цалин өгч, өөрийн тань өмнөөс шаардлагатай бүх шимтгэлийг суутгуулахаас эрс ялгаатай. Шимтгэл суутгалыг зохих ёсоор нь төлөхийн тулд бичил болон жижиг бизнес эрхлэгч нь татварын бүртгэл хөтлөх үүрэгтэй.

Дараах мэдээлэл нь юун түрүүнд бичил болон жижиг бизнес эрхлэгчдэд хамаатай. Хуулийн этгээдийн бизнесийн үйл ажиллагааны тухай мэдээллийг www.businessinfo.cz цахим хуудаснаас үзэх боломжтой.

ГАДААДЫН ИРГЭД ЧЕХ УЛСАД БИЧИЛ БОЛОН ЖИЖИГ БИЗНЕС ЭРХЛЭХ БОЛОМЖТОЙ ЮУ?

Гадаадын иргэд Чех Улсад удаан хугацааны виз, удаан хугацааны эсвэл байнга оршин суух зөвшөөрөлтэй тохиолдолд бизнес эрхлэх нөхцөл ихэнх тохиолдолд чех иргэдтэй ижил байдаг.

Гадаадын иргэн заавал “бизнес эрхлэх” зорилгоор удаан хугацааны виз эсвэл оршин суух зөвшөөрөлтэй байх албагүй, виз, оршин суух зөвшөөрлийн зорилго ямар ч байж болно. Хэрэв гэр бүл нэгтгэх, суралцах, хөдөлмөр эрхлэх зэрэг өөр зорилгоор оршин суух зөвшөөрөл авсан бол **виз/оршин суух зөвшөөрлийн зорилгоо биелүүлж байх нөхцөлд л** бизнесээ эхлүүлэх боломжтой.

ГАДААДЫН ИРГЭН БИЗНЕС ЭРХЛЭХ ЗОРИЛГООР ЧЕХ УЛСАД ОРШИН СУУХ ТУХАЙ

Хэрэв та хөдөлмөр эрхлэх, суралцах, гэр бүл нэгтгэх зорилгоо больж гагцхүү бизнес эрхлэхээр шийдсэн тохиолдолд оршин суух зөвшөөрлийн зорилгоо “бизнес эрхлэлт” болгон өөрчлөх шаардлагатай. Гадаадын иргэн Чех Улсад **5-аас багагүй жил** амьдарсан, **оршин суух зөвшөөрөл нь хүчинтэй байх** тохиолдолд оршин суух зөвшөөрлийн зорилгыг “бизнес эрхлэлт” болгон өөрчлөх боломжтой.

Гэр бүл нэгтгэх зорилгоор оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэн тус улсад **3 жил амьдарсан** эсвэл 18 нас хүрсэн тохиолдолд л оршин суух зөвшөөрлийн зорилгоо бизнес эрхлэх гэх мэт өөр зорилго болгон өөрчлөх боломжтой.

Компани, хоршооны удирдлагад ажиллах, хоршооны бизнесийн үйл ажиллагаанд оролцох нь бизнес эрхлэлтэд тооцогддог тул удаан хугацааны оршин суух зөвшөөрөл авах үндэслэл болохыг анхаарна уу. Үүнийг бүхэлд нь хуулийн этгээдийн үйл ажиллагаанд оролцох гэж нэрлэнэ.

Харин гадаадын иргэн хуулийн этгээд, компанийн хувь нийлүүлэгч, компанийнхаа удирдлагын эсвэл өөр байгууллагын гишүүн, хоршооны гишүүн, хоршооны удирдлагын гишүүн өөрийн хуулийн этгээд, компани, хоршооны үйл ажиллагааны хүрээнд үүрэг даалгавар биелүүлэх нь үйл ажиллагааны агуулгын хувьд хөдөлмөр эрхлэлтэд

тооцогддог. Ийм тохиолдолд гадаадын иргэн нь харьяа аймгийнхаа Хөдөлмөрийн товчооноос заавал зохих зөвшөөрөл авсан байна.

Жишээлбэл, цэвэрлэгээ үйлчилгээний хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэрэг хөтлөгч этгээд цэвэрлэгээ үйлчилгээнд биечлэн оролцдог бол хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авах шаардлагатай.

ХУВИАРАА БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ – ХЭРХЭН ЭХЛЭХ ВЭ?

Бизнес эрхлэх хүсэлтэй иргэн зохих зөвшөөрөл аваад нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгүүлж, татвар төлөх зорилгоор татварын орлогын бүртгэл хөтлөнө. Хувиараа бичил болон жижиг бизнес эрхэлж буй этгээдийг **хувиараа орлого олох зорилгоор үйл ажиллагаа явуулагч (чехээр “osoba samostatně výdělečně činná”, товчилбол “ОСВЧ”/“OSVČ”) эсвэл хувиараа бизнес эрхлэгч** гэж нэрлэдэг.

Чех Улсад **Бизнес эрхлэх эрхийн гэрчилгээ** авч бизнес (аж ахуй) эрхлэх нь түгээмэл байдаг хэдий ч эмч, хуульч, өмгөөлөгч, татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэх мэт үйл ажиллагааг **тусгай хуулийн дагуу тусгай зөвшөөрөл** авсны үндсэн дээр явуулна.

ХУВИАРАА БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ

Бизнес эрхлэлтийг **Бизнес эрхлэлтийн тухай хуулийн** хүчин төгөлдөр бүхий найруулгаар зохицуулдаг. Хувиараа бизнесийн үйл ажиллагаа эрхлэх бүхий л асуудлыг хот, тосгон, суурин газрын захиргааны Бизнес эрхлэх асуудал эрхэлсэн газар хариуцдаг.

Хувиараа бизнес эрхлэх гэрчилгээ авах хүсэлт хэрхэн гаргах вэ?

Хувиараа бизнес эрхлэхийн тулд Бизнес эрхлэх асуудал эрхэлсэн газарт хүсэлтээ биечлэн эсвэл шуудангаар эс бөгөөс уг газрын зориулалтын цахим шуудангаар тоон гарын үсэг бүхий хүсэлт гаргана. Хүсэлтээ Czech POINT төрийн үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан гаргах боломжтой. Бизнес эрхлэх зөвшөөрөл авах 1000 чех кроны төлбөрийг тухайн хот, тосгон, суурин газрын захиргааны кассанд бэлэн мөнгөөр эсвэл данснаас шилжүүлж төлнө. Уг газраас мэргэжлийн салбар, үйл ажиллагааны төрлөөс хамааран бизнес эрхлэх эрхийн гэрчилгээ олгоно. Мөн газраас **бизнес эрхлэгчдийн бүртгэлийн лавлагаа** олгодог.

Бизнес эрхлэх эрхийн гэрчилгээ доор дурдсан болзол хангасан этгээдэд олгоно. Үүнд,

- 18 нас хүрсэн байх,
- Иргэний эрх зүйн бүрэн чадамжтай байх,
- Эрүүгийн хэрэг зөрчилд холбогдоогүй байх - өөрийн харьяат улсын холбогдох байгууллагаас олгосон (хугацаа нь 3 сараас хэтрээгүй) **ял шийтгэлийн лавлагааг** баталгаат орчуулгын хамт бүрдүүлнэ,
- Зарим чиглэлээр үйл ажиллагаа явуулах тохиолдолд мэргэжлийн мэдлэг, ур чадвартай байгааг зохих боловсролын эсвэл ажлын туршлагын баримт бичгээр гэрчилнэ.

Чех Улсад бизнес явуулж эхэлснээ **мэдэгдэх (нарийн мэргэжлийн бус үйл ажиллагаа, гар урлалын үйлдвэрлэл, мэргэжлийн худалдаа)**, заавал зохих зөвшөөрөл, лиценз авсны дараа явуулж эхлэх гэсэн хоёр төрлийн үйл ажиллагаа байдаг. Оёдол, гэрэл зураг, орчуулгын үйлчилгээ үзүүлэх, зочид буудал, дэлгүүр ажиллуулах гэх мэт нарийн мэргэжлийн бус үйл ажиллагаа явуулахын тулд мэргэжлийн боловсрол эзэмшсэн баримт бичиг бүрдүүлэх шаардлагагүй. Гар урлалын үйлдвэрлэл, мэргэжлийн худалдааны үйл ажиллагаа явуулахад зохих боловсрол эзэмшсэн байх эсвэл тухайн мэргэжлийн салбарт ажлын зохих туршлагатай байх шаардлагатай. Үйл ажиллагааны чиглэлүүдийн бүрэн жагсаалт, эрхийн гэрчилгээ хэрхэн авах тухай чех хэлээрх холбогдох мэдээллийн хамт businessinfo.cz цахим хуудаснаас үзнэ үү.

Цаашилбал гадаадын иргэн Чех Улсад хуулийн дагуу **оршин сууж байгаагаа** нотлох бичиг баримт бүрдүүлэх үүрэгтэй.

Бичил болон жижиг бизнес эрхлэгч хүн бүр Чех Улсад албан ёсны хаягтай байх үүрэгтэй тул бүрдүүлэх материалд тухайн хаяг дээр **бизнес эрхлэх зөвшөөрөл олгосон үл хөдлөх хөрөнгө (байр) эзэмшигчийн тодорхойлолт** заавал багтана.

АЛХАМ 2: Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтөд бүртгүүлэх

Таныг **бүртгэлийн нэгдсэн маягт** бөгөлсний үндсэн дээр Бизнес эрхлэх асуудал эрхэлсэн газар таныг бизнес эрхэлдэг болсон гэсэн үндэслэлээр эрүүл мэндийн даатгалын компани, нийгмийн хангамжийн асуудал эрхэлсэн газар, татварын газар зэрэг холбогдох бусад байгууллагуудад бүртгүүлнэ.

Бизнесийн үйл ажиллагааг **үндсэн** хэлбэрээр эсвэл сурах, хөдөлмөрлөхийн хажуугаар **хавсран** явуулж болно. Бизнесийн үйл ажиллагаа явуулж буй хэлбэрээс эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ хамаарна.

Жич: Чех Улсад хэрхэн бизнес эхлүүлэх, мөн холбогдох албан газрын хаяг, утас зэрэг холбоо барих мэдээллийг (англи хэлээр) Үйлчлүүлэгчдийг дэмжих нэгдсэн төвүүдэд хандан авах боломжтой бөгөөд Үйлчлүүлэгчдийг дэмжих нэгдсэн төвүүд бизнес эрхлэх эрхийн гэрчилгээ авах хүсэлт, эрүүл мэндийн болон нийгмийн даатгалтай холбоотой мэдэгдэл зэргийг холбогдох албан байгууллагуудад дамжуулах үйлчилгээ үзүүлдэг. Салбар төвүүдийн хаяг, холбоо барих бусад мэдээллийг **businessinfo.cz** цахим хуудаснаас үзэж, асуулт, хүсэлтээ **онлайн маягтыг** бөглөж явуулах боломжтой.

ХУВИАРАА БИЗНЕС ЭРХЛЭХ – ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

Бизнес эрхлэгч хүн бүр аливаа нэг албаны баримт бичигт овог нэр, албан ёсны хаяг, бизнес эрхлэгчдийн бүртгэлд бүртгэгдсэн тухай мэдээлэл, улсын бүртгэлийн дугаар зэргийг заавал заах үүрэгтэй. Бизнес эрхлэгчид эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлээ тогтмол төлөхөөс гадна нийлмэл төлбөрт горимд (доорхыг үзнэ үү) бүртгүүлээгүй л бол татварын тайлан гаргаж, татвар төлөх үүрэгтэй.

Эрүүл мэндийн даатгал

Чех Улсад оршин сууж байгаа хүн бүр эрүүл мэндийн даатгалд хамрагдана.

Хувиараа орлого олох зорилгоор үйл ажиллагаа явуулагч (ОСВЧ/ОСВČ) болон бусад бизнес эрхлэгчид ажилтнаас ялгаатай нь эрүүл мэндийн даатгалаа өөрсдөө төлдөг.



Чех Улсад удаан хугацааны виз эсвэл оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэд (АНУ-ын иргэд, Олон улсын гэрээ хэлэлцээрт зааснаас бусад тохиолдолд) нийтийн эрүүл мэндийн даатгалд хамрагддаггүй тул эрүүл мэндийн **иж бүрэн цогц үйлчилгээ үзүүлдэг** эрүүл мэндийн арилжааны даатгалын гэрээ байгуулна. Ийм тохиолдолд эрүүл мэндийн даатгалын гэрээг оршин суух зөвшөөрлийн хугацаатай уялдуулж байгуулдаг тул төлбөрийг нэг дор бөөнд нь төлөх шаардлагатай болдог. Харин нийтийн эрүүл мэндийн даатгалд хамрагдсан бизнес эрхлэгчид даатгалын шимтгэлээ сар бүр төлдөг.

Нийгмийн хангамж

Нийгмийн хангамжийн систем нь нийгмийн даатгал, улсын нийгмийн тэтгэмж, нийгмийн тусламж гэсэн хоорондоо уялдаа бүхий гурван хэсгээс бүрддэг бөгөөд нэг нь нөгөөгөө нөхөх чадвар бүхий иж бүрэн тогтолцоог бий болгодог юм.

Нийгмийн даатгалын системд тэтгэвэр, хөдөлмөр эрхлэлтийн төрийн бодлогын шимтгэл, өвчний даатгал багтдаг. Нийгмийн даатгал улсын төсвөөс гаргаж байгаа дараах олговор, тэтгэвэр, тэтгэмжийг олгоход зориулагддаг. Үүнд,

- тэтгэврийн даатгалын олговор (өндөр насны тэтгэвэр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн халамжийн тэтгэвэр, бэлэвсэрсний болон тэжээгчээ алдсан/өнчирсний тэтгэмж),
- ажилгүйдлийн тэтгэмж буюу БНЧУ-ын Хөдөлмөрийн товчоонд бүртгэлтэй тэтгэмж авах болзол хангасан ажилгүй иргэдэд олгодог тэтгэмж болон хөдөлмөр эрхлэх эрхийг хангахтай холбоотой бусад олговор,
- өвчний даатгалын олговор (өвчний, асрамжийн тэтгэмж, жирэмсний болон амаржсаны нөхөн олговор, хүүхэд асарсан үеийн мөнгөн тусламж).

Чехийн нийгмийн хангамжийн асуудал эрхэлсэн газар (Česká správa sociálního zabezpečení – ČSSZ/ЧССЗ) нь нийгмийн хангамжийн асуудлыг хариуцдаг бөгөөд Чех Улсын санхүү, захиргааны асуудал эрхэлсэн хамгийн том байгууллагуудын нэг болох энэ байгууллага нь тэтгэвэр, тэтгэмж, өвчний даатгалын олговор олгодог. ЧНХАЭГ-ын сумдын салбар нь (ОССЗ/ОССЗ) Сумын нийгмийн хангамжийн асуудлыг, Прага хот дахь салбар нь Прагийн нийгмийн хангамжийн асуудлыг хариуцан ажилладаг.

Хувиараа бизнес эрхлэгч нь хууль тогтоомжид заасан болзлыг хангасан тохиолдолд тэтгэвэрийн даатгалд хамрагдаж, хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах төрийн бодлогын шимтгэл төлөх үүрэгтэй. Бизнес эрхлэгч нь өвчний даатгалд сайн дурын үндсэн дээр хамрагдах боломжтой ч өвчний даатгалд даатгуулаагүй тохиолдолд өвдсөн үедээ өвчний даатгалын сангаас олговор авах эрхгүй. Үүнд хөдөлмөрийн чадвараа түр алдсан үед авдаг өвчний тэтгэмж, нялх хүүхэд асрах үед

авдаг жирэмсний болон амаржсаны тэтгэмж, эцэг нь нялх хүүхдээ асрах үед эцгийн тэтгэмж хамаарна.

Бичил болон жижиг бизнес эрхлэх эрх авсан гадаадын иргэн СНХАЭГ-д бүртгүүлнэ. Бүртгүүлэхдээ биеийн байцаалт, Чех Улсад оршин суух зөвшөөрлөө шалгуулж, бизнес эрхлэгчдийн бүртгэлийн лавлагаа бүрдүүлнэ. Бизнес эрхлэгч нь бизнес эрхлэх эрх эхэлсэн, дууссан, түр зогссон гэх мэт **ямарваа нэгэн өөрчлөлтийг хуанлийн дараа сарын эхний 8 хоногт багтаан харьяа НХАЭГ-д мэдэгдэх үүрэгтэй.**

Даатгалын шимтгэл төлөх дүрэм

СНХАЭГ нь гадаадын иргэнд бүртгэлийн гэрчилгээг, **даатгалын шимтгэл төлөх** гүйлгээний утгын хамт олгоно. Даатгалыг сар бүр шимтгэл хэлбэрээр төлнө. Бичил болон жижиг бизнес эрхлэх эрх хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн **дараа сарын эхний 20 хоногт багтаж** нийгмийн хангамжийн шимтгэл төлөх үүрэг үүснэ. Төлбөрөө цагт нь төлж байх нь чухал, жишээлбэл нь 5 дугаар сарын шимтгэл 6 дугаар сарын 20-ноос хэтрэлгүй СНХАЭГ-ын дансанд орсон байх дүрэмтэй.

Бизнес эрхлэгч нь татварын газарт татварын тайлан өгөх үүрэг үүссэн өдрөөс эхлэн нэг сарын дотор өнгөрсөн оны **Орлого, зарлагын тайланг** СНХАЭГ-т гаргах үүрэгтэй.

Гадаадын иргэн удаан хугацааны виз, оршин суух зөвшөөрлөө алдахгүйн тулд **СНХАЭГ-т төлбөрөө цаг тухайд нь зөв зохистой төлж, өрөнд орохгүй байхыг анхаар.**

Хоршоо, компанийн удирдлагын төлөөлөгчид, гишүүд хуульд заасан сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг (сарын 3 500,- чех крон) авдаг тохиолдолд ч нийгмийн даатгалын шимтгэл төлөх үүрэгтэй.

Гадаадын иргэн бизнес эрхлэх зорилгоор оршин суух зөвшөөрөл авсан хэдий ч тодорхой үйл ажиллагаа явуулаагүй, орлого олоогүй, Чех Улсаас гадуур байгаа зэрэг тохиолдолд ч СНХАЭГ-ийн бүртгэлээс хасуулахгүй байхыг сануулж байна. СНХАЭГ-т үүссэн ер нь виз, оршин суух зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл болдийг анхаараарай.

ТАТВАР – ТАТВАРЫН ГАЗАР (ТГ)

Хувиараа бизнес эрхлэх эрх авсан гадаадын иргэн бизнэс эрхэлж буй албан ёсны хаяг (голдуу гэрийн хаяг)-ийн дагуу харьяалагдах **татварын газарт бүртгүүлнэ**. Бүртгүүлсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор татварын газарт бүртгүүлсэн гэрчилгээ, татвар төлөгчийн бүртгэлийн дугаар авна (чехээр „DIC“ гэсэн товчлолтой байна).

Онцгой тохиодлоос бусдаар хувиараа бизнес эрхлэгч иргэн бүр **орлого зарлагын бүртгэл хөтлөх үүрэгтэй**. Бүртгэлийг ойлгомжтой зөв хөтлөх нь татварын суурийг тодорхойлох үндэс болохоос гадна татварын газраас явуулах хяналт шалгалтыг илүү дөхөм болгодог. Бизнес эрхлэгч бүтэн жилийн турш үйл ажиллагаа эрхлээгүй, орлого олоогүй, аль эсвэл жилийн хэдхэн сар үйл ажиллагаа эрхэлж байсан ч дараа оны 3 дугаар сарын 31-ний дотор багтаж **татварын тайлан** гаргах үүрэгтэй. Жишээлбэл, 2023 онд бизнес эрхэлсэн гадаадын иргэн 2023 оны татварын тайланг 2024 оны 3 дугаар сарын 31-ний дотор гаргах үүрэгтэй гэсэн үг.

Татварын тайланд тайлагнасан (мэдэгдсэн) орлогоосоо орлогын албан татвар төлнө. Ногдуулсан татварыг төлөөгүй тохиолдолд нийгмийн даатгалын өр үүсэхтэй ижил байдлаар татварын газарт таны нэр дээр өр үүснэ. Дотоод хэргийн яамны Орогнол, шилжин сууршилтын газар (“ОАМП”)-аас албан татварын өртэй гадаадын иргэний удаан хугацааны виз, оршин суух зөвшөөрлийг сунгахаас татгалзах үндэслэл болж магад.

АНХААР! 2021.01.01-нээс эхлэн бичил болон жижиг бизнес эрхлэгчид татварын газарт **нийлмэл төлбөрт горим** ашиглан татвар төлөгчөөр бүртгүүлэх боломжтой болсон. Нийлмэл төлбөрт горим гэдэг нь орлогын албан татвар, тэтгэврийн даатгал, хөдөлмөр эрхлэлтийн төрийн бодлогын шимтгэл болон эрүүл мэндийн даатгалыг нэг удаагийн нийлмэл төлбөр хэлбэрээр төлөхийг хэлдэг. Нийлмэл төлбөрт горимд бүртгүүлсэн төлөгчид татварын тайлан гаргахгүй.

АЮУЛ ЭРСДЭЛ, ХАМГААЛАЛ

Хувиараа бизнес эрхлэх, хөдөлмөр эрхлэх нь хоорондоо маш их ялгаатай. Хэдийгээр та өөрөө бизнес эрхэлж байгаа гэж үзсэн ч Чех Улсын хууль тогтоомжийн дагуу таны эрхэлж буй ажил хөдөлмөр эрхлэлтэд тооцогдож магад. Ийм тохиолдолд хөдөлмөр эрхлэлтийн хууль зөрчсөн хэмээн маш өндөр торгууль ногдуулдаг.

Хэрэв та Чех Улсад цаашдаа амьдарч, оршин суух зөвшөөрлийн хугацаагаа сунгуулах хүсэлтэй тохиолдолд санхүүгийн хангалттай эх үүсвэртэй, албан татвар, эрүүл мэнд, нийгмийн даатгалын өргүй гэдгээ нотлох хэрэгтэй. Зөвхөн оршин суух зөвшөөрөл авахын тулд хувиараа бизнес эрхлэх нь тус улсын хууль тогтоомжид зааснаар урьдаас зориуд бэлдсэн гэж үздэг тул тун буруу алхам юм.

БИЗНЕС ЭРХЛЭЛТ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХООРОНДЫН ЯЛГАА

Дээр дурдсанчлан хувиараа бизнес эрхлэгч (иргэн) нь хэн нэгний удирдлаган дор бус **өөрийн нэр дээр эрсдэл хүлээн** бизнесийн үйл ажиллагаа явуулдаг. Үйлчлүүлэгч, захиалагчаа өөрөө сонгох ба ажлын цагаа тогтоож, шаардагдах багаж хэрэгслээ бүрдүүлнэ. Хувиараа бизнес эрхлэгч нь хэд хэдэн захиалагчтай хамтарч нэг зэрэг олон захиалга дээр ажиллах нь түгээмэл. Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлөхөөс гадна нягтлан бодох бүртгэл хөтлөнө.

Ажилтан гэж **хөдөлмөрийн эрх зүйн харилцааны үндсэн дээр** гэрээгээр ажиллах үүрэг хүлээсэн иргэнийг хэлнэ. Ажилтан нь **дээд албан тушаалтанд (ажил олгогч)-д захирагдан** ажил олгогчийн нэрийн өмнөөс эсвэл заавар журмын дагуу биечлэн ажиллана гэсэн үг. Ажилтан нь ажлын цагаар ажил олгогчийн ажлын байранд эсвэл тохиролцсон өөр газарт цалин хөлс авч ажиллах ба холбогдох бусад зардлыг ажил олгогч хариуцна. Ажил олгогч нь ажилтныг ямагт хөдөлмөрийн, хөлсөөр ажиллах (чех хэлээр “dohoda o pracovni činnosti – DPČ” гэх) эсвэл ажил гүйцэтгэх гэрээ (чех хэлээр “dohoda o provedeni práce – DPP” гэх) гэх мэт бичгээр байгуулсан ажлын гэрээний үндсэн дээр ажиллуулна.

Бизнес эрхлэлт, хөдөлмөр эрхлэлтийн хоорондын ялгааг сайтар ялгаж салгаж ойлгох нь ихэд чухал. Та бизнесийн үйл ажиллагаагаа Чех Улсын мөрдөгдөж буй хууль тогтоомжид нийцүүлэн явуулж байгаа эсэхдээ анхаарлаа хандуулаарай. Таны эрхэлж байгаа бизнес хөдөлмөрийн харилцааны шинжтэй байвал ажил олгогчтойгоо гэрээ байгуулах шаардлагатай. Учир нь бизнес эрхлэх эрхийн үндсэн дээр ажил олгогч талын даалгасан ажлыг “захиалга” хэмээн дүр эсгэн биелүүлэх нь хууль зөрчиж байна гэсэн үг. Иймд хөдөлмөр хяналтын газар эсвэл холбогдох бусад байгууллагаас хийсэн шалгалтын явцад хууль зөрчсөн нь илэрвэл өндөр торгууль төлөөд зогсохгүй удаан хугацааны оршин суух зөвшөөрлөө сунгуулахгүй, улмаар хүчингүй болгуулах байдалд хүрч болзошгүй. Таны хийж байгаа ажил хуурамч бизнес эрхлэлт мөн эсэхдээ эргэлзэж байгаа тохиолдолд үнэ төлбөргүй хууль эрх зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг байгууллагад хандсан нь зөв.

МЭДЭЭЛЭЛ, ТУСЛАЛЦАА

Чех Улсад бизнес, аж ахуй эрхлэх, мэдээлэл, хууль эрх зүй:

Үйлдвэр, худалдааны яам

www.mpo.cz

Хувиараа бизнес эрхлэгч, экспортлогчдод зориулсан албан ёсны цахим портал сайт

www.businessinfo.cz

Хувиараа бизнес эрхлэх эрх олгох асуудал:

(Хот, тосгон, суурин газрын захиргааны дэргэдэх) Бизнес эрхлэх асуудал эрхэлсэн газар

www.statnisprava.cz/rstsp/ciselniky.nsf/i/d0056

Чех Улсын эрүүл мэндийн салбар, эрүүл мэндийн даатгал, мэдээлэл, хууль эрх зүй

Эрүүл мэндийн яам

www.mzcr.cz

Нийгмийн хангамжийн тогтолцоо, мэдээлэл, хууль эрх зүй

Хөдөлмөр, нийгмийн хэргийн яам

www.mpsv.cz

Нийгмийн хангамж, мэдээлэл, холбоо барих хаяг, утас:

Чехийн нийгмийн хангамжийн асуудал эрхэлсэн газар

www.CSSZ.CZ

Улсын төсвийн санхүүжилт, татвар, гаалийн татвар:

Сангийн яам

www.mfcr.cz





ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ

Прага хотын түүхэн Хуучин хотын талбай



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУД

Чех Улсын эрүүл мэндийн салбар, эрүүл мэндийн даатгал, мэдээлэл, хууль эрх зүй

Эрүүл мэндийн яам

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР

Чех Улсад оршин сууж буй хүн бүр хуульд заасны дагуу заавал эрүүл мэндийн даатгалд хамрагдана. Энэ бүлэгт эрүүл мэндийн даатгалын тухай үндсэн мэдээллийг танилцуулах бөгөөд уг даатгалд стандартын бус олон төрлийн онцгой тохиолдлууд байдаг тул нийгмийн ажилтан, интеграцчилалын төв, ТББ-ын хуульчдаас зөвлөгөө авсны үндсэн дээр тодорхой асуудлаа шийдэх нь зөв алхам юм. (Эдгээр байгууллагуудтай холбоо барих хаяг, утас зэрэг мэдээллийг товхимлын Холбоо барих хэсгээс үзнэ үү).

Чех Улсад эрүүл мэндийн даатгал нь нийтийн болон арилжааны ("гэрээт" гэх) гэсэн хоёр төрөл байдаг.

Нийтийн эрүүл мэндийн даатгал нь эв санааны нэгдлийн зарчим дээр тулгуурладаг. Өөрөөр хэлбэл орлого олж буй иргэн бүр сар тутам эрүүл мэндийн даатгалын санд шимтгэл төлж, шаардлагатай тохиолдолд даатгалаар үйлчлүүлнэ. Нийтийн эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусалцааг үнэ төлбөргүй үзүүлдэг.

Нийтийн эрүүл мэндийн даатгалд хамрагдах эрхгүй Чех Улсад 90-өөс дээш хоногийн хугацаагаар оршин суухаар төлөвлөж буй болон хуульд заасан өөр үндэслэлээр эрүүл мэндийн үйлчилгээний зардлыг нь нийтийн эрүүл мэндийн даатгалын сангаас даахгүй гадаадын иргэд зөвхөн "Пойиштёвна ВЗП" ХК (Pojist'ovna VZP, a.s.) даатгалын компанид гэрээгээр даатгуулах үүрэгтэй. Арилжааны даатгалаас үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний цар хүрээ нь уг даатгалын компанийн байгуулсан гэрээт нөхцлөөс хамаарна.

НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ

Нийтийн эрүүл мэндийн даатгал нь Нийтийн эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар зохицуулагддаг бөгөөд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын дийлэнх хэсэгтэй (гоо сайхны мэс заслууд, шүдний гэх мэт нарийн мэргэжлийн хувийн эмнэлгүүд хамрагдахгүй) хамтран ажилладаг тул үзүүлж байгаа үйлчилгээний цар

хүрээ харьцангуй өргөн байдаг. Нийтийн эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг тусгай зөвшөөрөл, лиценз бүхий даатгалын компаниуд үзүүлдэг.

Дээр дурдсан хуулийн дагуу нийтийн эрүүл мэндийн даатгалд гадаадын иргэд дараах нөхцөлд хамрагдана. Үүнд,

- байнга оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэд,
- Чех Улсад албан ёсны хаягтай эсвэл байнга оршин суух зөвшөөрөлтэй ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг гадаадын иргэд,
- ЕХ-ы гишүүн орны иргэд, тодорхой нөхцөлд тэдний гэр бүлийн гишүүд,
- байнга эсвэл удаан хугацааны оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэн Чех Улсад хүүхэд төрүүлбэл хүүхэд төрсөн өдрөөсөө эхлэн тухайн хуанлийн сар дээр нэмж бүтэн 2 сарын хугацаанд нийтийн эрүүл мэндийн даатгалд хамрагддаг. Хүүхэд нийтийн даатгалд хамрагдах эсэх нь оршин суух зөвшөөрлийн төрлөөс хамаарах тул энэ асуудлаар интеграцчилалын төвийн ажилтнуудад цаг алдалгүй хандана уу,
- БНЧУ-тай байгуулсан олон улсын хэлэлцээрт заасан нөхцөлд багтаж байгаа бусад бүлэг хүмүүс.

АРИЛЖААНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ

Арилжааны эрүүл мэндийн даатгал (“гэрээт” гэх) гэдэг нь “Пойиштёвна ВЗП” ХК (Pojist'ovna VZP, a.s.), даатгуулагч (гадаадын иргэн) хоёрын хооронд байгуулсан хувийн эрх зүйн харилцааг хэлнэ. Арилжааны даатгал нь Чех Улсад оршин суудаг эсвэл оршин суух зөвшөөрөл авах хүсэлтээ хөөцөлдөж байгаа, нийтийн эрүүл мэндийн даатгалд даатгуулах эрхгүй гадаадын иргэдэд зориулагдсан болно. Арилжааны даатгалд гол төлөв бизнес эрхлэх, сургуульд сурах, гэр бүл нэгтгэх зэрэг зорилгоор удаан хугацааны виз эсвэл удаан хугацааны оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэд даатгуулдаг.

Гадаадын иргэдэд зориулсан хоёр төрлийн арилжааны даатгал байдаг бөгөөд үүнд **эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээний даатгал** (“гадаадад зорчигчдын эрүүл мэндийн даатгал” гэх) болон **эрүүл мэндийн иж бүрэн үйлчилгээ хамарсан даатгал** (“эрүүл мэндийн иж бүрэн даатгал” гэх) ордог.

Эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээний даатгал (“гадаадад зорчигчдын эрүүл мэндийн даатгал”)

БНЧУ-ын дипломат төлөөлөгчийн газарт удаан хугацааны виз эсвэл оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргасан гадаадын иргэд Чех Улсад байх хугацаандаа арилжааны эрүүл мэндийн даатгалд заавал даатгуулна. **Чех Улсын хилээр**

нэвтэрснээс хойших эхний 90 хоногийн хугацаанд яаралтай тусламж, үйлчилгээний даатгалтай байхын зэрэгцээ Чех Улсад оршин суух үлдсэн хугацаандаа “Пойиштёвна ВЗП” ХК (Pojišťovna VZP, a.s.)-тай эрүүл мэндийн иж бүрэн даатгалын гэрээ байгуулсан баримт бүрдүүлнэ. Өөр нэг боломж нь Чех Улсад оршин суух нийт хугацааг хамарч байгаа “Пойиштёвна ВЗП” ХК (Pojišťovna VZP, a.s.)-тай байгуулсан эрүүл мэндийн иж бүрэн даатгалын гэрээний тухай баримт бүрдүүлнэ.

90-ээс доош хоногийн буюу Шенгений визээр зорчих гадаадын иргэдийн эрүүл мэндийн даатгалд тавигдах шаардлагыг Европын Холбооны удирдамж буюу “визийн журам”-д заасан.

Эрүүл мэндийн иж бүрэн даатгал

90-ээс дээш хоногийн виз мэдүүлэх, уг визийн хугацааг сунгуулах, хуульд заасан нөхцөлд удаан хугацааны оршин суух зөвшөөрөл авах, хугацааг нь сунгуулах хүсэлт гаргасан тохиолдолд эрүүл мэндийн даатгалын баримтаас “Пойиштёвна ВЗП” ХК (Pojišťovna VZP, a.s.)-тай **эрүүл мэндийн иж бүрэн даатгалд даатгуулсан** гэдэг нь илт байх шаардлагатай.

Эрүүл мэндийн иж бүрэн даатгал гэж даатгуулагч шууд төлбөр хийлгүй эрүүл мэндийн үйлчилгээ авахыг хэлнэ. Иж бүрэн даатгалд урьдчилан сэргийлэх үзлэг, диспансерийн буюу тогтмол хяналт, жирэмсэн болон төрөх үеийн эрүүл мэндийн үйлчилгээ заавал багтсан байна.

Хэрэв эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах зардлаа олон улсын гэрээнд зааснаар эсвэл хуулийн этгээд, төрийн байгууллагын бичгээр үйлдсэн баталгаа, цагдаагийн газарт баталгаажуулсан урилгад заасны дагуу өөр хэлбэрээр даана гэдгээ нотловол эрүүл мэндийн гэрээт даатгалын баримт шаардахгүй.

Эрүүл мэндийн иж бүрэн даатгалыг Чех Улсад оршин суухаар төлөвлөж байгаа нийт хугацааг багтааж төлнө. Эрүүл мэндийн даатгалын төлбөр оршин суух зөвшөөрлийн хугацаанаас хамаарч нэг удаагийн өндөр үнээр гарах нь тохиолддог. Даатгалын төлбөрийг даатгуулсан хүний нас, өвчтөний түүх, тухайн үеийн урамшууллын саналаас хамааран тодорхойлдог.

ГАДААДАД БАЙХ ХУГАЦААНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЗОХИЦУУЛАЛТ

Эрүүл мэндийн гэрээт даатгалын төлбөрийг урьдчилан хийдэг тул гадаад улсад явах тохиолдолд гэрээг цуцлах эсвэл түр зогсоох боломжгүй. Нийтийн эрүүл мэндийн даатгалд хамрагдсан хүн (жишээ нь, ажилтан эсвэл байнга оршин суух зөвшөөрөлтэй хүн) гадаад улсад 6 сараас дээш хугацаагаар оршин суухаар төлөвлөж байгаа бол даатгалаа түр зогсоох боломжтой. Даатгалаа зогсоох хүсэлт гаргасан тохиолдолд Чех Улсад буцаж ирснийхээ дараа гадаадад байсан хугацаандаа эрүүл мэндийн даатгалд хамрагдаж байсан гэдгээ нотлож чадахгүй бол чехийн даатгалын компани энэ хугацааны даатгалын шимтгэлийг нөхөн гаргуулна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ БА ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ

Даатгалын компаниас гэрээт эмч, эмнэлгийн жагсаалтыг авч судалж үзэх нь зүйтэй. Нийтийн даатгал нь ихэнх эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагууд даатгалын компаниудтай гэрээ байгуулж эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг. Харин арилжааны даатгалын хувьд гэрээт эмч, эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын тоо хязгаарлагдмал байдаг тул арилжааны даатгалыг саадгүй ашиглахын тулд ийм жагсаалт зайлшгүй хэрэгтэй болно.

Арилжааны эрүүл мэндийн даатгалтай иргэд “Пойиштёвна ВЗП” ХК (Pojist'ovna VZP, a.s.)-тай гэрээ байгуулаагүй эмч, эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагад хандсан тохиолдолд эрүүл мэндийн үйлчилгээний төлбөрийг өөрөөсөө гаргана. Таны амь нас, эрүүл мэндэд шууд аюул учраагүй л бол эмч, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзаж магад.

Иймээс арилжааны даатгалын гэрээний нөхцөлтэй сайтар танилцснаар та ямар үйлчилгээнд хамрагдахаа мэдэж авна. Жишээ нь, мэс засалд орлоо гэж бодоход даатгалын компаниас зардал даахгүй гэх мэт эвгүй тохиолдлоос өөрийгөө сэргийлнэ.

Арилжааны даатгалтай хүн эмч, эмнэлэгт үйлчлүүлсэн төлбөрийн тооцоог бэлэн мөнгөөр хийх нь элбэг тохиолддог. Даатгалын компани эмчийн болон төлбөрийн тодорхойлолт, тооцооны тасалбарыг үндэслэж буцаан олголт хийнэ.

Ажлын бус цагаар (баярын болон амралтын өдрүүд, шөнө оройн цагаар) шүдний эмчийн болон эмнэлгийн яаралтай тусламж авах тохиолдолд **90 чех кроны хураамж төлдөг** журамтай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ – ХҮҮХЭД, ЖИРЭМСЭН ЭХЧҮҮД

Жирэмсэн эхчүүд эмэгтэйчүүдийн эмчийн хяналтанд байдаг.

Та хүүхдээ төрүүлэхээс хангалттай хугацааны өмнө сонгож авсан амаржих газартаа бүртгүүлэх шаардлагатай. Жирэмсний хяналтанд орсон эхчүүдэд амаржих газар болон иргэний байдлыг бүртгэх газарт хүүхдээ бүртгүүлэх, эцэг, эхийн тэтгэмж авах зэрэг асуудлаар эмэгтэйчүүдийн эмч, сувилагч зөвлөгөө өгдөг.

Чех Улсад хүүхдээ хүүхдийн эмчид үзүүлдэг.

Жирэмсэн эмэгтэй нийтийн эрүүл мэндийн даатгалд даатгуулах эрхгүй (ялангуяа удаан хугацааны виз, оршин суух зөвшөөрөлтэй, ажил эрхлээгүй) тохиолдолд эх, нярай хүүхдийн аль алиныг хамарсан төрөхийн өмнөх, төрөх, төрөхийн дараах үйлчилгээг багтаасан жирэмсэн эмэгтэйчүүдэд зориулсан арилжааны даатгалын тусгай хөтөлбөрт даатгуулна. Ингэж даатгуулах нь жирэмсний болон төрөх үед учирч болзошгүй хүндрэлээс үүдэн гарах олон зуун мянган кроны өндөр төлбөрөөс урьдчилан сэргийлэх арга зам болдог.



ХҮҮХЭД, ЖИРЭМСЭН ЭХЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ – ГАРЧ БОЛОХ ТОХИОЛДЛУУД

а) **Жирэмсэн эх эрүүл мэндийн арилжааны (гэрээт) даатгалтай байх тохиолдолд**

Хэдийгээр төрөхийн өмнөх ба дараах үйлчилгээний даатгал нь сайн дурын байдаг ч даатгуулах нь зүйтэй. Учир нь энэ даатгалд амаржих газраас гарах хүртэлх хугацаанд амаржсан эхээс гадна нярай хүүхэд ч хамрагддаг.

Уг даатгалд төрөхийн өмнөх үзлэг, ердийн шинжилгээ, төрөлт, нярай хүүхэд үзүүлэх үйлчилгээ зэрэг багтдаг.

Даатгалын гэрээ ихэвчлэн нэг жилийн хугацаатай байдаг бөгөөд хүлээлгийн хугацааг урьдчилан тооцох шаардлагатай (зарим даатгалын компанийн хүлээлгийн хугацаа 3 сар байдаг, тодруулбал гэрээ байгуулснаас 3 сарын дараа эрүүл мэндийн үйлчилгээний төлбөрийг даатгалаас гаргана гэсэн үг).

Зарим даатгалын компаниуд даатгалд хамрагдах жирэмсэн эхчүүдийн насны дээд болон доод хязгаарыг заадаг.

Чех Улсад төрсөн хүүхэд төрсөн өдрөөс эхлэн тухайн хуанлийн сар дээр нэмж бүтэн 2 сарын хугацаанд нийтийн даатгалд хамрагдана. Хүүхдийн даатгалын шимтгэлийг эцэг эх нь төлнө. Хүүхдийн эцэг шинэ хүүхэд төрсөн тухай эрүүл мэндийн даатгалын компанидаа 8 хоногийн дотор мэдэгдэнэ. Хэрэв хүүхдийн эцэг нь ЧУ-ын нийтийн эрүүл мэндийн даатгал хамрагдаагүй бол хүүхдийг “Пойиштёвна ВЗП” ХК (Pojist'ovna VZP)-д бүртгүүлнэ.

б) Жирэмсэн эх нийтийн даатгалд хамрагддаг хэдий ч байнга оршин суух зөвшөөрөлгүй байх (жирэмсэн эх, хүүхдийн эцгийн хэн хэн нь байнга оршин суух зөвшөөрөлгүй)

Ийм тохиолдолд жирэмсэн эх өөрөө жирэмсний болон амаржсаны даатгалд хамрагдах шаардлагагүй. Шинэ төрсөн хүүхдийг эрүүл мэндийн даатгалын компанид бүртгүүлэх ба хүүхэд төрсөн өдрөөсөө эхлэн тухайн хуанлийн сар дээр нэмж бүтэн 2 сарын хугацаанд нийтийн эрүүл мэндийн даатгалд хамрагдана – өмнөх зүйлийг үзнэ үү. Энэ даатгалтай уялдуулан хүүхдээ цаашид “Пойиштёвна ВЗП” ХК (Pojist'ovna VZP, a.s.)-ийн арилжааны (гэрээт) даатгалд даатгуулна.

в) Жирэмсэн эх нийтийн даатгалд хамрагдсан, жирэмсэн эх эсвэл хүүхдийн эцгийн аль нэг нь байнга оршин суух зөвшөөрөлтэй байх

Энэ тохиолдолд жирэмсэн эх өөрийгөө жирэмсний болон амаржсаны даатгалд даатгуулах шаардлагагүй. Эцэг эх нь нярай хүүхдээ төрсөн өдрөөс нь эхлэн 60 хоногийн дотор байнга оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргасан тохиолдолд хүүхэд төрсөн эхний өдрөөсөө эхлэн буюу уг хүсэлтийн хариуд шийдвэр гарах хүртэлх хугацааны туршид эцэг, эхийнхээ нэгэн адил нийтийн эрүүл мэндийн даатгалд хамрагдана.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, НАРИЙН МЭРГЭЖЛИЙН БОЛОН ЯАРАЛТАЙ ҮЙЛЧИЛГЭЭГ ХЭРХЭН АВАХ ТУХАЙ

Хүн бүр өрхийн эмчид бүртгүүлнэ. Өрхийн эмч өвчний түүх хөтлөх, эрүүл мэндийн ердийн үйлчилгээ үзүүлэх, мөн шаардлагатай тохиолдолд нарийн мэргэжлийн эмчийн хяналтанд шилжүүлдэг.

Өрхийн эмчид бүртгэлтэй байх нь гэнэтийн ямар нэгэн тохиолдол болоход эмч эрж хайх шаардлагагүй давуу талтай байдаг тул өрхийн эмчид аль болох ойрын хугацаанд бүртгүүлэх нь чухал. Интеграцчилалын төвүүд танд өрхийн эмч олоход тусална (утас, хаяг зэргийг **Холбоо барих** хэсгээс үзнэ үү).

Нарийн мэргэжлийн эмчид үзүүлэхийн тулд өрхийн эмчээсээ илгээх хуудас авна.

Эмэгтэйчүүдийн, шүдний гэх мэт зарим нэг нарийн мэргэжлийн эмч нарын байнгын үйлчлүүлэгчдийн тоо дүүрснээс шинэ үйлчлүүлэгч бүртгэж авахгүй тохиолдолд өөр эмчид хандах хэрэгтэй.

Ажлын бус цагаар эрүүл мэндийн яаралтай тусламж шаардагдсан тохиолдолд (насанд хүрэгсэд, хүүхэд, шүдний) яаралтай тусламж үзүүлдэг эмнэлэгийн тасагт хандаж болно.

МЭДЭЭЛЭЛ, ТУСЛАЛЦАА

БНЧУ-ын эрүүл мэндийн салбар, эрүүл мэндийн даатгал, мэдээлэл, хууль эрх зүй

Эрүүл мэндийн яам

www.mzcr.cz

Өвчтөний эрх, эмнэлгийн эрх зүйн тухай мэдээлэл

www.ferovanemocnice.cz

Эмчийг мэргэжил, бүс нутгаар нь хайх

www.znamylekar.cz



НИЙГМИЙН ХАНГАМЖ, НИЙГМИЙН ХАНГАМЖИЙН ТОГТОЛЦОО

Өмнөд Моравад орших Зноймо хотын үзэсгэлэнт гудамж

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУД, МЭДЭЭЛЭЛ

Нийгмийн хангамжийн тогтолцоо, мэдээлэл, хууль эрх зүй, нийгмийн хангамж, даатгалын тухай хоёр талын хэлэлцээр:

Хөдөлмөр, нийгмийн хэргийн яам

www.mpsv.cz

Нийгмийн хангамж, мэдээлэл, нийгмийн хангамж, даатгалын тухай хоёр талын хэлэлцээрийн жагсаалт, холбоо барих хаяг, утас:

Чехийн нийгмийн хангамжийн асуудал эрхэлсэн газар

www.cssz.cz

БНЧУ-ЫН НИЙГМИЙН ХАНГАМЖ

Нийгмийн хангамж нь нийгмийн таагүй нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх, газар авахуулахгүй байх, шийдэх боломж олгодог системт хэрэгсэл бөгөөд эв санааны нэгдлийн (эдийн засгийн идэвхтэй иргэд нь эдийн засгийн идэвхгүй иргэдээ дэмждэг) дэмжлэг, тусалцаа, хамтын оролцооны зарчим дээр үндэслэдэг.

Нийгмийн хангамжийн систем нь **нийгмийн тэтгэмж** (нийгмийн даатгал, улсын нийгмийн тусламж, нийгмийн тусламж), **нийгмийн халамжийн үйлчилгээ** (төрийн харьяа байгууллага эсвэл ТББ-ын ажиллуулдаг), **түр байрлуулах нийгмийн үйлчилгээ** (хөнгөлөлттэй нөхцлөөр эсвэл түр хамгаалан байрлуулах үйлчилгээ) гэсэн гурван хэсгээс бүрддэг хоорондоо уялдаа холбоо бүхий иж бүрэн тогтолцоо юм.

Чех Улсад нийгмийн хангамжийн салбарыг **БНЧУ-ын Хөдөлмөр, нийгмийн хэргийн яам** хариуцдаг бөгөөд тус яамны харьяа **Чехийн нийгмийн хангамжийн асуудал эрхэлсэн газар** тэтгэвэр, өвчний даатгалын олговор олгохтой холбоотой асуудлыг хариуцна. **БНЧУ-ын Хөдөлмөр, нийгмийн хэргийн яамны харьяа Хөдөлмөрийн товчоо** нь төвийн болон аймгийн салбар, хэлтсүүдээрээ дамжуулан хөдөлмөр эрхлэлт, нийгмийн тэтгэмж, тэтгэвэр, амьдралын хүнд нөхцөлд орсон иргэдэд үзүүлэх тусламж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн халамж зэргийг хариуцан ажилладаг.

БНЧУ-ЫН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТОГТОЛЦОО

Нийгмийн даатгалын тогтолцоонд тэтгэврийн даатгал, хөдөлмөр эрхлэлтийн төрийн бодлогын шимтгэл, өвчний даатгал тус тус ордог. Нийгмийн даатгалыг улсын төсвөөс гаргадаг дараах төрлийн олговорт зарцуулна. Үүнд,

- тэтгэврийн даатгалын олговор (өндөр насны тэтгэвэр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр, бэлэвсэрсний болон тэжээгчээ алдсан/өнчирсний тэтгэмж),
- Хөдөлмөрийн товчоонд бүртгэлтэй иргэдэд олгодог ажилгүйдлийн тэтгэмж, хөдөлмөр эрхлэх эрхийг хангахтай холбоотой бусад зардал,
- өвчний даатгалын олговор (өвчний, асрамжийн тэтгэмж, жирэмсний болон амаржсаны нөхөн олговор, хүүхэд асарсан үеийн мөнгөн тусламж).

Эдийн засгийн идэвхтэй иргэд буюу өөрөөр хэлбэл хөдөлмөр эрхэлж буй иргэд, хувиараа бизнес эрхлэгч (ОСБЧ/ОСВЦ) хүн бүр нийгмийн даатгалын санд тодорхой хэмжээний шимтгэлийг заавал төлнө. Ажил олгогч ажилтнуудаа нийгмийн даатгалд бүртгүүлдэг бол бизнес эрхлэгчид өөрсдөө бүртгүүлнэ.

“Бизнес эрхлэлт” бүлэгт дурдсанчлан хуульд заасан нөхцлийг бүрэн хангасан тохиолдолд хувиараа бизнес эрхлэгчид (ОСБЧ/ОСВЦ) тэтгэврийн даатгал, хөдөлмөр эрхлэлтийн төрийн бодлогын шимтгэлд заавал хамрагдах үүрэгтэй. Өвчний даатгалд сайн дурын үндсэн дээр хамрагдана. Бүртгүүлэх, бүртгэлээс хасуулах гэх мэт ямар нэгэн өөрчлөлт гарвал бизнес эрхлэгчид зохих газарт нь өөрсдөө мэдэгдэх үүрэгтэй.

НИЙГМИЙН ХАНГАМЖИЙН ТУХАЙ ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, ХЭЛЭЛЦЭЭР

Нийгмийн хангамжийг олон талаас нь авч үзвэл тухайн улсын нутаг дэвсгэр дээр үйлчилдэг үндэсний зохицуулалт хэдий ч зарим нэг төрлөөс нь тодорхой нөхцөлд гадаадын иргэд авах боломжтой.

Хүмүүс олноороо улс дамжин шилжин сууршиж буй даяаршлын өнөө үед Чех Улс ч нийгмийн хангамжийн тогтолцоогоо бусад улс орнуудтай хамтран зохицуулахыг эрмэлзэж байна. Иргэд улсын хил дамжин гадаад улсад шилжин суурьших явцад тэдний нийгмийн хангамжийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд гол зорилго нь оршдог. Хөдөлмөр, нийгмийн хэргийн яамны цахим хуудасны “Олон улсын харилцаа” хэсэгт нийгмийн хангамжийн тухай олон улсын гэрээний жагсаалт мөн эдгээр нь нийгмийн хангамжийн аль салбарыг хамарч байгаа талаарх мэдээлэлтэй танилцаж болно. Тодруулбал, БНЧУ, Австрали, Албани, Белорус, Босни ба Херцеговина, АНУ, Герман, Израил, Канад, Македони, Молдав, Монгол, Монтенегро, Серб, Сири, Солонгос, Тунис, Турк, Украин, Чили, Энэтхэг, Япон зэрэг улстай хоёр талын

гэрээ байгуулсан. Гэрээний бүрэн текстийг хавсаргасан дэлгэрэнгүй жагсаалтыг уг хуудсанд тавьсан холбоосоор орж үзнэ үү.

Даатгуулагч нутаг буцсан тохиолдолд нэгэнт төлсөн нийгмийн даатгалын төлбөрийг буцааж олгохгүй. Нийгмийн хангамжийн санд оруулсан мөнгөө зөвхөн дээр дурдсан олон улсын гэрээнд заасан хэлбэрээр, жишээ нь тэтгэвэр авснаар эргүүлэн авах боломжтой.

МЭДЭЭЛЭЛ, ТУСЛАЛЦАА

Нийгмийн хангамжийн тогтолцоо, мэдээлэл, хууль эрх зүй, нийгмийн хангамж, даатгалын тухай хоёр талын хэлэлцээр:

Хөдөлмөр, нийгмийн хэргийн яам

www.mpsv.cz


Нийгмийн хангамж, мэдээлэл, нийгмийн хангамжийн тухай хоёр улсын хооронд байгуулсан гэрээний жагсаалт, холбоо барих хаяг:

Чехийн нийгмийн хангамжийн асуудал эрхэлсэн газар

www.cssz.cz

БНЧУ-ын бусад орнуудтай нийгмийн хангамжийн тухай байгуулсан хоёр талын гэрээний жагсаалт:

www.cssz.cz/cz/mezinarodni-smlouvy/smlouvy-uzavrene-cr/prehled-smluv.htm



БАЙР

Нуслийн хөндий, Прага хотын үзэмж

ЧЕХ УЛСАД БАЙРНЫ АСУУДЛАА ХЭРХЭН ЗОХИЦУУЛЖ БОЛОХ ТАЛААР

Чех Улсад амьдрах байрны асуудлаа шийдэх арга зам нь бусад улсуудынхаас нэг их ялгарахгүй болов уу. Ихэнхдээ хувийн болон хоршоололын байр худалдаж авах эсвэл амины орон сууц, байр түрээслэж байрны асуудлаа шийдэх нь түгээмэл.

Үүнээс гадна оюутнуудын хувьд оюутны байр, бусад хүмүүс түрээсийн байр болон хажуу өрөө, давхар түрээслэсэн эсвэл нийтийн байранд суух боломжтой.

Гадаадын иргэн Чех Улсад орон сууцны байр, бусад үл хөдлөх хөрөнгө худалдан авахад ямар нэг хязгаарлалт байдаггүй гэдгийг мэдэхэд илүүдэхгүй байх. Гэхдээ үл хөдлөх хөрөнгө эзэмшиж байгаа нь тус улсад оршин суух зөвшөөрөл олгох үндэслэл болж чадахгүй.

БАЙР ХЭРХЭН ХАЙХ ТУХАЙ

Байрыг зарын веб хуудас, “Аннонце” (Annonce) зэрэг зар мэдээ сонин, нийгмийн сүлжээ эсвэл үл хөдлөх хөрөнгө зуучлалын компаниар дамжуулан хайна.

Үл хөдлөх хөрөнгө зуучлалын компанийн үйлчилгээ төлбөртэй байхаас гадна үйлчилгээний чанар, үнэ янз бүр байдаг учир тухайн компанийн талаар хүмүүсийн бичсэн сэтгэгдлийг унших эсвэл хэд хэдэн компанийн саналыг хооронд нь харьцуулж судалвал зүйтэй. Сонирхож байгаа байраа түрээслэх эсвэл худалдаж авах болвол захиалгын хураамж төлснөөр та давуу эрх эдэлнэ. Түрээсийн гэрээ байгуулахад байрны түрээсийн 3 сарын төлбөртэй тэнцэх мөнгийг бөөнд нь барьцаа (мөн “баталгаа” гэдэг нэр томъёо тааралдаж магад) болгон урьдчилж төлдөг. Барьцааны мөнгийг байрны эзэн эсвэл түрээслүүлэгчид төлж, хариуд нь бичгээр үйлдсэн тодорхойлолт авна. Түрээслэх хугацаа дуусахад барьцааны мөнгийг эргүүлэн өгөх үүрэгтэй. Түрээсийн мөнгө, ус, халаалт, хог зайлуулах зэрэг ашиглалтын зардлаа төлөөгүйгээс өр үүссэн гэдгийг зохих ёсоор нотолсон тохиолдолд барьцааны мөнгөнөөс суутгах эрхтэй.

БАЙР ТҮРЭЭСЛЭХ, ДАВХАР ТҮРЭЭСЛЭХ ГЭРЭЭ

Байр түрээслэх гэрээ

Байрны түрээс гэж байр эзэмшигч (түрээслүүлэгч) түрээслэгч талуудын хооронд үүсэх гэрээний харилцааг хэлнэ. Түрээсийн харилцаа нь гэрээний талууд байр,

байрны тоноглол, байр ашиглах зориулалт, түрээсийн төлбөр тооцоог төлөх арга зэрэг үндсэн зүйл агуулсан түрээсийн гэрээг бичгээр үйлдэж гарын үсэг зурснаар үүснэ. Тодорхой хугацаа заагаагүй тохиолдолд түрээсийн гэрээг хугацаагүй байгуулсанд тооцно.

Түрээсийн гэрээнд түрээслэгч талд түрээсийн харилцаанд зохихгүй торгууль эсвэл огт биелэгдэх боломжгүй үүрэг хүлээлгэхийг хориглодог. Ийм тохиролцоо хийсэн байлаа гэхэд шууд (автоматаар) хүчингүй болно. Түрээслүүлэгчийн зүгээс таныг түрээсийн байрны хаягаа Чех Улсад амьдарч буй хаяг (гадаадын иргэний хувьд “оршин сууж буй газар хэмээн бүртгүүлсэн хаяг”) гэдгээр бусдад мэдэгдэхийг хориглох эрхгүй. Учир нь гадаадын иргэн оршин сууж байгаа газрын хаягаа зохих хугацааны дотор тус улсын Дотоод хэргийн яамны харьяа хэлтэст мэдэгдэх үүрэгтэй.

Хоршоололын байр түрээслэх тохиолдолд түрээсийн гэрээг хоршоололтой байгуулна. Хоршоолол гэдэг нь байр, орон сууцыг захиран хариуцах зорилгоор байгуулагдсан нэгдэл холбоог хэлдэг бөгөөд орон сууцны хоршоолол нь гишүүдийнхээ орон сууцны хэрэгцээг хангах, орон сууцны байрыг захиран хариуцах гэх мэт зорилгоор үйл ажиллагаа явуулдаг. Хажуу өөрөө эсвэл байр давхар түрээслэх тохиолдолд түрээсийн мөнгийг бусад төлбөрийн хамт түрээслүүлэгчид шууд төлнө.



Гэрээнд гарын үсэг зурахаасаа өмнө гэрээг сайтар уншиж танилц, ойлгоогүй тохиолдолд ямар нэг гэрээнд гарын үсэг зурахгүй байхыг анхаарна уу. Шаардлагатай бол нийгмийн болон хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлдэг төрийн бус байгууллага, интеграцчилалын төвүүдэд хандаж болно.

Байр давхар түрээслэх

Байр давхар түрээслэх үед түрээслүүлэгч, давхар түрээслэгчийн хооронд харьцаа үүснэ. Түрээслүүлэгч нь гуравдагч этгээд болох давхар түрээслэгчтэй түрээсийн гэрээ байгуулж байр эсвэл түүний хэсгийг түрээслүүлнэ. Зарим нэг тохиолдолд түрээсийн байр эсвэл түүний хэсгийг байр эзэмшигчийн бичгээр үйлдсэн зөвшөөрөлгүйгээр давхар түрээслүүлж болохгүй.

Давхар түрээслэгчийн эрх түрээслэгчийнхтэй харьцуулахад хязгаарлагдмал байдаг – хоёр тал өөрөөр тохиролцоогүй бол давхар түрээсийг шалтгаан заахгүйгээр цуцалж болох ба түрээсийн хугацаа дуусахад давхар түрээсийн хугацаа ч дуусна. Үл хөдлөх хөрөнгө (байр) эзэмшигч нь зөвхөн түрээслэгчийн өмнө хариуцлага хүлээхээс бус давхар түрээслэгчийн өмнө ямар нэгэн (өөр байр олж өгөх) үүрэг хүлээхгүй.

БАЙРНЫ ТҮРЭЭСТЭЙ ХОЛБООТОЙ ТӨЛБӨР

Байр түрээслэн амьдарч байгаа тохиолдолд сар бүрийн түрээсийн төлбөрөөс гадна цахилгаан, хий, цэвэр, бохир ус, хог, цахилгаан шат, байрны нийтийн эзэмшлийн орц, шат, талбай гэх мэт ашиглалтын зардал төлнө.

Урьдчилгаа төлбөрийг жилийн туршид хийж дараа онд тооцоо гаргадаг. Тооцооноос мөнгө илүүдэлтэй гарсан бол эргүүлэн өгөх эсвэл дараа улиралд шилжүүлэх, өртэй гарсан тохиолдолд заасан хугацаанд барагдуулах үүрэгтэй.

Хэрэв та байр/амины сууцандаа радио, телевизтэй бол ашиглалтын хураамжаа (“концессийн хураамж” гэж нэрлэдэг) радио, телевизийн компанид шууд төлнө (концессийн хураамж нь байр ашиглалтын зардалд хамаарахгүй). Кабелийн телевиз, интернетийн төлбөрийг уг үйлчилгээг үзүүлж байгаа компанид төлнө.

Төлбөр хураамж барагдуулсан баримт бичиг, тасалбар, түрээс, давхар түрээстэй холбоотой бичиг баримтаа нэг бүрчлэн найдвартай хадгалагтун.

АМЬДРАХ БАЙРГҮЙ БОЛСОН ТОХИОЛДОЛД

Хэрэв та амьдрах байраа алдаж байх газаргүй болсон, мөн хамаатан садан, найз нөхөд тань туслах боломжгүй тохиолдолд “Армада спасы” (чехээр “Armáda spásy” буюу Авралын арми), “Чех Улсын Харита” (чехээр “Charita ČR” буюу ЧУ-ын Энэрэнгүй төв), “Надейе” (чехээр “Naděje” буюу Найдвар) зэрэг халамжийн байгууллагуудад түр хугацаагаар байрлах зорилгоор хандах боломжтой. Эдгээр байгууллага нь орон гэргүй хүмүүсийг хоноглох газар эсвэл түр хамгаалах байранд байрлуулах замаар тусалцаа үзүүлдэг бөгөөд зөвхөн орон гэргүй, мөнгөгүй болох гэх мэт гэнэтийн хүнд нөхцөл байдлаас гарахад зориулсан нийгмийн үйлчилгээ юм. Дэлгэрэнгүй мэдээллийг тусалцаа үзүүлдэг төрийн бус байгууллага, интеграцчилалын төвүүдээс лавлана уу.

АЮУЛ ЭРСДЭЛ, ХАМГААЛАЛ

Мөнгөө болгоомжтой, сайтар төлөвлөсний үндсэн дээр зарцуулах хэрэгтэй. Учир нь түрээсийн төлбөрөө төлөхгүй тохиолдолд байрнаасаа хөөгдөөд зогсохгүй байрны түрээсийн өртэй болж шүүхийн шийдвэрээр эд хөрөнгөө хураалгаж болзошгүй.

Хэдийгээр ноцтой бус мэт санагдавч нийтийн тээврээр тасалбаргүй зорчсон торгууль, утас, телевиз, радио, хог хаягдал зайлуулсан хураамж, зээлийн эсвэл зээлээр худалдаж авсан бараа, байрны түрээс, хий, цахилгааны төлбөр, эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлээ төлөөгүйгээс үүдэн шүүхийн шийдвэрээр эд хөрөнгөө хураалгаж болзошгүй болохыг анхаарна уу.

ЧЕХ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭРТ ОРШИН СУУГАА ХАЯГ, ХАЯГИЙН ӨӨРЧЛӨЛТИЙГ БҮРТГҮҮЛЭХ

Бүртгүүлсэн хүмүүсийн тоо

Хэрэв түрээсийн гэрээнд хоёр хүн гэж заасан бол байранд зөвхөн хоёр хүн л сууна. Гадаадын иргэд Чех Улсад оршин суух тухай хуульд зааснаар гадаадын иргэний сууж буй байранд тавигдах шаардлага нь эрүүл ахуйн нөхцөл, байранд сууж буй хүний тоонд ногдох м кв. талбай (хүн тутамд 8 м кв., хоёр хүнд 12,6 м кв. тус тус ногдох ба түүнээс дээш хүн тутамд 5 м кв. нэмэгдэх дүрэмтэй) уг байранд амьдарч байгаа хүний тоотой тохирч байгаа эсэхийг хянана.

Оршин суугаа газрын хаяг өөрчлөгдсөн тухай мэдэгдэх, баталгаат захидлын тухай

Чех Улсад оршин сууж байгаа хаяг өөрчлөгдсөн тухай бүрд нь Дотоод хэргийн яамны салбар, хэлтэст заасан хугацаанд мэдэгдэнэ.

Төрийн болон бусад албан байгууллагаас таны нэр дээр чухал ач холбогдол бүхий баталгаат захидал илгээсэн тохиолдолд хэдийгээр та өөрийн гар дээр аваагүй ч шуудангийн салбарт захидлыг 10 хоног хадгалсаны дараа танд хүргүүлсэнд тооцдог. Таны нэр дээр ирсэн захидлыг шуудангийн салбарт хадгалсан тухай мэдэгдлийг танай шуудангийн хайрцагт эсвэл тохиромжтой өөр газарт үлдээдэг.

Шуудангийн хайрцаг, гадаа хаалганы дэргэд байрлуулсан хонхон дээр овог нэрээ бүрэн зөв, гаргацтай тод бичих нь шуудан хүргэгч таны нэр дээр ирсэн захидал, илгээмжийг зохих ёсоор хүргэхэд ач холбогдолтой.



ГЭР БҮЛ, ЭРХ ТЭГШ БАЙДАЛ, ХҮҮХДҮҮД

Хоёр жаал Прага хотын төвд

Чех Улсад гэр бүл гэж гэрлэлтийн үр дүнд бий болсон удаан хугацааны хамтын амьдрал эсвэл хамтран амьдарч буй хосуудын хоорондын харилцааг хэлнэ. Эцэг эх, үр хүүхдийн хамт ам бүл болдог бол өвөө, эмээ, хамаатан садныг ураг садан гэж үздэг. Гэр бүл нь моногами хэлбэртэй буюу хуулиар нэг эхнэр, нэг нөхөртэй байхыг зөвшөөрдөг. Эцэг, эх хоёулаа хамтран үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлнэ.

Хосууд иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх газарт батлуулж эсвэл сүмд хуримладаг. Ижил хүйстэн хосуудыг хамтран амьдрагчаар бүртгүүлэхийг зөвшөөрдөг.

ГЭРЛЭЛТ

Гэр бүлийнхээ өмнө эхнэр нөхөр хоёрын хүлээх эрх үүрэг тэгш байх ба гэр бүлийн аливаа асуудлыг хамтран шийднэ. Эхнэр нөхөр хоёулаа амьжиргааны ижил түвшинд амьдрах эрхтэй.

Хосууд нь иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх газрын төлөөлөгч, сүмийн эсвэл шашны эрх бүхий нийгэмлэг, холбоонд хоёр гэрчийг байлцуулан гэрлэлтээ батлуулдаг. Гэрлэлт батлуулахад шаардагдах бичиг баримтыг гадаад улсад олгосон байвал олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол зохих ёсоор баталгаажуулж чех хэлний албан ёсны орчуулгын хамт бүрдүүлнэ.

Чех хэлээр ярьдаггүй, ойлгодоггүй гадаадын иргэн, бүрэн хэлгүй, сонсголгүй иргэнтэй гэрлэлтээ батлуулах тохиолдолд заавал хэлмэрч байлцуулна. Хэрмэрчгүй тохиолдолд гэрлэлтийг батлахгүй.

Хосууд албан ёсоор гэрлэснээр гэрлэгсдийн дундын өмч үүсдэг. Эд хөрөнгө хамтран өмчлөх энэхүү өвөрмөц хэлбэр нь гагцхүү гэрлэгсдийн хооронд үүсдэг бөгөөд хуульд заасан эд хөрөнгө хамтран өмчлөх ердийн нөхцлөөс тусгайлан зохицуулагддаг. Гэрлэгсэдийн дундын өмчид эхнэр, нөхрийн хэн нэг нь эсвэл хоёулаа хамт амьдрах хугацаандаа хуримтлуулсан эд хөрөнгө, өр төлбөр багтана. **Гэрлэгсдийн хамтран өмчлөх дундын өмчид орон байр төдийгүй байрны зээл ч орно.** Дундын өмчийн цар хүрээг нотариатчийн үйлдсэн гэрээ эсвэл шүүхийн шийдвэрээр өөрчлөх боломжтой.

Эхнэр нөхөр хоёр өмчөө хамтран ашиглаж, хадгалж хамгаална. Худалдан авалт, засвар хийх гэх мэт өдөр тутмын асуудлыг бие даан шийдэж болох ч бизнес эрхлэх зорилгоор дундын өмчөө ашиглах зэрэг бусад асуудлыг гэрлэгсэд хамтран зөвшилцөж шийднэ.

Гэрлэлтээ албан ёсоор батлуулаагүй ч нэг гэрт хамтран амьдарч, хүүхэдтэй болсон хосууд элбэг. Ийм хосууд нь албан ёсоор гэрлэлтээ батлуулсан хосуудтай ижил эрх эдлэх бөгөөд эдний дундаас төрсөн хүүхэд, албан ёсоор гэрлэсэн хосуудын дундаас төрсөн хүүхэдтэй ижил эрх эдэлнэ.

ШИНЭЭР ХҮҮХЭДТЭЙ БОЛОХ

Та хүүхэдтэй болохоор төлөвлөж байгаа бол шинэ төрсөн хүүхдээ төрсөн газрын (засаг захиргааны) харьяалалын дагуу иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх газарт (чех хэлээр “матрика”/„matrika“ гэж хэлдэг) ажлын 3 хоногт багтаж бүртгүүлэх үүрэгтэй болохоо анхаарна уу. ИГБББГ шинээр төрсөн хүүхдийг төрөгсдийн бүртгэлд бүртгэж, төрсний гэрчилгээ олгоно. Амаржих газар шинэ хүүхэд төрсөн тухай (эмчлэгч эмч) мэдэгддэг боловч мэдэгдээгүй тохиолдолд эцэг, эхийн аль нэг нь мэдэгдэх үүрэгтэй. Хүүхдийн төрсний гэрчилгээ авахад бүрдүүлэх бичиг баримтын жагсаалтыг ИГБББГ, эмэгтэйчүүдийн эмч эсвэл амаржих газрын эмчээс авна. Төрсний гэрчилгээг хүүхэд төрснийг мэдэгдсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор олгоно.

БНЧУ-ын нутаг дэвсгэрт мэндэлсэн гадаадын иргэн-нярай хүүхэд төрснөөсөө 60 хоногийн дотор тус улсаас гарах тохиолдолд хүүхдийн хууль ёсны төлөөлөгч (эцэг эх) нь өөрсдөө оршин суух зөвшөөрөлтэй эсвэл визтэй бол хүүхдийнхээ өмнөөс оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргах шаардлагагүй, түүнийг тус улсад “түр хугацаагаар” оршин сууж байгаа гэж үздэг. Хүсэлтийг эх оронд нь суугаа БНЧУ-ын дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан гаргана.

Харин нярай хүүхэд эцэг эхийн хамт Чех Улсад 60-аас дээш хоногоор оршин суух тохиолдолд хүүхдийн хууль ёсны төлөөлөгч (эцэг эх) нь хүүхэд төрсөн өдрөөс нь эхлэн 60 хоногийн дотор хүүхдийнхээ өмнөөс оршин суух эрх авах хүсэлт гаргах шаардлагатай.

Эцэг эх нь хүүхэддээ өөрийн оршин суух эрхтэй ижил төрлийн эрх авах хүсэлт гаргана. Иймд,

- эцэг эхийн аль нэг нь Чех Улсад богино хугацааны визтэй оршин сууж байгаа бол – **90 хүртэл хоногийн виз (богино хугацааны виз);**
- эцэг эхийн аль нэг нь Чех Улсад удаан хугацааны визтэй оршин сууж байгаа бол – **90-ээс дээш хоногийн виз (удаан хугацааны виз);**
- эцэг эхийн аль нэг нь Чех Улсад удаан хугацааны оршин суух зөвшөөрөлтэй оршин суудаг бол – **удаан хугацааны оршин суух зөвшөөрөл;**
- эцэг эхийн аль нэг нь Чех Улсад байнга оршин суух зөвшөөрөлтэй оршин суудаг бол – **байнга оршин суух зөвшөөрөл** тус тус хүсэх эрхтэй.

Чех Улсын нутаг дэвсгэрт төрсөн хүүхдийн оршин суух эрхийг авахын тулд удаан хугацааны виз/удаан хугацааны эсвэл байнга оршин суух зөвшөөрлийн хүсэлтийн маягт бөглөх, харьяат улсаас нь хүүхдэд олгосон гадаад паспорт эсвэл хүүхдийн нэр бичигдсэн бол эцэг, эхийн паспорт, эрүүл мэндийн даатгалд даатгуулсан тодорхойлолт (байнга оршин суух зөвшөөрөл хүсэхэд бүрдүүлэх шаардлагагүй) зэрэг материал бүрдүүлнэ. Хүүхэд оршин суух эрх авах хүсэлтийнх нь хариу гарч, удаан хугацааны виз/оршин суух зөвшөөрлийн үнэмлэх хүлээн авахаасаа өмнө Чех Улсаас гарч явсан тохиолдолд тус улсын хилээр дахин нэвтэрч, эргэн орж ирэх боломжгүй болохыг анхаарна уу.

Хуульд заасан хугацааны дотор байнга оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргасан тохиолдолд гадаадын иргэн-нярай хүүхдийг төрсөн өдрөөс нь эхлүүлэн хүсэлтийн хариу шийдвэр хүчин төгөлдөр болох өдрийг хүртэл байнга оршин суух зөвшөөрөлтөйд тооцно. Ийм тохиолдолд хүүхэд төрсөн өдрөөс эхлэн шийдвэр хүчин төгөлдөр болох өдрийг хүртэлх хугацаанд (хүсэлтийг нааштай шийдсэн болон цаашдаа ч) нийтийн эрүүл мэндийн даатгалд даатгуулна. Шаардагдах бүх бичиг баримтыг (жишээлбэл хүүхдэд гадаад паспорт авах) бүрэн бүрдүүлэх гэж цаг алдах хэрэггүй. Бичиг баримт дутуу байсан ч хүсэлтээ гаргавал дараа нь нөхөж бүрдүүлж болно. Нярай хүүхэд байнга оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргаагүй тохиолдолд төрсөн өдрөөсөө эхлэн нийтийн эрүүл мэндийн даатгалд хамрагдахгүй болохыг анхаарна уу.



ЖИРЭМСЭН БОЛОН НЯРАЙ, ХӨХҮҮЛ ХҮҮХЭДТЭЙ ЭХИЙН БОЛОН ЭЦЭГ, ЭХИЙН ЧӨЛӨӨ

Хүүхдийн хүмүүжилд эцэг эхийн оролцоо ижил тэгш байх нь хамгийн зөв. Эцэг эх нь хүүхдээ сургуулиа төгсгөл (26 нас хүртэл) тэжээх үүрэгтэй.

Нялх хүүхэдтэй болсон эцэг эхэд төрөөс төрөл бүрийн тусламж үзүүлдэг бөгөөд ажлаас чөлөө (жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн чөлөө, хүүхэд асрах эцэг, эхийн чөлөө) олгох жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж, хүүхэд асрах эцэг, эхийн тэтгэмж зэрэг мөнгөн тэтгэмж авах эрхийг хуулиар хангадаг. Ажлаас чөлөө олгох, тэтгэмж авахыг “матержска” („mateřská“), хүүхэд асрах эцэг эхийн чөлөө, тэтгэмжийг “родичовска” („rodičovská“) гэж чех хэлээр товчилж нэрлэж байгаа хэдий ч эдгээр нь хоорондоо эрс ялгаатай ухагдахуун тул тавигдаж буй шаардлага болзол ч үүнтэй уялдан өөр өөр байдаг. Дэлгэрэнгүй мэдээлэл шаардлагатай болсон тохиолдолд холбогдох хаяг, утасны дугаарыг товхимлын сүүлийн бүлэгт байгаа интеграцчилалын төв, төрийн бус байгууллагуудын мэргэжилтнүүдээс авна уу.

Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн чөлөө буюу ажлаас чөлөө (чехээр “матержска”/„mateřská“ гэх) олгох эрхийг зөвхөн хөдөлмөр эрхэлдэг эмэгтэй эдлэнэ. Энэ эрх нь эмчийн зааснаар төрөхөөс 6 – 8 долоо хоногийн өмнө эхэлж нийтдээ 28 долоо (ихэр хүүхэд төрүүлсэн бол 37 долоо) хоногийн хугацаанд үргэлжилнэ. Хуульд заасны дагуу зарим нэг онцгой тохиолдолд уг чөлөөний хугацааг богиносгодог ч 14 долоо хоногоос бага байж болохгүй, мөн жирэмсэн эх амаржаад



6 долоо хоног өнгөрөөгүй байхад чөлөөг нь дуусгах, түр зогсоох ёсгүй. Ажилтан нь ажил олгогчоос чөлөө олгуулах хүсэлт гаргах шаардлагагүй, жирэмсний болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн чөлөө авах тухайгаа бичгээр мэдэгдэхэд хангалттай. Ажлаас чөлөө олгосон хугацаанд жирэмсэн эмэгтэйд ажил олгогч цалин өгөхгүй.

Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн чөлөө, тэтгэмж авах болзлыг хангаагүй эмэгтэй хүүхдээ төрмөгц хүүхэд асрах эцэг, эхийн тэтгэмж авах хүсэлт гаргах боломжтой.

Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн чөлөөг ихэнхдээ хүүхдийн эх эдэлдэг хэдий ч хүүхэд асрах чөлөө олгохыг эцэг нь хүсэх боломжтой. Хүүхэд асрах чөлөөг эхийн гаргасан өргөдлийг үндэслэн жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн чөлөө дууссанаас эхлэн хүүхэд гурван нас хүртэлх хугацаанд олгох бөгөөд эцэгт нь мөн өргөдлийн үндсэн дээр хүүхэд төрснөөс 14 долоо хоногоос эхлээд гурван нас хүртэлх хугацаанд олгодог. Ажил олгогч эцэг, эхэд өргөдлийнх нь дагуу хүүхэд асрах цалингүй чөлөө олгох үүрэгтэй.

Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн чөлөө авсан эх улсын өвчний даатгалын сангаас тэтгэмж авах эрхтэй бөгөөд хэмжээг нь ажил олгогчоос олгосон цалингийн тодорхойлолтыг үндэслэн тогтооно. Уг тэтгэмжийг авахын тулд сүүлийн хоёр жилийн хугацаанд дор хаяж 270 хоног өвчний даатгалд хамрагдсан байх зэрэг хуульд заасан нөхцлийг хангасан байна.



Хүүхэд асрах чөлөө авсан эцэг эх улсаас нийгмийн тэтгэмжийн нэг төрөл болох хүүхэд асрах тэтгэмж авна. Нэг хүүхдэд ногдох нийт хэмжээ нь 300 000 чех крон бүхий уг тэтгэмжийг хүүхдийн 4 нас хүртэлх хугацаанд сар тутам авах боломжтой. Сар бүр олгож байгаа тэтгэмжийн хэмжээ нь тэтгэмж авах нийт хугацаанаас хамаарах ба өөрөөр хэлбэл тэтгэмж авах нийт хугацаа уртсах тусам сард авч байгаа тэтгэмжийн хэмжээ бага байна гэсэн үг.

ЧЕХИЙН НИЙГЭМД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

Чех Улсад эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн нэгэн адил тэгш эрхтэй.

Эмэгтэйчүүд энэ нийгмийн бие даасан, эрх чөлөөт иргэд.

Жирэмсний, нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн чөлөө, хүүхэд асрах эцэг эхийн чөлөө авснаас бусад үед эмэгтэйчүүд хөдөлмөр эрхэлж, бизнес хийдэг. Жил ирэх тутам хүүхэд асрах эцэг эхийн чөлөөг аав нар авах нь ихсэж байна.

Эмэгтэйчүүд театр, ресторан, кинотеатр гэх мэт олон нийтийн үзвэр үйлчилгээний газраар чөлөөтэй үйчлүүлдэг.



ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

Гэр бүлийн хүчирхийлэл гэдэг нь гэр бүлийн гишүүд, ойр дотны хүмүүсийн хэн нэг нь нөгөөгөө удаан хугацаагаар дарамтлах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбод, сэтгэл санаанд нь халдсан үйлдлийг хэлнэ. Халдлага нь дарамталж байгаа хүнээ хэл амаар доромжлох, ёжлох, бусдаас тусгаарлах, заналхийлэх, айлган сүрдүүлэхээс эхлээд бие махбодод нь халдах, сэтгэл санаагаар дарамтлах зэрэг янз бүрийн хэлбэртэй байдаг.


Үндсэн хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эрүүгийн хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хохирогчийг хүчирхийллийн аль ч хэлбэрээс хамгаалдаг. Гэр бүлийн хүчирхийллийг ихэвчлэн “нэг гэрт хамт амьдарч байгаа хүмүүсийн нэг нь нөгөөдөө дарамт шахалт үзүүлдэг” хэмээн зүйлчилж, хэрэг үйлдсэн этгээдэд 8 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулж болзошгүй юм.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид (заавал биеийн болон бэлгийн байх албагүй) БНЧУ-ын Цагдаагийн газарт хандах нь зүйтэй. Цагдаагийн алба хаагчид ноцтой гэж үзсэн тохиолдолд хүчирхийлэгчийг 10 хүртэл хоногоор орон гэрээс нь гаргаж тусгаарлах эрхтэй. Асуудлыг шүүхийн журмаар шийдвэрлүүлэх тохиолдолд хүчирхийлэгчийг захирамжилсан арга хэмжээний үндсэн дээр хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн шийдвэр гарах хүртэл гэрт нь оруулахгүй хугацааг сунгуулах боломжтой. Хэрэв та цагдаагийн газарт шууд хандахаас эмээж байгаа бол наанадаж уя асуудлаар үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагад хандвал зохино.

Энэ байгууллагууд

- онцгой тохиолдолд туслалцаа үзүүлэх – нууц хаяг бүхий аюулгүй байранд байрлуулах;
- нууц хаяг бүхий түр хамгаалах байранд байрлуулах;
- гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчдөд зөвлөгөө үзүүлэх;
- гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой үйлдэгдсэн гэмт хэргийн хохирогчдыг хууль эрх зүйн мэдээллээр хангах;
- нууц хаяг бүхий дараагийн шатны хамгаалах байранд байруулах зэрэг чиглэлээр туслалцаа үзүүлнэ.

Гэр бүлийн хүчирхийллийн үед зөвлөгөө, туслалцаа үзүүлдэг байгууллагуудын жагсаалт, холбоо барих утас, хаяг зэргийг тус товхимлын **Холбоо барих** хэсгээс үзнэ үү.



ЗӨВЛӨМЖ

Терчино удоли хэмээх Байгалийн үндэсний цогцолборт газрын хүрхрээ



ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ТУСЛАЛЦАА, МЭДЭЭЛЭЛ

Шаардлагатай тохиолдолд иргэдэд үнэ төлбөргүй туслалцаа үзүүлж, хууль зүйн болон нийгмийн асуудлаар зөвлөгөө өгөх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг интеграцчилалын төв, төрийн бус байгууллагад хандах хэрэгтэй.

ХӨДӨЛМӨР ЗУУЧЛАЛЫН ТӨВҮҮД

Хөдөлмөр зуучлалын төв хэр найдвартай болохыг сайтар магадлах хэрэгтэй. Хөдөлмөр, нийгмийн хэргийн ямны цахим хуудаснаас үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл бүхий зуучлалын төв, компанийн жагсаалтыг үзэх боломжтой.

Чех Улс руу явах, оршин суух асуудлаа шийдэхийн тулд илүү мөнгө төлөх хэрэггүй – ихэнх зүйлээ та өөрөө хөөцөлдөж чадна! Элчин сайдын яам, БНЧУ-ын Дотоод хэргийн яамны гадаадын иргэдэд зориулсан албан ёсны цахим хуудас, албан ёсоор үйл ажиллагаа явуулдаг чехийн төрийн бус байгууллагууд, интеграцчилалын төвүүдээр дамжуулан найдвартай мэдээлэл олж ав. Албан ёсны цахим хуудаснаас бусад эх сурвалжаас олж авсан мэдээлэлд зуун хувь итгэж болохгүй.

БИЕЙН БАЙЦААЛТ, БИЧИГ БАРИМТ

Өөрийнхөө оршин суух зөвшөөрлийн цахим үнэмлэх, гадаад паспортоо хэзээ ч бусдад өгч болохгүй, чухал бичиг баримтынхаа хуулбарыг хийж, нотариатаар баталгаажуулж авах нь зөв.

Чех Улсад зорчихдоо өөрийнхөө болон хүүхдийнхээ (тантай цуг ирсэн бол) боловсролын гэрчилгээ, вакцинажуулалтын товлолын дэвтэр, шаардлагатай бусад бичиг баримтаа биедээ авч ирэх нь зүйтэй.

БНЧУ-д оршин суух зөвшөөрлийн цахим үнэмлэхээ гээж, гэмтээсэн тохиолдолд шинэ үнэмлэх гаргуулах төлбөр маш өндөр тул сайтар хамгаалж, хадгалагтун.

ИТГЭЖМЛЭЛ

Гэрээнд гарын үсэг зурах, албан захидал хүлээн авах зэрэг та өөрөө хөөцөлдөж чадах эсвэл хөөцөлдөх үүрэгтэй асуудлаар тодорхой хугацаа заагаагүй ерөнхий итгэмжлэл үйлдэн таныг төлөөлөх эрхийг бусдад олгож болохгүй. Итгэмжлэлийг тодорхой ямар нэг үйлдэл хийлгэх зорилгоор, тодорхой заасан хугацаанд, тодорхой этгээдэд

өөрийгөө төлөөлүүлэхээр олгодог. Итгэмжлэлийг шаардлагатай үед зөвхөн таны итгэлийг хүлээсэн гэр бүлийн хүмүүс эсвэл сайн найз нөхдөдөө өгөх нь зүйтэй.

Баримт бичгээ нэг бүрчлэн найдвартай сайн хадгалагтун. Эрхэлж буй ажлын, байрны гэх мэт ерөөсөө ямар нэг чухал гэрээ, хэлэлцээрийг ямагт бичгээр байгуулах шаардлагатай. Ингэснээр та өөрийгөө болон өөрийнхөө эрх ашгийг ямар нэг маргаан үүсэх тохиолдолд хамгаалах боломжтой болно.

ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛ

Та хөдөлмөрийн гэрээ, ямар үндсэн үүрэг гүйцэтгэх ямагт бичгээр байгуулах шаардлагатай. Таныг Чех Улсад ирсний дараа тохиролцсноос өөр, тэвчишгүй хөдөлмөр хийлгүүлсэн тохиолдолд энэ нь ажил олгогчийн зүгээс залилан мэхлэх гэмт хэргээр зогсохгүй хөдөлмөрийн эсвэл бэлгийн мөлжлөг хийх зорилгоор хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн байж болох юм. Энэ нь эр эм ямар ч хүнд хүйс харгалзалгүй тохиолдож болох бөгөөд ийм гэмт хэрэг үйлдсэн эсэхийг хүнтэй ёс бус байдлаар харьцах, хэтэрхий олон цагаар илүү ажиллуулах, эрүүл ахуйн тохиромжгүй нөхцөлд байлгах, эрүүл мэндэд эрсдэлтэй эсвэл сөрөг нөлөөтэй ажил хийлгүүлэх, зохиомол өр төлүүлэх, бэлгийн мөжлөгт өртсөн зэргээр илрүүлэх боломжтой. Ийм тохиолдолд та нэн даруй энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэшсэн ТББ (Байгууллага, холбоо барих хэсгээс үзнэ үү) эсвэл БНЧУ-ын Цагдаагийн газарт хандаж өөрийгөө хамгаалуулах нь зүйтэй. Та гэрчийн мэдүүлэг өгснөөр гэмт хэрэгтэнд хариуцлага тооцож таны нэгэн адил бусад хохирогчийг хөдөлмөрийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх боломжтой болно.

ӨР ТӨЛБӨР, ӨР ТӨЛБӨРГҮЙ БАЙХ ТАЛААР

Өр төлбөр тавьж шүүхийн шийдвэрээр эд хөрөнгөө хураалгах нь таныг зөвхөн мөнгө санхүүгийн хувьд хүнд байдалд оруулаад зогсохгүй тус улсад хууль бусаар оршин суух байдалд ч хүргэж болох эрсдэлтэй тул мөнгө зээлэх, ялангуяа “бичиг баримт шаардагдахгүй түргэн шуурхай мөнгө зээлүүлнэ” гэсэн зарын дагуу банк бус байгууллагаас мөнгө зээлэхээс болгоомжлогтун. Хэдийгээр ноцтой бус мэт санагдавч нийтийн тээврээр тасалбаргүй зорчсон торгууль, утас, телевиз, радио, хог хаягдал зайлуулсан хураамж, зээлийн эсвэл зээлээр худалдаж авсан бараа, хий, цахилгааны төлбөр, байрны түрээс, эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүйн улмаас торгууль ногдуулж алданги тооцож болзошгүй.

Чех Улсад өртэй этгээдийн бүртгэл хөтөлдөг. Бизнес эрхлэх, оршин суух зөвшөөрлөө шийдэхийн тулд өр төлбөргүй байх шаардлагатай.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ САХИН МӨРДӨХ

Оршин суух, хөдөлмөр эрхлэхтэй холбоотой хууль тогтоомжоос гадна Чех Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй ямарваа нэг хууль тогтоомжийг зөрчвөл таныг зөвхөн Чех Улсаас гаргаад зогсохгүй цаашлаад Шенгений мэдээллийн системд (SIS) оруулах хүртэл хэмжээнд хүрч болзошгүй. Ийм тохиолдолд та Шенгений гэрээний орнуудаар зорчих эрхээ хасуулна.

ЧЕХ УЛСАД ОРШИН СУУГАА ХАЯГАА ӨӨРЧЛӨХ ТОХИОЛДОЛД

Чех Улсад оршин суугаа гэрийн хаягаа өөрчилж нүүсэн тохиолдолд энэ тухайгаа хуульд заасан хугацааны дотор Дотоод хэргийн яаманд мэдэгдэх үүрэгтэй. Албан байгууллагаас таны нэр дээр чухал ач холбогдол бүхий баталгаат захидал илгээсэн тохиолдолд хэдийгээр та өөрийн гар дээр аваагүй ч шуудангийн салбарт захидлыг 10 хоног хадгалсаны дараа танд хүргүүлсэнд тооцдог. Таны нэр дээр ирсэн захидлыг шуудангийн салбарт хадгалсан тухай мэдэгдлийг танай шуудангийн хайрцагт эсвэл тохиромжтой өөр газарт үлдээдэг.

ОНЦГОЙ ТОХИОЛДОЛД ХЭРЭГТЭЙ БОЛОХ ҮҮДНЭЭС ХУРИМТЛУУЛСАН МӨНГӨ

Боломж гарах бүрд мөнгөө цааш нь хадгалж онцгой тохиолдол, нутаг буцах гэх мэт гэнэтийн шаардлага гарсан үед санхүүгийн хуримтлалтай байх нь маш чухал.



ЧЕХҮҮДИЙН ӨДӨР ТУТМЫН АМЬДРАЛААС

Орлицке уулан дахь зуслангийн байшин

ШУУРХАЙ ДУУДЛАГЫН ДУГААР

Шуурхай дуудлага 112

Шуурхай дуудлагын 112 дугаараар ЕХ-ны бүх гишүүн орнуудын аврах ангид суурин болон үүрэн утаснаас дуудлага өгч болно. Дуудлага ЕХ-ны нийт нутаг дэвсгэр дээр үнэ төлбөргүй байдаг бөгөөд дуудлага өгсөн этгээдийн байршлыг тогтоох боломжтой.

Шуурхай дуудлагын 112 дугаар нь Европын Холбооны болон зарим улсын нутаг дэвсгэр дээр гэнэтийн осол аваар, аюултай тулгарах үед (гал түймэр унтраах анги, цагдаагийн алба, түргэн тусламж) яаралтай тусламж эрж байгаа хүн бүхэнд зориулагдсан болно.

Шуурхай дуудлагын 112 дугаарын диспетчер нь гадаадын олон хэлээр ойлголцдог тул чех хэл мэдэхгүй хүн ч хандаж болно. Таны үүрэн утасны нэгж дууссан, SIM картгүй эсвэл тухайн газар сүлжээ муу байгаа гэх мэт ямар ч нөхцөлд дуудлага өгөх боломжтой.

Эрүүл мэнд, хэрэг зөрчил гэх мэт асуудлаар дотоодын үндэсний дугаараар дуудлага өгдөг болохыг анхаарна уу.

150 гал түймэр унтраах анги

155 түргэн тусламж

158 цагдаа

156 хотын цагдаа

Дотоодын эдгээр дугаарууд нь шуурхай дуудлагын 112 дугаартай үүрэг агуулгаараа эн тэнцүү байдаг.

Амь насанд нь аюул учирсан хүн бүхэн эрүүл мэндийн үйлчилгээ авах бөгөөд даатгалгүй гадаадын иргэнээс өр төлбөрийг дараа нь нэхэмжилнэ.

ТЭЭВЭР

Хотын нийтийн тээвэр нь тухайн хотоос хамааран автобус, трамвай, троллейбус, метро (зөвхөн Прагад байдаг) гэсэн хэд хэдэн төрлөөс бүрддэг. Нийтийн тээврийн үйлчилгээ төлбөртэй, мөн хот бүр өөрийн үнэ тарифын системтэй байдаг. Зорчих тасалбар худалдан аваад заавал зориулалтын автомат төхөөрөмжид хийж тэмдэглүүлнэ. Төлбөргүй зорчих нөхцөлд хамрагдаагүй л бол биедээ авч яваа ачаа бараа, нохойдоо ч тасалбар авах шаардлагатай. Байцаагч зорчих тасалбартай эсэхийг шалгаж тасалбаргүй зорчигчдод өндөр торгууль тавьдаг.

Зарим хотуудад тээврийн нэгдсэн систем үйлчилдэг тул хот дотор зорчих тасалбар нь хотын дагуул дүүрэг, тосгон руу зорчиход хүчинтэй байдаг.

Нийтийн тээврийн нэгдсэн систем нь тээврийн хэрэслийн бүх төрлийг (автобус, галт тэрэг гэх мэт) хооронд нь уялдуулан холбосон чиглэл, маршрутын нэгдмэл тогтолцоог хэлнэ.

Зарим бүлэг хүмүүс нийтийн тээврээр хөнгөлөлттэй зорчдог бөгөөд үүнд хүүхэд, оюутан сурагч, хөгжлийн бэрхштээлтэй иргэд, ахмад настнууд багтдаг. Нийтийн тээврээр хүүхдээ тэргэнд хийгээд түрж яваа эцэг эхчүүд болон өөр бусад зорилтот бүлэг хүмүүс тодорхой хэмжээний хөнгөлөлттэй зорчдог. Нийтийн тээврийн үнэ тарифын хөнгөлөлтийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг тухайн тээврийн компани, нийтийн тээврийн касс, мэдээллийн төвүүдээс авна уу. Хот хоорондын үнэ тарифын тухай мэдээллийг галт тэрэгний болон автобусны буудлаас, амьдарч буй хотынхоо нийтийн тээврийн тухай мэдээллийг тухайн хотын нийтийн тээврийн компаниас авна. Харин хөнгөлөлт эдлэхийн тулд тээврийн компаниас тусгай баримт олгуулах шаардлагатай.

Чех Улсын хот хоорондын нийтийн тээврийн сүлжээ маш шигүү бөгөөд үйлчилгээндээ автобус, галт тэрэг ашигладаг. Нэгдсэн сүлжээний хөдөлгөөний цагийн хуваарийг интернетээс (жишээ нь, www.idos.cz) лавлах мөн зорчих тасалбарыг цахимаар худалдан авч болно. Галт тэрэг, автобусны тухай мэдээллийг тухайн тээврийн компанийн мэдээллийн төв, автобусны буудлын мэдээллийн төвөөс авахаас гадна тасалбар худалдан авч болно. Зарим тохиолдолд таны зорчихоор төлөвлөсөн автобус, галт тэрэгний суудлын захиалгыг урьдчилан хийх шаардлага гардаг.



АВТОМАШИН ЖОЛООДОХ

Чех Улсад жолооны эрхийн үнэмлэхтэй хүн бүр автомашин жолоодох эрхтэй. 18 нас хүрсэн хүн автомашин жолоодох эрхтэй болох ба эмэгтэйчүүд жолоо барих нь түгээмэл.

Чех Улсад замын хөдөлгөөний баруун гарын дүрэм үйлчилдэг.

Жолоо барих эрхтэй гэдгээ жолооны үнэмлэхээр гэрчилнэ. Жолооны үнэмлэхийг жолооны дамжаа амжилттай дүүргэж, шалтгалт өгсний дараа эрх мэдлийн өргөжүүлсэн хүрээ бүхий хот, тосгон, суурин газрын захиргаанаас олгодог. Автомашин барихдаа жолооны үнэмлэх, биеийн байцаалт, тээврийн хэрэгслийн даатгалын “ногоон карт”, тээврийн хэрэгслийн баримт бичгээ ямагт биедээ авч явах ба шаардлагатай үед шалгуулна.

ЕХ-оос бусад улсын иргэн 1 жилээс дээш хугацаагаар удаан хугацааны эсвэл байнга оршин суух зөвшөөрөлтэй тохиолдолд оршин суух зөвшөөрөл нь хүчинтэй болсон өдрөөс эхлэн 3 сарын дотор харьяалагдах хот, тосгон, суурин газрын захиргаанд хандаж нутгаас нь олгосон жолооны үнэмлэхийн үндсэн дээр чех жолооны үнэмлэх олгуулах хүсэлт гаргана. Гэхдээ гадаадын зарим улсад олгосон жолооны үнэмлэхийг үндэслэж чех жолооны үнэмлэхийг шууд олгохгүй болохыг анхаарна уу.

Замын хөдөлгөөний олон улсын хэлэлцээрт (Вена, 1968) заасан нөхцөлд нийцсэн жолооны үнэмлэхийг л солиулах боломжтой. Тухайн улсаас олгосон жолооны үнэмлэхийг солиулах боломжтой эсвэл жолооны шалгалт өгөх шаардлагатай эсэх талаар дэлгэрэнгүй мэдээллийг харьяа хот, тосгон, суурин газрын болон аймгийн захиргаанаас, эс бөгөөс БНЧУ-ын Тээврийн яамнаас лавлах нь зүйтэй.

Тээврийн хэрэгсэл бүрийг харьяа хот, тосгон, суурин газрын захиргааны газрын авто тээврийн хэрэгслийн бүртгэлд заавал бүртгүүлнэ. Тээврийн хэрэгсэл бүрийг жолоочийн хариуцлагын даатгалд (чехээр “rovinné rušení” гэнэ) заавал даатгуулж тээврийн хэрэгслийн техникийн байдлын хяналт үзлэг, яндангийн утааны бохирдлын хэмжилт зэргийг тогтмол хийлгэнэ.

Хот суурин газарт машинаа зориулалтын зогсоолд тавих бөгөөд зогсоол төлбөртэй (төлбөрийг зогсоолын автомат машинаар төлнө). Ихэнх хот, суурин газрууд төвдөө зориулалтын зогсоолын бүс тогтоож тээврийн ачааллыг зохицуулж байна. Ийм бүсэд зөвхөн тухайн орчны оршин суугчид жилийн хураамж төлсний үндсэн дээр машинаа тавих эрхтэй байдаг болохоор машина буруу газар тавьсан гэсэн үндэслэлээр торгууль төлөх, машинаа ачуулахаас урьдчилан сэргийлэх үүднээс машин тавьж болох, болохгүй бүсийг сайтар ялгаж ойлгох нь чухал.



Чех Улсад хурдны авто зам ашиглахын тулд хурдны авто зам ашигласны төлбөр төлдөг.

Чех Улсын нутаг дэвсгэрт тээврийн хэрэгслийн зөвшөөрөгдөх дээд хурд:

хот, суурин газар: 50 км/цаг

бусад зам: 90 км/цаг

хурдны авто зам: 130 км/цаг

Чех Улсын хуулиар автомашин жолоодох үедээ согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хатуу хориглодог.

ШУУДАН, АЛБАН ЗАХИДАЛ

Гадаад улсад болон дотооддоо хүргүүлэх энгийн болон баталгаат захидал, илгээмжийг Чех шуудангаар явуулна.

Албан бичиг ялангуяа төрийн байгууллагад захидал явуулахад хамгийн найдвартай хэлбэр нь **баталгаат захидал** юм. Баталгаат захидлыг Чех шуудангаар зориулалтын маягт бөглөж, батлуулсны дараа явуулах бөгөөд захидал урагдаж гэмтсэн, гээгдсэн тохиолдолд хариуцлагыг Чех шуудан хүлээнэ. Шаардлагатай тохиолдолд

Чех шуудангийн тамга бүхий маягтаар албан байгууллагад захидлыг баталгаатай илгээсэн гэдгээ гэрчилнэ.

Таныг гэртээ эзгүй үед шуудан хүргэгч баталгаат захидал авчирсан тохиолдолд танай шуудангийн хайрцагт мэдэгдэл үлдээнэ. Ийм тохиолдолд харьяа шуудангийн салбараас гадаад паспорт, оршин суух зөвшөөрлийн үнэмлэх зэрэг биеийн байцаалтаа шалгуулж албан захидлаа авна.

Таны нэр дээр ирсэн албан захидлыг зохих ёсоор хүргэх боломжтой болгох үүднээс гадаа хаалганы дэргэд байрлуулсан **хонх, шуудангийн хайрцган** дээр овог нэрээ бичнэ. Та нүүж, оршин суугаа хаягаа өөрчилсөн тохиолдолд энэ тухайгаа Дотоод хэргийн яамны салбар, хэлтэст заасан хугацаанд мэдэгдэх үүрэгтэй.

Чех шуудангийн салбарт (шуудангийн салбараас өөр газарт ч байдаг) Czech Point буюу төрийн үйлчилгээний нэгдсэн цэг ажилладаг. Czech Point нь төрийн байгууллагуудын нэгдсэн мэдээллийн сангаас баталгаажуулсан лавлагаа, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн лавлагаа олгохоос гадна бизнес эрхэлж эхэлсэн, бизнес эрхлэлтэд гарсан өөрчлөлтийн талаар мэдэгдэл хүлээн авах, бичиг баримтын хуулбарыг баталгаажуулах үйлчилгээ үзүүлдэг.

Дэлгэрэнгүй мэдээллийг www.ceskaposta.cz цахим хуудаснаас үзнэ үү.



БУСАД ЧУХАЛ МЭДЭЭЛЭЛ

Хлубока над Влтавоу шилтгээн

ЧЕХ УЛСЫН НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ БАЯРЫН БОЛОН АМРАЛТЫН ӨДРҮҮД

1 дүгээр сарын 1: Шинэ жил, Чех Улс тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдөр

Улаан өндөгний баярын өмнөх Их Баасан гараг (хэлбэлздэг баяр)

Улаан өндөгний баярын Даваа гараг (хэлбэлздэг баяр)

5 дугаар сарын 1: Майн 1-ний хөдөлмөрийн баяр

5 дугаар сарын 8: Ялалтын өдөр

7 дугаар сарын 5: Славын соён гэгээрүүлэгч Кирилл, Мефодий нарын өдөр

7 дугаар сарын 6: Гүн сэтгэгч Ян Хусыг шатаасныг дурсах өдөр

9 дүгээр сарын 28: Чехийн төрт улсын тэмдэглэлт өдөр

10 дугаар сарын 28: Тусгаар тогтносон Чехословак Улсыг тунхагласан өдөр

11 дүгээр сарын 17: Эрх чөлөө, ардчиллын төлөө тэмцсэн тэмдэглэлт өдөр

12 дугаар сарын 24: Зул сарын баярын битүүний өдөр

12 дугаар сарын 25: Зул сарын баярын эхний өдөр

12 дугаар сарын 26: Зул сарын баярын 2 дахь өдөр

УЛАМЖЛАЛ, ЁС ЗАНШИЛ

Христийн шашны Зул сарын баяр, Улаан өндөгний баяртай холбоотой зан үйл, уламжлалд чех хүмүүс өндөр ач холбогдол өгдөг юм. Шашны баяраас гадна бүтэн жилийн туршид зан үйлтэй холбоотой баяр тэмдэглэдэг. Жишээ нь, жил бүрийн 4 сарын 30-нд өвөл дуусч хавар ирснийг билэгдэж эмгэн шулам шатаах, 12 сарын 6-ны өдрийн орой чөтгөр болон сахиусан тэнгэрээ дагуулсан гэгээн Николай хүүхдүүдэд үгэнд орж томоотой байсанд нь чихэр, сахилгагүй нэгэнд нь нүүрс өгдөг заншлыг дагадаггүй айл байхгүй гэж хэлэхэд хилсдэхгүй. Жил бүрийн 6 сарын 1-нд Хүүхдийн баярыг тэмдэглэж олон төрлийн арга хэмжээ, наадам цэнгээн зохион байгуулдаг. 5 сарын 1-ийг Хайрын өдөр хэмээн нэрлэж интоор модны цэцэглэж

буй мөчрийн дор эрэгтэй нь эмэгтэйгээ үнсдэг заншилтай. Харин 11 сарын 2-нд чех хүмүүсийн хувьд онцгой өдөр тохиодог. Учир нь энэ өдөр хүмүүс насан өөд болог-соддоо зул өргөн, газрыг нь эргэж эцэг өвгөдөө дурсан санадаг болохоор “сүнс эргэх өдөр” хэмээн нэрийддэг юм.

ШАШИН ШҮТЛЭГ

Хүний эрхийн түгээмэл тунхалалд хүн бүр шашин шүтэх эрхтэй гэж заадаг. Дийлэнх чех хүмүүс шүтлэггүй ч Чех Улсад христийн шашин хамгийн өргөн дэлгэрсэн бөгөөд чехийн ард түмний уламжилж ирсэн олон зан үйл чухам энэхүү христийн шашнаас үүдэлтэй.

ЧЕХ СОЁЛ УРЛАГИЙН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Дэлхийн өнцөг булан бүрээс Чех Улсыг зорин ирэх жуулчдын нүдийг хужирлах түүх дурсгалын олон сайхан газрууд бий. Жуулчдын сонирхлыг хамгийн ихээр татдаг түүх дурсгалын арван хоёр газрыг ЮНЕСКО-гийн дэлхийн соёлын өвд бүртгүүлжээ.

Соёл урлаг, боловсролын салбарт Карлын Их сургууль, Үндэсний театр, БНЧУ-ын Шинжлэх ухааны академи, Үндэсний музей зэрэг байгууллагууд тэргүүн эгнээнд явдаг юм.

Чех Улсын соёл, урлаг, боловсрол, шинжлэх ухааны салбарт амжилт гаргаж дэлхийд танигдсан хүмүүс олон байдгаас дурдвал хөгжмийн зохиолч Бедржих Сметана, Антонин Дворжак, Леош Яначек, 14-15-р зуунд амьдарч байсан гүн сэтгэгч Ян Хус, 16-17-р зууны үеийн сурган хүмүүжүүлэгч Ян Амос Коменски (зарим улсад Коменциус нэрээр танигдсан), 1918 онд тусгаар тогнолоо зарласан Чехословак Улсын анхны ерөнхийлөгч Томаш Гарик Масарик, Нобелийн уран зохиолын шагналт Ярослав Сайферт, Ярослав Хашек, Франц Кафка, Карел Чапек, Бохумил Храбал, Божена Немцова, Милан Кундера, 1989 оны хилэн хувьсгалын дараа сонгогдсон анхны ерөнхийлөгч Вацлав Хавел нарыг нэрлэж болно.

Нобелийн химийн шагналтан Ярослав Хейровски, харааны контакт линз зохион бүтээгч Отто Вихтерле, ХДХВ/ДОХ-ын эмчилгээнд ашигладаг вирусний эсрэг эм нээгч Антонин Холы нар манай орны нэрд гарсан эрдэмтэд юм.

Уран зураачдын дотроос арт-нуво урсгалын төлөөлөгч Алфонс Муха, хийсвэр (абстракт) урлагийг үндэслэгч Франтишек Купкаг дурдаж болно.

Чех Улсад зохиогддог соёл урлагийн арга хэмжээний талаарх мэдээлэл төрөл бүрийн сонин сэтгүүлд гардаг. Эдгээр арга хэмжээний тухай мэдээллийг Чехийн телевиз, радио зэрэг үндэсний олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээс авах боломжтой.

НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

Чех заншлаар хүмүүс бие биетэйгээ “та”, “чи” хэмээн харьцдаг. Насанд хүрсэн танихгүй хүмүүс, албан ёсны харилцаанд бие биенээ “та” гэж авгайлна. Хэрэв “та” гэж авгайлж байсан хүмүүс бие биенээ “чи” хэмээн дуудах тохиолдолд санаачлагыг эмэгтэй хүн эхэлж гаргана. Цаашилбал ахмад настай хүн эсвэл албан тушаал ахиу нэгэн санаачилж болно. Ийм санаачилга гаргах нь хүмүүсийн хооронд найрсаг харьцаатай байгаагийн илрэл юм. Харин нэг гэр бүлийн гишүүд, найз нөхөд бие биенээ “чи” гэж дууддаг.

Чех хэл ярианы, албан ёсны гэсэн хоёр хувилбартай байдгаараа онцлог. Найз нөхөд хоорондоо ихэвчлэн ярианы хэл хэрэглэдэг бол албаны болон бичгийн харилцаанд албан ёсны хэл ашигладаг. Энэ нь гадаадын хүнд эхэн үедээ төвөгтэй байж магад. Хэрэв та чех хэлийг найз нөхдийнхөө тусламжтай сурсан бол энэ нь ярианы хэл бөгөөд сургууль дээрээ багш нартай эсвэл албаны хүмүүстэй харьцахад шаардлага хангахгүй гэдгийг мэдэхэд илүүдэхгүй байх.

Албан ёсны уулзалт, арга хэмжээ, урилгад заасан цагт нь очих ба ямар нэг өөрчлөлт гарах тохиолдолд урьдчилан мэдэгдэж, уучлалт хүснэ. 15 минутаас илүү хождож очих нь бусдыг үл хүндэтгэсэн бүдүүлэг ёс суртахуунд тооцогддог.

Чех хүмүүс бусадтай харьцахдаа эхэн үедээ биеэ барьсан, хөндий хүйтэн мэт санагддаг тал бий. Ерөөсөө чех хүмүүс танихгүй хүмүүстэй, гадаад байтугай өөр хоорондоо ч зайнаас харьцаж, сэтгэл хөдлөлөө илэрхийлэхгүй байх нь олонтоо. Харин ойртож дотноссон хойноо их өгөөмөр, найрсаг хүмүүс болохыг нь та мэдэх болно. Чех хүн таныг гэртээ уривал энэ нь хоосон маяг эсвэл дүр үзүүлсэн хэрэг огт биш, харин ч найрсаг харилцааны илэрхийлэл юм. Таныг зочилж очно хэмээн хүлээх болно.

Чех хүмүүс чөлөөт цагаараа биеийн тамир, спортоор хичээллэж, спортын уралдаан тэмцээн үзэх дуртай. Нийтээрээ хоккей, хөлбөмбөгийн тэмцээн үзэж дэмждэг болохоор бараг үндэсний спортын хэмжээнд хүрсэн гэхэд болно. Чех хүмүүс дугуй унах, зуны улиралд гол мөрнөөр завиар урсах, уул хад, сонирхолтой газраар аялах, өвлийн цагт цанаар гулгах дуртай. Амралтын өдрүүдээрээ зуслан эсвэл хөдөөний байшиндаа чөлөөт цагаа өнгөрөөнө. Театр, кинотеатрт очихоос гадна ном уншиж, найз нөхөдтэйгээ пивны газар, ресторан, зоогийн газарт уулзах нь элбэг.

АРХИ, ТАМХИ, СОГТУУРУУЛАХ УНДАА ХЭРЭГЛЭХ


Чех Улсад архи, согтууруулах ундаа уух, тамхи татах, өргөн хэрэглээний пиво, дарс хэрэглэхийг хуулиар зөвшөөрдөг. Хэдий тийм боловч зоогийн газар, ресторан, албан газар, сургууль цэцэрлэг, эмнэлэг зэрэг нийтийн үйлчилгээний газрууд, галт тэрэг, автобус зэрэг нийтийн тээврийн хэрэгсэлд тамхи татахыг хориглодог. 18 нас хүрээгүй хүнд тамхи, согтууруулах ундаа худалдахыг хориглоно.

ХОГ ХАЯГДЛЫГ АНГИЛАХ

Сүүлийн жилүүдэд чех хүмүүс гэртээ хог хаягдлаа төрөлжүүлэн ялгаж, өнгөөр ялгасан саванд хаяж хэвшжээ. Ногоон болон цагаан өнгийн саванд шил, цэнхэр өнгийн саванд цаас, шар өнгийн саванд хуванцар эдлэл, бор өнгийн саванд ургамлын гаралтай хог хаягдлыг тус тусд нь ангилан хаяж байна. Үүнээс гадна ундааны сав, тетрапак хайрцаг, металл, хуучин хувцас, гутлыг хүртэл ангилан ялгаж тус тусын зориулалтын саванд хийнэ. Хар өнгийн саванд овор багатай гэр ахуйн ангилаагүй хог хаяна.

Ширээний чийдэн зэрэг том оврын зүйлийг энгийн хогийн саванд хаяхгүй, цахилгаан бараа, будаг, лак, полистирол, металл эдлэл зэрэг овор ихтэй болон аюултай хог хаягдлыг үнэ төлбөргүй цуглуулах цэгт тушаана.

Хог хаягдлаа гудамжинд хаясан хүнд өндөр торгууль ногдуулна.



ХОЛБОО БАРИХ

“Чехийн диваажин” уулан дахь Хруба скала шилтгээн

ОРШИН СУУХТАЙ ХОЛБООТОЙ БҮХ АСУУДАЛ, ОРШИН СУУХ ЭРХИЙН ХУГАЦААГ СУНГУУЛАХ, ӨӨРЧЛӨЛТИЙГ БҮРТГҮҮЛЭХ

БНЧУ-ын Дотоод хэргийн яамны Орогнол, шилжин сууршилтын бодлогын газрын салбар, гадаадын иргэдийн оршин суух асуудал эрхэлсэн хэлтэс
www.mvcr.cz/cizinci — эндээс оршин суух зөвшөөрлийн тухай шаардлагатай бүх мэдээлэл, Дотоод хэргийн яамны бүс нутаг дахь салбар хэлтсийн хаягийг олж авна

Мэдээллийг Дотоод хэргийн яамны лавлах утаснаас авах боломжтой:

(+420) 974 820 680

ОРШИН СУУХ ВИЗ, ЗӨВШӨӨРЛИЙН ХЯНАЛТ, УРИЛГА БАТАЛГААЖУУЛАЛТ, ТУС УЛСАД ХҮРЭЛЦЭН ИРСНИЙ ДАРААХ БҮРТГЭЛ

Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн цагдаагийн алба
www.policie.cz/clanek/informace-pro-pobyt-cizincu.aspx

ҮНЭГҮЙ МЭДЭЭЛЭЛ, ЗӨВЛӨГӨӨ

Танд зөвлөгөө, тусламж хэрэгтэй бол гадаадын иргэдэд туслалцаа үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус ашгийн бус байгууллага (ТББ) эсвэл интеграцчилалын төвүүдэд (бүтэн нэрээр Интеграцчилалыг дэмжих төв гэж нэрлэдэг) хандах нь зүйтэй. Эдгээр байгууллага нь Чех Улсад ажиллаж амьдрах аливаа асуудлаар мэдээлэл, зөвлөгөө өгөхөөс гадна хууль зүйн туслалцаа үзүүлэх, чех хэлний сургалт явуулах, орчуулга хийх зэрэг үйлчилгээ үзүүлдэг юм. Ажилтнууд нь мэргэжлийн туслалцаа үзүүлэх хэмжээнд тусгайлан мэргэшсэн байдаг ба үнэн зөв, шинэ мэдээллээр тогтмол хангагддаг болно. ТББ, интеграцчилалын төвүүдийн үйлчилгээ үнэ төлбөргүй байдаг ч чех хэлний зарим дамжаа төлбөртэй.

Чех Улсад ирсэн эхэн үедээ шинэ орчинд дасахад дөхөм болох үүднээс эдгээр байгууллагаас зохион явуулдаг соёлын арга хэмжээнд оролцоход илүүдэхгүй биз ээ.

ИНТЕГРАЦИЛАЛЫН ТӨВҮҮД (ГАДААДЫН ИРГЭДИЙН ИНТЕГРАЦИЛАЛЫГ ДЭМЖИХ ТӨВҮҮД)

Чех Улсын аймаг бүрт интеграцчилалын төвүүд ажилладаг бөгөөд ямар албан газарт хандаж асуудлаа шийдүүлэх, хаана чех хэл сурах, амьдралд тохиолдох элдэв асуудлаа хэрхэн яаж зохицуулах талаар зөвлөгөө өгдөг. Үүнээс гадна таныг ямар нэгэн гэрээнд гарын үсэг зурахаас өмнө уг гэрээг сайтар нягтлах, орчуулагч, хэлмэрч олоход тусална. Интеграцчилалын төвийн байрнууд үнэгүй ашигладаг интернетэд холбогдсон байдаг.

Эдгээр төвүүдийн ихэнх үйлчилгээ үнэ төлбөргүй байдаг ч зарим нэг үйлчилгээ нь төлбөртэй. Үйлчилгээ авах нөхцөл болзлыг интеграцчилалын төвийн ажилтнууд танд заавал урьдчилан танилцуулна. Санал болгож буй үйлчилгээний талаар дэлгэрэнгүй мэдээллийг интеграцчилалын төвүүдийн цахим хуудаснаас үзнэ үү.

Интеграцчилалын төвийн хаяг, утас зэрэг мэдээллийг www.integracnicentra.cz цахим хуудаснаас үзнэ үү.

Прага хотын интеграцчилалын төв/“ИЦП” (Integrační centrum Praha/ICP)

Žitná 1574 / 51, 110 00 Praha 1

Утас: +420 252 543 846

Arbesovo náměstí 70/4, 150 00 Praha 5

Утас: +420 253 253 984

И-мэйл: info@icpraha.com

www.icpraha.com

“ИЦП” (ICP) нь Прага 1, 13, 14 дүүргүүдэд салбараа ажилуулдаг.

“ИЦП” (ICP) нь Нийслэл Прага хотын захиргааны харьяа байгууллага бөгөөд интеграцчилал, Прага хотын өдөр тутмын амьдралын мэдээллийг “Praguer” аппликейшн, нийслэл Прага хотын www.metropolevsech.eu цахим хуудаснаас үзэх боломжтой.

Гадаадын иргэдийн интеграцчилалыг дэмжих төв – Чехийн төв аймаг (Centrum na podporu integrace cizinců – Středočeský kraj)

Млада Болеслав хот дахь салбар

tř. Václava Klementa 467

293 01 Mladá Boleslav

Утас: 420 311 584 406

И-мэйл: icmladaboleslav@suz.cz

Кладно хот дахь салбар

Cyrila Boudy 1444
272 01 Kladno – Krocehlavy
Утас: +420 325 630 546
И-мэйл: ickladno@suz.cz

Бенешов хот дахь салбар

Žižkova 360
256 01 Benešov
Утас: +420 326 905 279
И-мэйл: icbenesov@suz.cz

Пржибрам хот дахь салбар

U nemocnice 85
261 01 Přebram I.
Утас: +420 326 905 249
И-мэйл: icpribram@suz.cz

Кутна Хора дахь салбар

Hornická 642
284 01 Kutná Hora
Утас: +420 326 905 408
И-мэйл: ickutnahora@suz.cz

Гадаадын иргэдийн интеграцилалыг дэмжих төв – Өмнөд чех аймаг (Centrum na podporu integrace cizinců – Jihočeský kraj)

Kněžskodvorská 2296
370 04 České Budějovice
– “Ческа Споржителна”-ийн байрны ар хэсэг, Пражска гудамжтай зэрэгцээ гудамж,
(монголоор) 2 давхар
Утас: + 420 387 202 508
И-мэйл: icceskebudejovice@suz.cz

Гадаадын иргэдийн интеграцилалыг дэмжих төв – Высочина аймаг (Centrum na podporu integrace cizinců – Vysočina)

Tolstého 15
586 01 Jihlava
Утас: +420 567 212 256, +420 778 401 506
И-мэйл: icjihlava@suz.cz

**Гадаадын иргэдийн интеграцчилалыг дэмжих төв – Карловы Вары аймаг
(Centrum na podporu integrace cizinců – Karlovarský kraj)**

Závodu Míru 876/3a

360 17 Karlovy Vary

– (монголоор) 2 давхар

Утас: +420 353 892 559

И-мэйл: ickarlovyvary@suz.cz

Гадаадын иргэдийн интеграцчилалыг дэмжих төв – Либерец аймаг (Centrum na podporu integrace cizinců – Liberecký kraj)

Voroněžská 144/20

460 10 Liberec

Утас: +420 482 313 064

И-мэйл: icliberec@suz.cz

**Гадаадын иргэдийн интеграцчилалыг дэмжих төв – Моравскослезски аймаг
(Centrum na podporu integrace cizinců – Moravskoslezský kraj)**

Českokobratrská 2227/7

702 00 Ostrava

ICQ: (600-235-100); Skype: (cpic_ostrava)

Утас: +420 596 112 626, +420 607 860 812

И-мэйл: icostrava@suz.cz

Гадаадын иргэдийн интеграцчилалыг дэмжих төв – Оломоуц аймаг (Centrum na podporu integrace cizinců – Olomoucký kraj)

Hálkova 171/2

779 00 Olomouc

Утас: +420 585 204 686, +420 608 119 971

И-мэйл: icolomouc@suz.cz

Гадаадын иргэдийн интеграцчилалыг дэмжих төв – Пардубице аймаг (Centrum na podporu integrace cizinců – Pardubický kraj)

Pernerova 444

530 02 Pardubice

Утас: +420 466 989 228, +420 725 148 519

И-мэйл: icpardubice@suz.cz

Гадаадын иргэдийн интеграцчилалыг дэмжих төв – Пльзень аймаг (Centrum na podporu integrace cizinců – Plzeňský kraj)

Americká 39

301 00 Plzeň

Утас: +420 725 874 976, +420 377 223 157

И-мэйл: icplzen@suz.cz

Гадаадын иргэдийн интеграцчилалыг дэмжих төв – Злин аймаг (Centrum na podporu integrace cizinců – Zlínský kraj)

Štefánikova 167

760 01 Zlín

Утас: +420 577 018 651

И-мэйл: iczlin@suz.cz

Гадаадын иргэдэд үйлчлэх төв – Өмнөд моравын аймаг (Centrum pro cizince Jihomoravský kraj)

www.cizincijmk.cz

Kounicova 271/13 (доод давхар)

602 00 Brno

Утас: +420 734 510 213

И-мэйл: info@cizincijmk.cz

Усти аймаг дахь гуравдагч орны иргэдийн интеграцчилалыг дэмжих төв (Centrum na podporu integrace státních příslušníků třetích zemí v Ústeckém kraji)

www.centrumcizincu.cz

Velká Hradební 33

400 21 Ústí nad Labem

Утас: +420 475 216 536 Sběrka zákonů

И-мэйл: usti@centrumcizincu.cz

Храдец Кралове дахь Гадаадын иргэдийн интеграцчилалын төв (Integrační centrum pro cizince Hradec Králové)

www.cizincihradec.cz

Šafaříkova ul. 666/9 (ҮМСА-гийн байр, монголоор 4 давхар)

500 02 Hradec Králové

Утас: +420 492 604 940

И-мэйл: poradna.cizinci@hk.caritas.cz

ТӨРИЙН БУС АШГИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД (ТББ)

www.cizinci.cz цахим хуудасны Холбоо барих хэсгээс бүх байгууллагуудын хаяг, утасны дугаарыг авах боломжтой.

Дараах хэсэгт зөвхөн зарим нэг ТББ-ын талаарх мэдээллийг сонгон оруулсан болно. Эдгээр байгууллагууд нь Чех Улсын нутаг дэвсгэр дээр оршиж байгаа хэнд ч болов утсаар зөвлөгөө өгөх үйлчилгээг ямар нэг хязгаарлалтгүй үзүүлдэг бөгөөд биечлэн очиж уулзах тохиолдолд тухайн бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй ТББ-тай урьдчилж тохирсны үндсэн дээр очих нь зүйтэй.

- **Дүрвэгсдэд туслах байгууллага – “ОПУ”** (Organizace pro pomoc uprchlíkům – OPU) (Прага, Брно, Храдец Кралове, Плзень, Острава зэрэг хотод ажилладаг) – хууль зүйн болон нийгмийн асуудлаар зөвлөх үйлчилгээ үзүүлдэг – www.opu.cz, утас: +420 730 158 779, 739 413 983, 730 158 781 (хууль зүйн зөвлөх үйлчилгээ), и-мэйл: opu@opu.cz
- **Интеграцилалын асуудлаарх зөвлөх үйлчилгээний төв – “ППИ”** (Poradna pro integraci – PPI) (Прага, Усти над Лабем зэрэг хотод ажилладаг) – хууль зүйн болон нийгмийн асуудлаар зөвлөх үйлчилгээ үзүүлдэг – www.p-p-i.cz, утас: +420 603 281 269 (Прага хот), и-мэйл: paha@p-p-i.cz, утас: +420 475 216 536 (Усти над Лабем хот), и-мэйл: usti@p-p-i.cz
- **Шилжин сууршилтын олон улсын байгууллага – “АЙОМ”** (International Organization for Migration/Mezinárodní organizace pro migraci – IOM) (Прага хот) – зөвлөх үйлчилгээ, хөдөлмөрийн шилжин сууршилт, сайн дураар нутаг буцах хөтөлбөр – www.iom.cz, утас: +420 233 37 01 60, и-мэйл: prague@iom.int
- **Гадаадын иргэдийн интеграцилалын төв – “ЦИЦ”** (Centrum pro integraci cizinců – CIC) (Прага хот) – хөдөлмөр, нийгмийн асуудлаар зөвлөх үйлчилгээ үзүүлдэг – www.cicpraha.org, утас: +420 222 360 452 (нийгмийн асуудлаар), +420 702 150 630 (хөдөлмөрийн асуудлаар), и-мэйл: info@cicpraha.org
- **Интеграцилал, шилжин сууршилтын нийгэмлэг – “СИМИ”** (Sdružení pro integraci a migraci – SIMI) (Прага хот) – хууль зүйн болон нийгмийн асуудлаар зөвлөх үйлчилгээ үзүүлдэг – www.migrace.com, утас: +420 224 224 379, +420 603 547 450 (хууль зүйн асуудлаар), +420 605 253 994 (нийгмийн асуудлаар), и-мэйл: poradna@refug.cz

- **ИнБазе (InBáze, z.s.)** (Прага хот) – хууль зүй, нийгмийн, хөдөлмөрийн болон сэтгэлзүйн асуудлаар зөвлөх үйлчилгээ үзүүлдэг – www.inbaze.cz, утас: +420 739 037 353, и-мэйл: info@inbaze.cz
- **Чех Улсын Харита/Каритас Чех (Charita ČR)** – гэнэтийн хүндрэлд өртсөн гадаадын иргэдэд туслалцаа үзүүлдэг – www.charita.cz. Утас: **монгол хэлээр** +420 733 67 66 67, **украин хэлээр** +420 731 432 431, **вьетнам хэлээр** +420 605 99 99 69, www.charita.cz/infolinka. Чех Улсын Харита улс даяар салбар хэлтэс ажиллуулдаг.
- **Прага хотын Арцидиецезийн Харита – Шилжин сууршилтын төв** (Arcidiecézní Charita Praha – Středisko Migrace) – хууль зүй, нийгмийн асуудлаар зөвлөх үйлчилгээ үзүүлж, гэнэтийн хүндрэлд өртсөн иргэдийг богино хугацаагаар хоноглуулах, хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хүмүүст туслалцаа үзүүлдэг – www.praha.charita.cz/sluzby/migrace, утас: +420 224 813 418, и-мэйл: migrace@praha.charita.cz
- **Европын харилцах баг (Evropská kontaktní skupina)** (Прага хот) – хөдөлмөрийн болон ажлын карьерын асуудлаар зөвлөх үйлчилгээ үзүүлдэг – www.ekscr.cz, утас: +420 222 211 799
- **“МОСТ ПРО” (MOST PRO)** (Пардубице хот) – нийгмийн асуудлаар зөвлөх үйлчилгээ үзүүлдэг – www.mostlp.eu, утас: +420 467 771 170, и-мэйл: info@mostlp.eu
- **Цагаачдын асуудал эрхэлсэн иргэдийн нийгэмлэг – “СОЗЕ”** (Sdružení občanů zabývajících se emigranty – SOZE) – хууль зүй болон нийгмийн асуудлаар зөвлөх үйлчилгээ үзүүлдэг – www.soze.cz

SOZE Brno – Утас: +420 545 213 643, и-мэйл: soze@soze.cz,

SOZE Olomouc – Утас: +420 585 242 535, и-мэйл: soze.olomouc@soze.cz

ТӨРӨЛЖСӨН ЧИГЛЭЛИЙН ТӨРИЙН БУС АШГИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД:

Боловсрол, мэргэжлээрээ ажил олох, гадаадад эзэмшсэн боловсролын бичиг баримтыг дүйцүүлэн хүлээн зөвшөөрүүлэх асуудлаар зөвлөх үйлчилгээ үзүүлдэг ТББ-ууд

“МЕТА” олон нийтийн төлөөх компани (META, o. p. s.) – www.meta-ops.cz,
утас: +420 775 339 003, и-мэйл: poradenstvi@meta-ops.cz

Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирогчдод туслалцаа үзүүлдэг ТББ-ууд

Чех Улсын Ла Страда (La Strada Česká republika) – www.strada.cz – албадан ажил хийлгэх, бэлгийн мөлжлөгт өртсөн зэрэг хүн худалдаалах, бусдын мөлжлөгт өртсөн хохирогчдод тусламж үзүүлдэг, яаралтай дуудлагын SOS утас: +420 222 71 71 71, Лавлах утас: +420 800 077 777

Прагийн Архиепископын Харита – Магдала төсөл (Arcidiecézní Charita Praha – Projekt Magdala) – www.praha.charita.cz – албадан ажил хийлгэх, бэлгийн мөлжлөг зэрэг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод зөвлөх үйлчилгээ, туслалцаа үзүүлдэг
утас: +420 251 552 790, и-мэйл: magdala@praha.charita.cz

Гэр бүлийн хүчирхийлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ууд

www.domacinasili.cz – хүндрэлд өртөгсдөд яаралтай тусламж үзүүлэх бүс нутаг дахь төвүүдийн талаарх мэдээлэл

“Аюулгүй байдлын цагаан хүрээ” (Bílý kruh bezpečí)

Гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлдэг
Утас: 116 006 (24 ЦАГИЙН АЖИЛЛАГААТАЙ)
www.bkb.cz

“РОЗА” (ROSA)

Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй хүмүүст туслалцаа үзүүлдэг
Утас: +420 602 246 102, и-мэйл: info@rosa-os.cz
www.rosa-os.cz

“АКОРУС” (ACORUS)

Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй хүмүүст туслалцаа үзүүлдэг
Утас: +420 283 892 772 (24 ЦАГИЙН АЖИЛЛАГААТАЙ)



**ДАСАН ЗОХИЦОХ
ИНТЕГРАЦИЛАЛЫН ДАМЖАА**

Чех Улсад тавтай морилно уу



MINISTERSTVO VNITRA
ČESKÉ REPUBLIKY

